



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2026 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН**

*2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР**

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 09 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

|                                          |      |
|------------------------------------------|------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>   | 1    |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | 2-4  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | 5-73 |

---

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |      |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| 1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 5-73 |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы  
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны  
09 дүгээр сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ганбаатар, С.Зулпхар, Д.Рэгдэл, Б.Түвшин, М.Энхцэцэг;  
Чөлөөтэй: Б.Бейсен, Х.Болормаа;  
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Мөнхсайхан.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Энхбаяр, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Анар, мөн банкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Мөнгөний бодлого, судалгааны газрын Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал Б.Цэнд-Аюуш, Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх удитор Н.Цэвэлмаа, мөн газрын менежер С.Нацагдорж, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын мэргэжилтэн Р.Хангал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн шинжээч Б.Очиртогтох, ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга

А.Даваажаргал, мөн яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Энхтөр, Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Янжмаа, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Эдийн засаг, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга Б.Батхуяг, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Тусламж, үйлчилгээний багц хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгор, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга М.Мөнх-Оргил, мөн газрын ахлах шинжээч Э.Адъяасүрэн, ахлах мэргэжилтэн Б.Түмэнбаяр, Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Л.Ганбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, мөн яамны Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Стратеги, бизнес хөгжлийн газрын дарга Б.Мэндбаяр, мөн компанийн Санхүүгийн бодлогын газрын дарга Ц.Зоригтбат, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн Захиргаа, удирдлагын газрын дарга Т.Билгээ, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Бадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат, Д.Ганмаа, П.Наранбаяр, Ц.Мөнхтуяа, Ж.Галбаяр, Б.Хэрлэн, Ж.Чинбүрэн, М.Ганхүлэг, Н.Алтаншагай, Ц.Баатархүү, Г.Хосбаяр, О.Саранчулуун, Ж.Баясгалан, О.Батнайрамдал, Д.Бум-Очир, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 4 цаг 15 минут үргэлжилж, 30 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дугаар сарын 09-ний өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 12 цаг 15 минут

### ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**П.Ганзориг:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Намрын ээлжит бус чуулган эхэлсэнтэй холбогдуулан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны анхны хуралдаан өнөөдөр эхэлж байна. Манай Байнгын хороо нийт 30 Улсын Их Хурлын гишүүнтэй. Хурал болгон дээр цагтаа ирж, ирц бүрдүүлж, хуралдаа идэвхтэй оролцож байгаа нийт гишүүддээ талархлаа илэрхийлье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралд ирвэл зохих 30 гишүүнээс 19 гишүүн ирж, 63.3 хувийн ирцтэй байгаа тул Байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

. Түүнийгээ тогтоож энэ халамжийн зардлууд, үйлчилгээнүүдээ цэгцлэх хэрэгтэй Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай, Аюушийн Ариунзаяа, Цэндийн Баатархүү, Жадамбаагийн Баясгалан, Дуламын Бум-Очир, Шинэбаярын Бямбасүрэн, Жанчивын Галбадрах, Пүрэвжавын Ганзориг, Даваасамбуугийн Ганмаа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Бадарчийн Хэрлэн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Лутаагийн Энхнасан, Дорзовдын Энхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын 19 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

**1.Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. /Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг Танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлэх/**

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Э.Батшугар Эрүүл мэндийн сайд, М.Санжаадорж Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Т.Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Н.Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга.

Монгол банкнаас: Э.Анар Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч, П.Мөнхбаяр Санхүүгийн зах зээл, валютын газрын захирал, Б.Цэнд-Аюуш Мөнгөний бодлого, судалгааны газрын Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс: Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Н.Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн.

Үндэсний аудитын газраас: З.Цэнджав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Н.Цэвэлмаа Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Б.Баттуяа Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, С.Нацагдорж Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, М.Наранжаргал Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас: Б.Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга.

Сангийн яамнаас: Х.Ганцогт Сангийн сайдын зөвлөх, Ч.Чимэдсүрэн Татварын бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Ичинноров Санхүү төсвийн судалгааны газрын дарга, П.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Г.Гантулга Төсвийн орлогын хэлтсийн дарга, Л.Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Очиртогтох Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Б.Дэнсмаа Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Р.Хангал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, О.Гантулга Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Боловсролын яамнаас: Мөнх-Оргил Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Ганбат Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга, Б.Түмэнбаяр Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Э.Адьяасүрэн Эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын ахлах шинжээч.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам: Ж.Энхтөр Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Л.Ариунзаяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын дэд дарга, З.Бауржан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, мөн 3 газрын дарга ирсэн юм байна. Б.Алимаа, Ю.Отгонбилиг, Д.Мөнгөнтуул.

Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамнаас: Б.Урьболд Бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Ц.Ариунсанаа Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Батхуяг Соёл урлагийн газрын дарга, Э.Билигт Биеийн тамир, спортын улсын хорооны дарга.

Эрүүл мэндийн яамнаас: Л.Мөнхцэцэг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Д.Отгонбаатар Эрүүл мэндийн даатгалын Бодлого зохицуулалтын газрын дарга, Б.Янжмаа Бодлого төлөвлөлтийн газрын дарга, М.Наранпүрэв Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Б.Цэцэгсайхан Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Н.Хүрэлбаатар Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас: Ц.Батбаатар газрын дарга, Б.Батхуяг Эдийн засаг, төлөвлөлт судалгааны хэлтсийн дарга, Б.Ууганбаяр Тусламж үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга, Ч.Гантөмөр Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Б.Янжиндолгор Тусламж үйлчилгээний багц хариуцсан ахлах мэргэжилтэн.

Чингис хаан Баялгийн сан нэгдэл ХХК-аас: Б.Мэндбаяр Стратеги бизнес хөгжлийн газрын захирал дарга, Ц.Зоригтбат Санхүү бодлогын газрын дарга.

ЭТТ компаниас: Т.Билигээ Захиргаа удирдлагын газрын дарга, Г.Бадрах Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхийн асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ гэж заасан.

Танилцуулга явахгүй шууд асуулт, хариулттай юм байна. Асуулт, үг тусдаа юм байна шүү. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Лутаагийн Энхнасан гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

**А.Ариунзаяа:** Сайн байцгаана уу. Товч асуултууд асууя. Боловсролын салбарын дутагдсан цалингийн зардал 674.5 тэрбум төгрөг. Энэ одоо авч байгаа цалинг нь хөдөлгөхгүй байгаа, одоогийн цалинг нь олгоод явахад он дуустал шаардагдах төсөв гэж ойлгож байгаа зөв биз дээ. Төсөв тодотгол хийхгүй буцаах юм бол боловсролын салбар цалин хөлсөө тавьж чадахгүйд хүрэх нь гэж ойлгоод байна зөв үү гэдгийг тодруулъя.

Хоёр дахь нь, эрүүл мэндийн салбарын цалинг 20 хувь нэмэгдүүлэхэд 90 тэрбум төгрөг. Яг эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын нийт цалин хөлсний зардал хэд байгаа вэ. Хэчнээн төгрөгийн ачааллыг Эрүүл мэндийн даатгалын сан төрийн өмнөөс үүрээд байна вэ.

Гурав дахь асуулт, Соёл, спорт бусад төрийн үйлчилгээний салбарын цалинг 11 сараас 50 хувь нэмэгдүүлэх гээд байна. 80 тэрбум төгрөг. Миний хүүхэд хаан, чиний хүүхэд заан хөөрхий манай нөгөө захиргааныхан яачхав. Энэ 80 тэрбум төгрөгийг нийт төрийн албан хаагчиддаа буюу цалин нэмэгдээгүй үлдсэн байгаа. Өчнөөн олон жил ингээд чимээгүй ажлаа хийж байгаа энэ албан хаагчдынхаа цалинг нь нэмэгдүүлбэл нийт энэ үлдсэн байгаа албан хаагчдыгаа хэдэн хувиар нэмэгдүүлэх боломж байна вэ буюу миний асуугаад байгаа нь энэ 80 тэрбум төгрөгийг шударгаар хуваарилсан бол ядаж 10, 10 хувь хэд байдаг юм. Ийм боломж гарч ирж болохгүй байсан уу гэдэг ийм асуулт.

**П.Ганзориг:** Боловсролын яамнаас эхлээд хариулаад явъя. 9 номерын микрофон Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ням-Очир хариулъя. Дараа нь Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга төсөвтэй холбоотой асуулт учраас хариулах нь зөв байх. 9 номерын микрофоныг нээе.

**Т.Ням-Очир:** Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ням-Очир. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны төрийн үйлчилгээний зарим хүн албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 151 дүгээр тогтоол батлагдсан. Энүүгээр төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн багш, ажилтны албан тушаалын цалинг 50 хувиар нэмэгдүүлээд, нэмэгдлийг энэ нэмэгдсэн 50 хувиас бодож олгохоор ийм шийдвэр гарсан. Энэ нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулж ирж байгаа. Энэ 674.9 тэрбум төгрөг, энэ 50 хувь нэмэгдсэн цалингаас нэмэгдлийг тооцож олгоод, дутагдаж байгаа эх үүсвэрийг нөхөж байгаа ийм эх үүсвэр гэж ойлгож болно.

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье. Нэмж хариулъя. Гүйцээж хариулах уу, болчихсон уу. Сангийн яам хариулах хэрэгтэй байх. Саяын боловсрол дээр бол Ариунзаяа гишүүн ингэж асуугаад байна шүү дээ. 5 сарын 1-нд цалингийн зөрүү арилгана гээд боловсролын салбар дээр цалингуудаа нэмээд шийдвэрлээд явчихсан Засгийн газраас. Гэтэл Улсын Их Хуралд хэрвээ энэ тодотгол батлагдахгүй боллоо гэхэд Улсын Их Хурлаар боловсролын салбар цалингүй болчих гээд байна уу? Энэ дээр нэг тодорхой хариулаач гэж байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, 4 номер. Санжаадорж хариулъя.

**М.Санжаадорж:** Сангийн яам. Санжаадорж. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Тийм, боловсролын салбар дээр тодотгол батлагдсанаар ийм хэмжээний цалингийн сан дутагдаж байгаа. Энэ нь дахиж цалин нэмэх асуудал биш. Боловсролын салбар дээр багш, ажилчдын цалинг нэмсэнтэй холбоотойгоор ийм зөрүү гарч байгаа.

Хоёрдугаар асуудал, эрүүл мэндийн салбар. Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулж бүх эмнэлгүүд санхүүжилтээ авч байгаа. Энэ даатгалын сангийн пропорцоор хэлэх юм бол 50 хувь нь шимтгэлийн орлогоос, 50 хувь нь улсын төсвөөс байгаа. Өөрөөр хэлбэл, шимтгэл төлөгч иргэд өөрсдийнхөө мөнгөнөөсөө энэ цалингийн нэмэгдлийг угаасаа хуваалцах ёстой. Энэ дагуу бол төр хариуцах хэсгийнхээ пропорцыг энэ удаад нэмж байгаа. Үүн дээр нэмээд дутагдалтай хэсгийн зарлагын эх үүсвэрийг гаргаж өгч байгаа ийм зүйл байгаа юм. Даатгалын санхүүжилт маань өөрөө тухайн иргэн санхүүгийн эрсдэлд орох юм бол тухайн эмнэлгийн цалин эмчилгээний хөлс бүгд.

**П.Ганзориг:** 6 номерын микрофон, ЭМЯ-аас Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр хариулъя.

**Н.Эрдэнэбаяр:** Ариунзаяа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Эрүүл мэндийн салбарт 67300 гаруй эмч, эмнэлгийн ажиллагсад байгаа. Үүний 33741 ажилтан нь ТА3-ийн системээр цалин авч байгаа. Энд 2026 онд 1 сарын 1-ээс 30 хувь, 11 сарын 1-ээс 20 хувь ингээд нэмэхэд төсөв дээр 342.4 тэрбум төгрөгийн ийм нөлөөлөл үүсэж байгаа. Үүний 185 тэрбумыг улсын төсвөөс ингэж тусгаж өгсөн байгаа. Тодотгол дээр 91.7 тэрбум төгрөг ингэж орохоор байгаа. Үлдэгдэл 65.3

тэрбум төгрөгийг дотоод зохион байгуулалтаа сайжруулах, тусламж үйлчилгээний дахин хуваарилалтыг хийх, шатлалын зөв бодлогыг оруулж ирэх, шаардлагагүй зардлуудыг хэмнэх гэдэг байдлаар ингэж зохицуулалтууд хийж энэ цалингийн нэмэгдлүүд явж байгаа.

**П.Ганзориг:** 4 номер нэмж хариулъя. Санжаадорж.

**М.Санжаадорж:** Одоо тодотголоор бол төрийн үйлчилгээний албан хаагчдаас ингээд эрүүл мэндийн салбарын нийт эмч, ажилчид, боловсролын салбарын багш, ажилчид бүгдээрээ цалин нь бол ингээд 50 хувь дээр буюу жигдрээд оччихож байгаа юм. Тэгэнгүүт соёл, биеийн тамир, цаг уур гээд бусад ТҮ-ийн салбарынхан маань бол энэ жилийн 1 сарын 1-ээс огт нэмэгдэлгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ хэсгийг бол бид нар 50 хувь нэмэхээр тооцооллыг оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл, саяын хэлсэн 2 салбараас бусад байгууллагын бүх төрийн үйлчилгээний албан хаагчид, галч, манаач, цэвэрлэгч, бүх үйлчилгээний албан хаагчдын цалин 50 хувиар нэмэгдэх юм. Ингэснээр энэ жилийн зорилго Засгийн газрын хувьд бол төрийн үйлчилгээний нийт албан хаагчдаа ингээд 50 хувийн нэмэгдэлтэй болгоод ямар ч байсан жигдрүүлээд авчих асуудал байгаад байгаа юм. Дараагийн ээлжид болохлоор ирэх жилийн төсвийг бид өргөн барьсан байгаа. Тэн дээр бол инфляцын нөлөөллөө хараад 2 дугаар улирлаас эхлээд цалин нэмэх бодлогын асуудал орж ирж байгаа.

**П.Ганзориг:** Ариунзаяа гишүүн тодруулаад асуучихъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Даваажаргал. Төрийн нарийн бичгийн даргыг дуудъя. Сайд нь хүртэл сая энд явж байсан шүү дээ. Тэгээд төсвийн асуудлыг нь холбогдох Байнгын хороогоор оруулаад мэргэжлийн хүмүүс байр сууриа хэлээд ингээд явуулах гэж байхад нь Төрийн нарийн бичгийн дарга байхгүй байгаад байна уу. Ариунзаяа гишүүн тодруулаад асууж байя. Дараа нь Төрийн нарийн бичгийн дарга гүйцээж хариулаарай.

**А.Ариунзаяа:** Төсөв нь батлагдаагүй байхад хэн дур мэдэн цалин нэмж олгочхов оо. Энэ чинь төсвийнхөө дагуу л цалин хөлс бусад асуудлуудаа явуулдаггүй юм уу. Тэгээд улс төрийн энэ амлалтаас болоод байхгүй байгаа төсвийг урьдчилж өгцгөөгөөд, тэгээд төсвийн тодотголоо хийхгүй бол боловсролын салбар цалингаа тавьж чадахгүй нь байна шүү дээ. Тэгээд энэ шийдвэрийг гаргасан хүн энд байхгүй л дээ. Гэхдээ ийм асуудал ер нь энэ Монголын төрд байж болдог юм уу, яасан дураараа юм. Юуны тулд бид нар төсөв батлаад байдаг юм, зориулалтынхаа дагуу л зарцуулах ёстой биз дээ. Тэгж байгаад ямар ч байсан өгөөд явчихъя, тэгээд намар тэгээд тодотголоо хийгээд болгоно биз гэж хандаж болдог юм уу. Цалин хөлсний нэгдсэн бодлого яв, Хөдөлмөрийн яам яваа.

**П.Ганзориг:** Ариунзаяа гишүүнд нэг минут нэмж өгье.

**А.Ариунзаяа:** Хөдөлмөрийн яамныхан байхгүй байна. Цалин хөлсний нэгдсэн бодлогыг хэн гаргах ёстой юм. Үүнийгээ баз л даа. Энэ асуудлыг хариуцахын тулд сайдаар ажиллаж байгаа хүмүүс байгаа биз дээ, үгүй юм уу? Сангийн яам энэ Мэргэжлийн яамны саналыг нь сонсдоггүй юм уу. Ерөнхий сайд нь сонсдоггүй юм уу. Тэгвэл энэ Хөдөлмөрийн яамаа татан буулга. Яах гэж Хөдөлмөрийн яам байдаг юм. Энэ 80 тэрбум төгрөгийг жигд үлдсэн байгаа хүмүүстээ хуваах юм бол хэдэн хувиар нэмэгдүүлж болох вэ гэдэг тооцооллыг хийгээрэй. Чуулган дээр асууна, зарчмын зөрөөтэй саналыг гаргана. Ингэж өм цөм

нэмэгдүүлээд аль нэгийг нь орхигдуулаад байж болохгүй биз дээ. Хэзээ ийм байсан юм. Монголын төр хүүхдүүдээ хүртэл алаг үздэггүй биз дээ, миний санал бол ийм л байна. Нэгдсэн бодлогоо гарга. Яагаад заавал нэгийг нь гомдоож, нөгөөдхийг нь ингэж энхрийлэх ёстой юм. Зөв үү, буруу юу энэ дээр бодоод үзээрэй, тооцооллуудаа хийгээрэй.

**П.Ганзориг:** Асуулт асуух гишүүд дээр Баясгалан гишүүн, Саранчулуун гишүүн, Батнайрамдал гишүүн нарыг нэмээд, тэгээд асуулт асуух гишүүдийг хааж байна, дахин нэр авч нэмэхгүй. Дараагийн асуулт асуух гишүүн Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя.

**Л.Энхнасан:** Өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн төсвийн тодотголыг зөвхөн тоо орлого, зардлын зөрөөг харах нь учир дутагдалтай гэж бодож байна. Яагаад гэвэл, энэ төсвийн тодотголын хамгийн гол зорилго нь эдийн засгийн хүндрэлийг инфляцын дарамтаас иргэдийг хамгаалах, энэ нийгмийн суурь үйлчилгээг тасалдахгүй байхыг илүү бий болгож байгаа гэж харж байгаа. Тэгэхлээр өнөөдрийн энэ төсвийн хүндрэл гэнэт бий болоогүй. Бид нар өөрсдөө төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсаны дараа цалин тэтгэвэр, нийгмийн даатгал, энэ татварын олон өөрчлөлтийг бий болгосон. Тэгээд энэ нь төсөвт нэмэлт дарамт бий болгосон. Харин энэ тодотголыг яагаад хавар оруулж болоогүй юм. Тиймээс өнөөдрийн нөхцөлд хэн нэгнийг буруутгахаас илүүтэйгээр илүү гаргасан энэ улс төрийнхөө шийдвэрүүдийг бодитойгоор тооцоод, энэ хуулиа хэрэгжүүлэх тал дээр илүү анхаарах хэрэгтэй байна. Энэ дээр тэгээд хэн нэгнийг буруутгаад, хоорондоо маргалдаад ингээд гүтгэж болохгүй гэж бодож байна. Энд асуумаар байгаа асуудал бол эмийн салбарын зардлыг зөв эрэмбэлэх хэрэгтэй байна. Энэ эмийн үнэ өсөх өсөхөд ялангуяа архаг өвчтэй, тэгээд ахмад болон бага орлоготой иргэд шууд дарамт болдог. Сайд маань ахмадуудад даралтын эм, зарим эмүүдийн хөнгөлөлт үзүүлнэ гэж ярьж байна. Тэгэхлээр Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн үндэсний зөвлөл эмийн бүртгэл жагсаалт, чанар энэ үнийн зохицуулалтыг шинэчилсэн үү. Энэ дээр ямар нэгэн ажил хийсэн үү.

Хоёрдугаарт, энэ гэрт ойрхон сургууль, хамгийн сайн сургууль гээд 50 тэрбум энэ тодотголоор орж ирж байна. Танилцуулга дээр 22 барилга түрээсэлж, 9.9 мянган сурагчдыг хамруулна гэж бичсэн байна. Энэ ямар түвшинд байна. Хэдэн газар түрээсэлсэн, ямар зардал гарсан, цаашдаа ингэж явах юм бол төсөвт дарамт учирна биз дээ. Ийм замаар ер нь сургуулиа барихгүйгээр, ингээд түрээслээд хотхонд байр түрээслээд ингээд явах юм уу. Энэ дээр Боловсролын яамнаас хариулт авмаар байна.

**П.Ганзориг:** 6 номерын микрофон дээр Эрүүл мэндийн яам эхлээд хариулъя. 8 номероос

**Ц.Батбаатар:** ЭМД-ын Ерөнхий газрын дарга Батбаатар гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмээр олгох жагсаалт гэж байдаг. Энэ жагсаалтад нийт 669 төрлийн эм байдаг бөгөөд өнгөрсөн жилийн гүйцэтгэлээр нийт 900 мянга орчим иргэн энэ хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлж байна. Нийт зардлын хувьд аваад үзвэл хөнгөлөлттэй эмийн зардал нь 2 зардлаас бүрддэг. Нэг нь, Эрүүл мэндийн даатгалын сангийн хариуцах төлбөр, нөгөөдөх нь иргэний хариуцах төлбөр гээд хамтын төлбөрөөс бүрддэг. Нийт 250 тэрбум төгрөг гарснаас Эрүүл мэндийн даатгалын сангаас 150, иргэнээс 100 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан байгаа юм. Иргэдийн хувьд аваад үзвэл, хөнгөлөлттэй эм авч байгаа 900

мянган иргэнээс 580 орчим мянган иргэн нь энэ зүрх судас, даралт, чихрийн шижингийн эм уудаг иргэд байгаа. Эдгээр иргэд нь өнгөрсөн жил эмээ тогтмол ууж чадахгүйгээс мөн нөгөө лавлагаа шатлалын эмнэлэг дээр очоод өндөр өртөгтэйгөөр тусламж үйлчилгээг авдаг ийм асуудлууд үүсдэг. Өнгөрсөн жилийн статистикаас үзэхэд нийт

Мөн хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон эмүүдээс нийт худалдааны нэршлээр нь бүртгэлийн хугацаа дууссан болон бусад улсын мөн гаалийн импортын үнийн мэдээлэл байхгүй эмүүдийг хасаж, энэ эх үүсвэрээр хөнгөлөлттэй эмийн хамтын төлбөрөөс иргэдийг чөлөөлөх бодлогыг оруулж ирсэн байгаа.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн сайд нэмээд хариулсан нь зөв байх. Энхнасан гишүүний асууж байгаа асуулт, эрүүл мэндийн салбарын одоогийн байгаа тогтолцоон дээр эм байна уу. ЭМД-ын сангаас санхүүжүүлж байгаа энэ үйл ажиллагаа цаашдаа та сайд болохдоо бодлогын хэмжээний өөрчлөлт хийнэ, өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарыг илүү санхүүжилт эдийн засгийнх нь загвар тогтолцоог өөрчилнө гэж байсан. Тэр энэ 2026 оны төсөв дээр яаж орж ирж байгаа юм. Ер нь цаашдаа 2027 онд ямар бодлогын том өөрчлөлт хийх юм бэ гэдэг ийм зарчмын асуулт асуусан. Батшугар сайд нэмж хариулъя.

**Э.Батшугар:** Гишүүний асуултад хариулъя. Ер нь манай тогтолцоо бол нэг эх үүсвэр худалдан авалт болон ди ар жи-ийн эрүүл мэндийн энэ даатгалын санхүүжих тогтолцоо нь үнэхээр сайн тогтолцоо. Мөн эрүүл мэндийн энэ салбарын системийн угсралт бол бид нар маш энэрэнгүй сайн угсралт хийсэн байна билээ. Ерээд оны эхээр. Жишээлбэл миний ажиллаж, амьдарч байсан улс оронд хувийн даатгалгүй бол эмнэлэгт очихоор уучлаарай, үзүүлэхгүй гэдэг. Нэг шүд авхуулахад 2 мянган доллар болдог. Манайх үнэхээр иргэнээ хамгаалсан энэрэнгүй хандсан тогтолцоо. Эрүүл мэндийн даатгалтай холбоотойгоор нэг зүйлийг хэлэхэд, 2026 оны төсөв яригдаж байгаа болохоор нэгдүгээрт, бид нар эхний байдлаар даатгал дээрээ эмийн жагсаалтыг шинэчилнэ гэж явж байгаа юм. Үүнийг ЭМДҮЗ-ийн хурлаар ороод, тэгээд шинэчилдэг. Тэгээд нэн шаардлагатай эмүүдээ оруулъя. Монгол Улсын иргэдийн хамгийн их хэрэглэгддэг эмийг оруулъя.

**П.Ганзориг:** Батшугар сайд гүйцээж хариулъя.

**Э.Батшугар:** Жишээлбэл зүрх судасны эм гэхэд 3 төрлийн эм байдаг. Монгол Улсад хамгийн их хэрэглэгддэг. Нэг нь бол даралтын эм гэж байгаа. Нөгөөдөх нь зүрхний хэм алдагдахад уудаг эм, нөгөөдөх нь цусны бүлэгнэлт болон цус шингэлдэг манайхаар ирдэг эмийг оруулъя. Сахарын эмийг заавал оруулах ёстой. Мөн өндөр төлбөртэй эмийг оруулна. Ард иргэдийн карманаас их хэмжээний мөнгө гараад байна. Нэмж хэлэхэд, өнчин эмүүдийг оруулна, нэг ёсондоо тасалдах эрсдэлтэй эмүүдийг оруулна. Үүнд хүүхдүүдийн уналт таталтын эм байдаг гэх мэтчилэн явна. Тусламж үйлчилгээний тал дээр нэг чухал зүйл хэлмээр байна. Манай эмнэлгүүдийн хүртээмжийг тодорхой хэмжээгээр энэ онд 39 эмнэлэг шинээр баригдаж байгаа. Ирэх жил бол 34 баригдана. Нийтдээ 73 эмнэлэг баригдана. Улсын төсвөөс болон гадаадын зээл тусламжаар. Тэгэхэд манай Монгол Улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн болж байна гэж харж байна.

**П.Ганзориг:** Боловсролын яамнаас 9 номер.

**Т.Ням-Очир:** Энхнасан гишүүний асуултад хариулъя. Жилд ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо тогтмол 20-30 мянгаар өсөж байгаа. Энэ өсөлт 3 жил тогтвортой өснө. Энэ өсөлтийн 50-60 хувь нь нийслэл дээр бий болж байгаа. Үүнтэй холбоотойгоор жишээлбэл бид нар өнгөрсөн хавар судалгаа хийгээд 37 сургууль дээр хэт өндөр ачаалал үүсэх буюу 3 ээлжээр хичээллэх ийм эрсдэл үүсэх нөхцөл байдал байгаа учраас өмнөх жил цэцэрлэгүүдээр хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрөө ерөнхий боловсролын сургуулиудад шилжүүлэн хэрэгжүүлж байгаа. Ингээд 30 гаруй мянган хүүхдийг бид нар сургалтын зориулалтаар түрээслэх гэрт нь ойрхон тохижуулсан ийм сургалтын байранд хичээллүүлэх ийм шийдвэрийг гаргасан. Энэ хичээлийн жилийн 9 сарын 1-нд бид нар 21 байршил дээр 8600 хүүхдүүдийг хичээллүүлж эхлээд байна. Өөрөөр хэлбэл, нийслэлд 36 мянган хүүхэд 1 дүгээр ангид элсэнэ гэж тооцвол 4 хүүхэд тутмын нэгийг нь хотхон хороолол дотор нь гэрт ойрхон сургуульд.

**П.Ганзориг:** 9 номер гүйцээж яриулъя.

**Т.Ням-Очир:** 4 хүүхэд тутмын нэгийг нь хотхон хороололд нь ойрхон тийм тохижуулсан сургалтын байранд хичээллүүлэх ийм боломжийг олгосон. Энэ түрээсийн байруудад жилд боловсролын салбарт 30 орчим тэрбум төгрөгийг бид нар зарцуулж байгаа. Хэрвээ энэ 30 мянган хүүхэд бид нар мянган хүүхэдтэй 30 сургууль барина гэвэл 3 жилийн хугацаанд бидэнд 900 орчим тэрбум төгрөг ийм хэрэгтэй. Гэхдээ хүүхдийн тооны өсөлт харьцангуй тогтвортой болж байгаа учраас 3-4 жилийн дараанаас яг цэцэрлэг шиг хүүхдийн тоо тогтворжино. Энэ хүрээндээ бид нар энэ богино хугацааны шийдлээр зөв менежментээр энэ асуудлыг давж гарах боломжтой гэж харж байгаа. Баярлалаа.

**П.Ганзориг:** Энхнасан гишүүн тодруулъя.

**Л.Энхнасан:** Тэгэхлээр эмийн жагсаалтыг ЭМДҮЗ-өөр орох гэж байна гэж ойлгож байна. Шинэчлэгдээгүй байгаа юу сайд аа.

Хоёрдугаарт, Би тэр гэрт ойрхон сургуулийг бол дэмжиж байгаа. Харин цаашдаа ингэж явах юм уу? Яагаад гэвэл, энэ чинь төсөвт аудитын дүгнэлт дээр ч гэсэн байгаа шүү дээ. Төсөвт цаашдаа дарамт үзүүлэх төлөвтэй байна гээд. Тэгэхлээр ингээд цаашдаа 3, 4 жил явах юм уу?

Гуравдугаарт, олон улсын туршлагыг харахад Солонгос, Японд яг хотхонд барилгын компаниуд өөрсдөө сургуулиа барьчихаад, улсад тушааж өгдөг. Тэгж байж нөгөө зөвшөөрлөө авдаг энэ тал руугаа ер нь явах нь зүйтэй байх аа. Түүнээс биш улс ингээд түрээсийн мөнгийг нь өгөөд, тэгээд хүүхдүүдийг сургуульд оруулж байгаа энэ түр зуурын гал унтрааж байгаа л явдал гэж бодож байна. Энэ дээр Боловсролын яам анхаараад, зөвхөн энэ дээрээ ингээд тогтохгүй.

**П.Ганзориг:** ЭМЯ-аас хэн хариулах вэ. Батшугар сайд хариулъя.

**Э.Батшугар:** Тийм. ЭМДҮЗ хуралдахад бид нар Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар бол жагсаалтаа гаргачихсан. Тэгээд ЭМДҮЗ хуралдана, үүнээс өмнө Эрүүл мэндийн яам болон Сангийн яаманд тооцооллоо гаргаад, тэр жагсаалтаа өгдөг. Одоогийн байдлаар тэр хариуг нь хүлээж байна. Ялангуяа Сангийн яамнаас. Тэгээд Сангийн яам бол үнэхээр та бүхэн маань ойлгож байгаа байх, төсвөө боловсруулаад тодорхой хэмжээний цаг хугацаа л авсан. Тэгэхдээ яг цаг

хугацаандаа илгээнэ гэж надад хэлсэн. Тэгэнгүүт нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ЭМДҮЗ рүүгээ тухайн дүгнэлтүүдээ авч, өгөөд тэгээд ЭМДҮЗ хуралдана. Тэгэхдээ одоогийн байдлаар би энэ сардаа багтаагаад хуралдаад шинэчилчихнэ гэсэн тийм тооцоололтой явж байгаа гишүүн ээ.

**П.Ганзориг:** Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэбат:** Ахмадын суурь тэтгэврийг олгох энэ асуудлын хугацааг нь наашлуулж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ үлдсэн хүмүүс байгаад байна аа. Хэлэхгүй бол болохгүй. Яах вэ, хуульд байхгүй учраас бид нар ер нь цаашдаа бодолцмоор юм шиг байгаа юм. Тухайлбал үйлдвэрт 30 жил ажиллачихсан, хүнд нөхцөлөөр гарчихсан 50 настай эрэгтэй хүн байна. Тэгээд би дахиад 10 жил хүлээж байж суурь тэтгэврийг чинь авах юм байна гэж. Би 30 жил нийгмийн даатгал төлсөн, 30 жил тоос шороо, хүнд нөхцөлд ажилласан би бараг 60 насалж чадахгүй байх гэдэг хүн надаас тухайлбал асуулт асууж байна л даа. Тэгэхээр бид нар энэ суурь тэтгэвэр гэдэг эхлэл учраас ямар ч байсан 100-300-гаар эхэлж байгаа. Цаашдаа хэн нэгэн хүмүүсийг тэр нэг шударга төлж байгаа, төлж байсан, олон жил ажиллаж байсан гэдэг хүмүүсээ цаана нь үлдээчихнэ гэдэг зүйлийг бодмоор юм байна билээ гэдгийг би хэлмээр байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ахмадын эм тарианы асуудал гээд яригдаж байгаа. Энэ сайн. Нөгөө талд нь нэг асуудал байна. Улсын Их Хурлын ахмадын ажлын хэсгийнхэн бид нар ярилцаад ахмадуудын нийт гаргаж байгаа зардлын 37 хувь нь сар болгож байгаа, гаргаж байгаа 700 мянгынх нь 37 хувийг эм болон эмнэлгээс үйлчилгээ авч байгаа зардал гаргаад байгаа юм байна билээ. Зарим эмүүд нь байгаа онодоггүй юм байна. Ямар ч хэрэггүй, заавал уу гээд эмч бичээд өгчихсөн байж байхад, энэ эм чинь хөнгөлөлтөд байхгүй эм нь байна гэж. Аптекаар орохоор яг ингэдэг. Тийм учраас энэ асуудлууд шийдэгдэх үү? Энэ дээр хэр зэрэг та хэд маань судалгаа хийсэн юм бэ? Тухайлбал Ахмад гэж байгаа саяын 3 эмээс өөр ямар, ямар эмүүд нь дараад нь байдаг юм. Мөн 3 сар уу гээд бичээд өгчихсөн эмийг тухайлбал би сая Хөвсгөл явж байхад 7 сум аптекгүй хэвээрээ л байж байна. Сар болгон 3 сар уу гэхихсэн эмийг нь 100км-ийн, 200км-ийн цаанаас нөгөө ахмад сар болгон хуруугаа хийх гэж аймгийн төв дээр орж ирж авах юм гэнэ ээ. Тэгээд ийм юмаа бид нар шийдэх ёстой байхгүй юу. Энэ чинь бүүр нэг эмээсээ илүү хэд дахин бензин тос цаг нар гээд, заавал өөрөө ирж хурууныхаа хээг дарна гэсэн энэ мэтийг энэ төсөв дээр чинь засах юм байна уу? Шууд тэр сумын төвийнх нь эмнэлгүүдэд нь тэр эмийг нь өгчихье л дөө. Заавал тэр настай хүмүүс ингээд байж яах юм бэ? Энэ тал дээр тусгай санал өгч байгаа, Батшугар дарга сайд аа.

Тийм учраас манай яамны болон энэ эм тариа хариуцдаг хүмүүс яг бодит амьдрал дээр тэр ахмад гэдэг юм уу, хөгжлийн бэрхшээлтэй гэдэг юм уу дагуулаад явуулаарай. Хөгжлийн бэрхшээлтэй өвдөлт намдаадаг тибантин гэдэг эмийг бүр зарахаа больчихсон юм байна билээ. Хаана зарж байгаа нь нууц гэнэ ээ? Яагаад зарахаа байчихсан юм гэсэн чинь нэг хэсэг хүмүүс авч хэрэглээд байхаар нь цагдаагийн газраас ирсэн учраас бид нар нууцалчихсан юм гээд нэг юмыг шийдэх гэж байна гээд нөгөө хэдэн ядарсан хүмүүсээ бүүр шийтгэдэг ийм байж болохгүй гэдгийг би зориуд хэлмээр байгаа юм. Тэгээд наад нэг эмийн учраа нэг зөвхөн ахмад гэлтгүй учрыг нь сайн олоорой гэдгийг би онцолж хэлмээр байна.

Түрүүний багш, эмч нарын цалинтай зэрэгцүүлээд манай Ариунзаяа гишүүн хэлж байна. Би үүнийг бодоод байсан юм. Үлдсэн байгаа ер нь төсөв мөнгө зарах

гэж байгаа тухайлбал төрийн захиргааны албан хаагч нар сая ингээд хөдөө орон нутгаар явж байхад бид нар ер нь яачихсан хүн болж байна аа. Үндсэндээ төрийн үйлчилгээнийхээ албан хаагчдаас 40 мянган төгрөгийн зөрүүтэй л байна гэж байгаа юм. Төрийн захиргаа гэдэг чинь харьцангуй хариуцлагатай, харьцангуй илүү мэргэжил ур чадвар шаарддаг. Тийм учраас энэ хүмүүсийг Сангийн яам, Хөдөлмөрийн яамнаас асуумаар байна. Яг хуваавал хэдэн төгрөг байх юм бэ? Ийм хувилбарыг та хэд маань судалж бодож үзсэн үү? Цалинг нь их ялгаатай гэж бодоод байгаа юм. ТЗ гэхээр дандаа дарга нар, дандаа өндөр цалин авдаг хүмүүс гэж бодоод байгаа юм. Тэнд чинь маш олон төрийн захиргааны бага цалинтай ийм хүмүүс байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тал дээр нэг тооцоо дахиж хэлээч ээ.

Дараагийнх нь, манай Хөдөлмөрийн яамныхан, 1 минутаа нэмээд авчихъя.

**П.Ганзориг:** Нэг минут нэмж өгье.

**С.Эрдэнэбат:** Сая түрүү жилжингээ л нөгөө багш, эмч нар маань жагсаж байгаа. Цалингаа нэмүүлчихсэн, бусдыг нь нэмнэ гээд л. Энэ, энэ өнцгөөс хамаагүй хандвал би буруу шүү. Сургуульд очоод нэг үйлчилгээний ажил хийх, эмнэлэгт очоод үйлчилгээний ажил хийх, нэг оффис дотор сууж байгаа үйлчилгээний ажил хоёр чинь их өөр шүү дээ. Та хэд сургууль, эмнэлгээр явдаг л байлгүй. Тэгэнгүүт 2 байгаа хүн нь нэгийг нь 50 хувь нь хийнэ, нэгийг нь ингэлээ гээд бүүр ярих юм. Сууриар нь авч үзье гэвэл, тэр ажлын байрных нь зураг авалтыг нь хий гээд ачааллыг нь харуулаад, бусад нөлөөллийг нь харуулаад, мянган хүүхэд дотор дунд нь бужигнаад юу угаах, нэг юун дотор ороод ажил хийх хоёр их өөр байгаа юм. Тийм учраас энэ хөдөлмөрийнхөө суурь стандартын тэр зураглал, цалингийнхаа сүлжээг дахиж нэг авч үзээд тавихгүй бол багш, эмч нартайгаа барьцаад л үзээд байгаа юм шиг гэдэг байдлаар хандвал би буруу гэж бодож байгаа. Тийм учраас хамгийн сүүлд асуухад ХАБ, эрүүл ахуйн зардал дээр хэдэн төгрөг тавьсан бэ? Энэ жилийн тавьсан мөнгийг юунд зарцуулсан бэ? төсвийг нь тодотгох гэж байна.

**П.Ганзориг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2 асуултад нь хариулъя. 7 номерын микрофон.

**А.Даваажаргал:** Гишүүний асуултад хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Даваажаргал. 2026 оны төсвийн тодотголоор яамны батлагдсан төсвөөс нийгмийн халамжийн сангаас 49.8 тэрбум төгрөг хэмнэгдсэн зардлаасаа танагдаж байгаа. Тэгэхдээ энэ зардал нь эргээд 11, 12 сарын суурь тэтгэврийг олгоход зарцуулагдахаар зохицуулалт хийгдсэн. ХАБ, эрүүл ахуйн зардлаас нэг ч төгрөгийн зардал танагдаагүй. Сайдын тушаал гарч 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд цогц арга хэмжээний хөтөлбөр батлагдаж нийтдээ бид нар 7 аймаг, 2 дүүрэг дээр ХАБ-ын сургалт, мэдээлэл, цогц арга хэмжээг зохион байгуулж ажилласан байгаа. Цалин хөлсний нэгдсэн бодлогын хувьд яамнаас төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийг санаачлан боловсруулж Засгийн газарт өргөн мэдүүлэхээр, танилцуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Амжвал бид нар энэ чуулганаар оруулж ирэхээр зорьж ажиллаж байгаа. Салбарын хэмжээнд нийтдээ ер нь 35 хуулиар цалин хөлсний асуудлыг зохицуулж байгаа. Цалингийн бүтэц өөрөө нэлээн өөрчлөлтүүд орсон. Салбарууд өөр, өөрсдийнхөө онцлогоос шалтгаалж өөрсдийнхөө салбар дээр нэмэлт цалингийн бүтцийг бий болгосон асуудлууд байгаа. Үүнийг нэгдсэн байдлаар шийдвэрлэхээр Цалин хөлс, нийгмийн баталгааны

хуулийг яамнаас боловсруулж, энэ чадвал энэ чуулганаараа дамжуулж оруулж ирэхээр төлөвлөөд ажиллаж байна.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн яамнаас хариулчихъя. Батшугар сайд хариулъя.

**Э.Батшугар:** Гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 40 сум ямар ч эмийн сангүй байгаа юм. Тэгээд үүнээс шалтгаалаад тухайн сумын иргэд үнэхээр эмийн дутагдалд ороод байгаа. Тэгээд үүнийг шийдэхийн тулд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, эмнэлгүүд хуралдаад, тэгээд сумын Эрүүл мэндийн төвдөө нэн шаардлагатай эмийг нь хангадаг болно.

Хоёрдугаарт нь, тухайн бүсийн, тухайн сумын ямар иргэн ямар өвчлөлтэй байна, ямар эм шаарддаг юм бэ гэж судалгаа хийж байгаа. Жишээлбэл, нэг суманд 6 иргэн уналт таталтын өвчтэй Флебсит байгаа бол тэр иргэнд нь таарсан тэр эмийг нь хангана. Хоёрт, яг тийм судалгаа гарсан байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр, таны ярьж байгаатай адилхан манай Эрүүл мэндийн даатгалын сангаас 870 мянган иргэн хөнгөлөлттэй эм авсан. Өнгөрсөн жилийн байдлаар. Үүнтэй холбоотойгоор 584 иргэн болох 67 хувь нь зүрх судасны, сахарын эмийг хөнгөлж авсан. Дахиад цаашлаад яривал 240 мянган иргэн ямар нэгэн байнгын уух ёстой байгаа эм нь таслалт үүсээд, нөгөө иргэний бие нь хүндрээд тэгээд эмнэлэгт хэвтэж байгаа юм. Тэр эмнэлэгт хэвтсэн зардал нь өөрөө 210 тэрбум гарч байгаа юм. Тэгэхээр нэг ёсондоо бид нар энэ архаг өвчтэй иргэдийнхээ эмийг нь 100 хувь хөнгөлж өгвөл эрүүл мэндийн салбарт ч гэсэн тодорхой хэмжээний хөнгөлөлт гараад, тэр хүн хэмнэсэн мөнгөөрөө тусламж үйлчилгээнийхээ чанар хүртээмж сайжруулахад зарцуулах бололцоотой болно.

**П.Ганзориг:** Цалингийн тооцоололтой холбоотой асуудлаар Сангийн яамнаас хариулъя. 4 номер хариулах уу?

**М.Санжаадорж:** Гишүүний асуултад хариулъя. Боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний албан хаагч гэхээр 20 хэдэн мянган хүний асуудал яригдаж байгаа юм. Соёл, биеийн тамир гээд. Тэгээд энэ хүмүүсийгээ бид нар 50 хувь нэмэгдүүлээд түрүүний нөгөө цалингийн нэгдсэн бодлогод арай дөхүүлээд, хөрөөний ир шиг энэ цалингаа арилгаад, 50 хувь нэмэгдүүлчихье. Тэгээд ирэх жил бол энэ хүмүүс дээрээ арай бага нэмэгдүүлээд, харин төрийн захиргаа, төрийн тусгай дээрээ буюу огт нэмэгдээгүй байгаа энэ хүмүүс дээрээ илүү өндөр нэмээд явах ийм хувилбарыг 2027 оны төсөв дээр бид нар тусгачхаад байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл, тодотгол болон ирэх жилийн төсөв хоёр хоорондоо тооны хувьд уялдаатай болчихоод байгаа юм. Мэдээж хэрэг, таны хэлсний дагуу би Ариунзаяа гишүүний хэлсний дагуу тооцооллыг хийлгэж гэж байна. Урьдчилсан байдлаар 8-9 хувь орчим нь жигд нэмчхээд, тэгээд ирэх жилийн тооцоогоо яах вэ гэдэг дээр бид нар ярих ёстой болж таарах юм байна.

**П.Ганзориг:** Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

**С.Эрдэнэбат:** Тэр багш, эмч нарын цалингийн хувьд би хэлэхэд, хамтын гэрээ хэлэлцээр гээд л энэ чинь нэлээн юм болж байж болдог юм. Яах вэ, төр бүгдийг нь ижилхэн сууриар нь нэмнэ гээд ингээд яваад байвал маш зөв. Үүнийг

ажлын байрныхаа зураг ачаалал гээд нэмээд, би Боловсролын яамнаас асуухад 30 хүүхдээс дээш хичээл заадаг хэдэн багш байдаг юм, стандарт нормоосоо дээш тийм үү, ингээд л эхэлнэ шүү дээ. Ийм ажлын ачаалал норм гээд үзэх юм. Нөгөө талаараа саяын тооцооллыг хийгээд, ер нь хувилбар байвал бодоод үзвэл нэг дараагийн барьцалт гэдэг байдлаар биш гэдгээр зохицуулчих вий гэдэг үүднээс асуусан шүү. Түүнээс биш тэр боловсрол, соёл тэр бусад албан хаагч нэмэх ёстой, адилхан нэмэх ёстой боломж нь байгаа бол. Би дэмжиж байгаа шүү. Дэмжихгүй асуугаад байгаа зүйл ерөөсөө биш. Сургуулиудад хэлэхэд, ер нь цаашдаа бид нар чинь сургууль барихад тун их мөнгө шаардаад байгаа. Том, том хотхон бариад байгаа компаниудаар нь хооронд нь яриад нэг сургуулийн стандарт барьж өгөөд, та нар үүнийгээ барь.

**П.Ганзориг:** Үг хэллээ. Ганмаа гишүүн асуулт асууя.

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу. Өнөөдөр бид нар төсвийн тодотгол хэлэлцэж байгаа. Тэгэхдээ төсвийн тодотгол зөвхөн цалин тариф нэмсэн мөнгө, нягтлан бодлогын бүртгэл биш. Гол нь бодлого байх ёстой, мөнгөө тавьж байж. Тэгэхлээр энэ нэмэгдсэн санхүүжилт тогтолцооны ямар өөрчлөлттэй дэмжиж байгаа юм, ямрыг нь болохоор больж байгаа юм, багасгаж байгаа юм гэдгийг хамтад нь заавал ярих ёстой. Тийм учраас сайд нар тэгээд мэдээж Эрүүл мэнд, Сангийн, ЭМД-ын ерөнхий газар гэдгээс хариултууд авбал их сайн байна. Та бүхэн мэдэж байгаа. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хуулийг нэр бүхий гишүүд бид хэд тэгээд мэргэжлийн хүмүүс өргөн барьсан, тэгээд хэлэлцүүлэхээр батлагдчихсан байгаа. Энэхүү хуулийн гол шаардлага нь ерөөсөө л иргэд энэ шат дамжлага, давхардал чирэгдэл, тэгээд үр ашигтай, үр дүнтэй тусламж үйлчилгээг санхүүгийн дарамтгүй авах энэ тогтолцоог томоор нь харж боловсруулсан.

Тэгэхээр нэгдүгээрт, бид нар анхан шатын тусламж үйлчилгээ буюу лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний үүрэг, зохион байгуулалтын талаар асууя гэж бодож байна. Эрүүл мэндийн даатгалын тэгээд Азийн хөгжлийн банкны нэг ийм хавсарсан судалгааг олж харлаа. Түүн дээр лавлагаа шатлалын 11.8 сая тохиолдлын ердөө 24 хувь нь анхан шатаар дамжсан, 76 хувь нь анхан шатыг алгасаад шууд лавлагаа шатлалд очсон байна. Анхан болон лавлагаа шаталгааны үйлчилгээний давхардал нь 48 хувьтай байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ үзүүлэлтийг 2026 оны эцэс гэхэд хэдэн хувьд хүргэх юм. 2027 ондоо магадгүй энэ хэдэн хувьд хүргэх юм гэдэг ийм зорилт тавьсан юм байгаа юу? Яг ямар онош, ямар үйлчилгээг лавлагаа, шатлалаас анхан шат руу шилжүүлэх юм? тэгээд үүний үр дүнд лавлагаа шатлалын шаардлагагүй үзлэг хэвтэлтийг хэдээр бууруулж, Эрүүл мэндийн даатгалын сангаасаа хэдэн төгрөг хэмнэх тийм тооцоо гаргасан бэ? Гаргасан уу, үгүй юу?

Хоёрдугаарт, энэ анхан шатлалыг бэхжүүлэх талаар хүрэх гол арга нь улс орон даяар л ярьж байгаа. Анхан шатлалаа бэхжүүлэе. Энэ талаар тодорхой бодлогын санаачилгууд гаргачихсан байгаа. Жишээлбэл, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 1 дүгээр тогтоол хүн амдаа ойртож, эмчийнхээ тоог нэмээд, хүн бүрээ бүртгээд, хүртээмжээ нэмэгдүүлээд. Тэгэх юм бол тарифаа нэмэх. Ер нь тарифыг байнга л нэмж ирсэн. Сүүлийн 5 жилд. Энэ бүхнийг ингээд харахаар чухал ажлууд байгаад байдаг. Хэрэгжилт нь хаана яг юу байна. Эндээс Эрүүл мэндийн яам нь юугаа хийх юм. Нийслэл нь юугаа хийчихсэн байгаа вэ. Яг аль, аль газар өрхийн эмнэлэг нь хүрэлцээгүй, хаана эмч нь байхгүй, яаж тэрийг сайжруулах юм, ямар байдлаар зохион байгуулах юм. Өөрөөр хэлбэл, бид нарын сервис

делиберийн модель, Сервис спэсификэйшн үүнийгээ яаж оновчтой зохицуулах вэ гэдэг асуудал дээр та бүхэн ажилласан уу?

Тэгээд төсвийн тодотгол дээр жишээлбэл энэ бодлогоо дэмжихийн тулд цалин нэмж байгаа эсхүл анхан шатаа дэмжсэн, сайн хүний нөөцийг очихоор цалингаа нэмж хуваарилах уу? Энэ дээр яг юу хийх юм. Уг статистикаар хүн амд бус тухайн байгууллагад бодитоор бүртгүүлж үйлчилгээ авч байгаа, иргэндээ хүрсэн энэ тусламж үйлчилгээг чанартай авах, дээрээс нь хүний нөөцөө стандартад хүргэсэн тийм байгууллагын тарифыг нэмэгдүүлэх, урамшуулалд суурилуулах ийм тогтолцооны бодлогууд нь энэ төсөвтэйгөө яаж орж ирж байгаа вэ гэдэг нь маш чухал бөгөөд хэрэгтэй асуулт байгаад байна.

Дөрөвдүгээрт, Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг эмч сувилагч дунджаар 1800-аас 2 мянга зарим газар 3900 хүрээд байгаа юм байна. Хүний нөөцийн стандартын хангалт нь ердөө 50 хувь-тай. 1500 хүн тутамд нэг эмчтэй болоход 338 эмч шаардлагатай гэсэн тооцоо байгаа юм байна. Тэгэхлээр үүнийг нөхөж байршилд суурилсан, бүртгэлд нь тооцоосон ийм төлөвлөгөөгөө гаргаж чадсан уу гэдгийг би асуумаар байгаа юм.

Нэг минут нэмээд авчихъя.

**П.Ганзориг:** Нэгмөсөн нэмэлт минут өгье.

**Д.Ганмаа:** Архаг өвчний судалгаагаар яг 240 мянган иргэний талаас бараг илүү хувь нь тусламж үйлчилгээг лавлагаа шатлалаас авсан гээд гарчихсан байгаа. Анхан шатад бүртгэгдсэн архаг өвчний 88.3 хувийг зөвхөн зүрх судасны өвчин эзэлж байгаа. Чихрийн шижин, бөөр, амьсгалын зам болон бусад архаг өвчнийг анхан шатдаа их хангалтгүй байгааг энэ судалгаагаар ерөөсөө харуулж байгаа юм. Гол өвчлөл нас баралтад хүргэж байгаа. Үүнийгээ анхан шатдаа байлгахын тулд тарифыг нь 30 хувиар нэмчихлээ шүү дээ. Бүртгэлээ сайжруулчихвал дахиад хэдэн хувиар билээ, нэмэх гэж байгаа тийм үү? Ийм тохиолдолд энэ архаг өвчнийг хэдийг нь яг идэвхтэй хяналтдаа авч байгаа юм. Хэдийг нь цусны даралт, сахрын хяналтдаа авах юм. Шаардлагагүй хэвтэлтийг хэдээр бууруулах юм. Эмийн тасралтгүй хэрэглээг хэрхэн хангах юм гэдэг зорилт нь байгаа юу. Байхгүй бол ер нь яг ингээд бичгээр би эд нарыг бүгдийг нь нэг бүрчлэн авч болох уу.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн яамнаас Батшугар сайд хариулъя.

**Э.Батшугар:** Ганмаа гишүүн маш чухал эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудалд яг оновчтой асууж байна. Өнгөрсөн онд гэхэд нийт лавлагаа шатны өвчтөнүүдийн очсон иргэдийн 70 хувь нь архаг өвчтэй иргэд байгаа юм. Нэг ёсондоо тухайн иргэн зүрх, цусны даралт, артерийн даралттай иргэн 5 хоног хэвтээд, тэгээд зүгээр болно гэсэн зүйл байхгүй. Харин анхан шатныхаа эрүүл мэндийн байгууллагадаа хяналтдаа ороод, тэгээд үүгээрээ дамжуулж эмээ тогтмол уух ёстой. Эдийн засгийн талдаа бас маш их хэмжээний. дарамт ирж байгаа. Эрүүл мэндийн даатгалын газарт. Бараг 200-гаад тэрбумын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна билээ. Тэгэхээр бид нар зайлшгүй анхан шатын эмнэлгээ бэхжүүлэхийн тулд та сайн маш сайн мэдэж байна. ЭМДҮЗ 01 дүгээр тогтоолыг баталсан. Үүнтэй холбоотойгоор хамгийн зөв нь бол энэ эхний байдал дээр санхүүгийн хөшүүрэг байна. Анхан шатын байгууллагууд бол 2 шатлалаар, 2 өөр санхүүжилт авдаг. Нэг нь нормативын тухайн үеийн хорооны ч юм уу, дүүргийн

хороололдоо хорооны иргэний тоогоор нь авдаг. Хоёрт нь, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. Тэгээд ямар тогтолцоо хэрэгжиж байгаа вэ гэхээр нэгдүгээрт, нэг иргэний санхүүжилт нь 59 мянга байхад үүнийг нь 83 мянга болгосон. Одоо яах ёстой вэ гэхээр, анхан шатын эмч тухайн хорооныхоо иргэн болгон дээрээ очоод юу гэдэг юм, Дорж, Дулмаа байна уу, таны даралтыг нь үзээд, жинг нь үзээд, хэр зэрэг эрсдэлийг нь тооцоод, тэгээд түүнийхээ дагуу энэ хүнийг үзсэнээ, үзсэн гэдгээрээ санхүүжилтээ авна, нормативын санхүүжилтээ авна. Хэрвээ тухайн хорооныхоо бүх иргэнээ бүртгэчихвэл тэгвэл нөгөө 83 мянган төгрөг нь нэмэгдээд, 95 мянган төгрөг болно. Өндөр туршлагатай эмч ажиллуулбал тодорхой хэмжээний анхан шатны байгууллага нь бонус авна. Зүрх судасны өвчин бол яг Монгол Улсын нас баралтын номер нэг шалтгаан. Эрүүл мэндийн яаман дээр яг юу хэрэгжиж байгаа вэ гэхээр, Зүрх судасны өвчний үндэсний стратеги батлагдах гэж байна. Боловсруулж байгаа, боловсруулчихсан л даа, удахгүй батлагдана.

Хоёрт нь, та мэдэж байгаа байх. Зүрх судасны үндэсний төв Люксембургийн болон RBRD-ийн санхүүжилтээр удахгүй шаваа тавина, барилгын ажил эхэлнэ. Бусад нарийн тоотой мэдээллийг манай яамныхан хариулчих уу.

**П.Ганзориг:** Ганмаа гишүүн маш нарийн тоонууд, төсвийн тодотгол дээр ер нь цаашдаа 2027 оны төсөвтэй холбоотой асууж байна. Тухайлбал, лавлагаа шатнаас анхан шат руу хэдэн хувиар бууруулах гээд байгаа вэ. Хандаж байгаа эм иргэдэд. Тэгээд түүгээрээ хэдий хэмжээний төсөв нь шилжих юм. Иргэдийг эрүүл мэндийн салбар тогтолцооны хувьд шинэчлэл хийхгүй бол болохгүй гэдгийг хаа, хаанаа бүгд ярьж байгаа. Эмнэлгийн тогтолцоог санхүүжүүлдэг тогтолцоогоор төсвөө яаж ч нэмээд энэ иргэдийн эрүүл аюулгүй байх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж гээд асуудлууд шийдэгдэхгүй. Тэгэхээр иргэдээ эрүүл байлгасных нь төлөө, өвчнийг нь хүндрүүлээгүй, дараагийн шат руу нь очуулаагүйн төлөө тэр үр дүнг санхүүжүүлдэг энэ тогтолцоог хэрхэн яаж хийж байгаа юм бэ? Үүнийгээ тоогоор хэмжигдэхээр тодорхой хариулаач л гэж асууж байна.

Энэ дээр ЭМЯ-аас уу, ЭМД-ын сангаас уу. 8 номер дээр хариулъя.

**Ц.Батбаатар:** Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр анхан шатыг бэхжүүлэх бодлогын хүрээнд өнгөрсөн статистикаас харахад нийт иргэдийн авч байгаа тусламжийн 70 гаруй хувь нь өөрөө анхан шат болон аймаг, дүүргийнхээ эмнэлгийг алгасаад тусламж үйлчилгээг авсан байгаа. Тэгэхээр ЭМД-ын бодлого зөв шатлалд нь зөв тусламж үйлчилгээг үзүүлэхэд чиглүүлсэн ийм санхүүгийн хөшүүргийг хэрэгжүүлж байгаа. Үндсэн эрүүл мэндийн шатлалын бодлогыг зохион байгуулах чиг үүргийг 1 дүгээрт хэрэгжүүлэхгүй байгаа. ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоол батлагдсанаар энэ анхан шат дээр нийт улсын хэмжээнд нэг иргэнээр тооцсон тарифыг ингээд санхүүжилтийг олгоод байгаа боловч тухайн анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын, иргэдийнхээ 65 орчим хувьд хүрч үйлчилсэн ийм дүр зурагтай байгаа. Тийм учраас үүнийг бодит яг иргэндээ үзүүлсэн тусламж үйлчилгээгээр нь анхан шатын эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэхээр өөрчлөлт оруулсан.

Мөн энэ давхардалтай холбоотойгоор 311 тэрбум төгрөгийн зардал нэг талдаа анхан шатдаа мөнгөө өгөөд байдаг, нөгөө талдаа лавлагаа шатлалынхаа тусламж үйлчилгээний авч байгаа тохиолдлын тоо буурахгүй ийм байгаа. Энд нь

нийт даатгалын сангаас 311 тэрбумыг өнгөрсөн хугацаанд зарцуулсан байна. Энэ 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлснээр бид бүхэн нийт шаардлагагүй хэвтэлтийг 40 хувиас 30 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

**П.Ганзориг:** Ганмаа гишүүн тодруулъя.

**Д.Ганмаа:** Би богино хугацаанд маш их асуулт, маш их мэдээллийг, тэгээд тоон, чанарын аль аль түвшинтэй нь асууж байна л даа. Тэгэхлээр цагтаа тааруулж хариулж байна. Саяын ярьснаар байгаа буюу хийчихсэнийгээ хийчихсэнээр, хийж байгааг хийж байгаагаар одоо яг цагтаа багтахгүйгээ бичгээр хүргэж болохыг нь бичгээр хүргэхээр явуулж өгөөч гэж хүсэхээр байна. Ганц минут байдаг. 30 секундэд. Энэ тарифыг 30 хувиар нэмэгдүүлснээр жишээлбэл 2026 оны эцэс гэхэд яг ингээд ямар, ямар өөрчлөлт шинэчлэлтүүдийг та нар хүлээж байгаа юм бэ. Тэр перформс бэйс байдлаар, ялангуяа маш тодорхойгоор орж ирэх хэрэгтэй байна. Саяын асуултад бичгээр хариунуудаа авъя.

**П.Ганзориг:** Наранбаяр гишүүн асуулт асууя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр төсвийн тодотголоор өнөөдөр ард иргэдийнхээ амьжиргааг дэмжихээр ингэж орж ирж байгааг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ өрхийн өөрийнх нь бодитой орлого нь 4.9 хувиар буучихлаа гээд ингээд орж ирж байна шүү дээ. Тэгэхээр ийм үед үүнийг дэмжиж байгаа. Яах вэ, энэ цалингийн асуудал байна. Багш нарын цалин. Үүнийг багш ажилтан гэж 93 мянган хүнийг бүгдийг нь хамруулсан нь ололт байсан шүү. Тэгэхгүйгээр зөвхөн багшийн цалинг нэмсэн бол өнөөдөр тэр 35 мянган хүнийг нөгөө талд нь гаргаж болохгүй байсан. Их Хурал 618 тэрбум төгрөгийг багш нарын цалинд, энэ ажилтнуудын цалинд зориулаад нэмж баталж өгсөн. Үүнийг 12 сард нь хуваагаад хүргэсэн байсан. Тэгэхдээ энэ дээр үндсэн цалинг тасралтгүй нэмэх ийм бодлогыг хэрэгжүүлэхийн тулд энэ ажлыг эхлүүлсэн. 2.2 сая болчихсон байсан үндсэн цалин дунджаар. Одоо ингээд 2.8 сая хүргэх тухай зарим гишүүд ярьж байгаа юм. Энэ боломжтой. Үндсэн цалинг нэмж байж бид цалингийн бүтцийн шинэчлэлийг хийхгүй бол болохгүй ээ. Энэ дээр би хөдөлмөрийн яг энэ цалингийн асуудал хариуцсан улсуудаас нь асууя.

Цаашдаа энэ үндсэн цалинтайгаа тэнцэх хэмжээний нэмэгдэл аваад явж байдаг ийм зүйлээ боливол яасан юм бэ. 70:30 гэдгийг олон улсын байгууллагуудаас үүнийг чинь санал болгоод байгаа юм. Үндсэн цалин 70 хувьтай тэнцэхүйц байх хэрэгтэй. Амьдралынх нь баталгаа байх хэрэгтэй. Залуу багш нар орж ирээд шууд амьдралд хүрэлцэхүйц мөнгөө хэн нэгэн хүний үзэмжээр олгодог нэмэгдэл цалингаасаа тусдаа баталгаатай авдаг ийм систем рүү орох юмыг өнөөдөр энэ үндсэн цалингийнх нь нэмэгдэл дээр нэмэх нь шууд нэмэгдлийг нь дахиад 50 хувь гэж бодоод өгчихсөн. Үүнээс болоод, дураараа ингэж төсөв хөдөлгөснөөс болоод л Засгийн газар өнөөдөр энэ цалингийн сан нь хүрэлцэхээ больсон шүү дээ. Үүнийгээ өөрсдөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй шүү дээ. Хүргэчихсэн байсныг энэ Аубакир сайд хүртэл мэдэж л байгаа шүү дээ. Тухайн үедээ яг төсвийн хуваарийг нь хийгээд ингээд тавьчихсан байсан зүйлийг. Тэгээд хариуцлагагүй ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа үед энэ үндсэн цалинг 2.8 саяд хүргэх энэ боломж энэ удаагийн нэмэлт санхүүжилтээр орж ирэх юм аа. Энэ дээр нэг хариулаач ээ. Ингэх юм бол багшлахаар олон хүн орж ирнэ шүү. Үүнийг нэгдүгээрт, асуух гэсэн юм.

Хоёрдугаарт, Боловсролын яамнаас сурах бичгийн асуудлыг асуухаас өөр аргагүй байна. Өнөөдөр 1 дүгээр ангид орж байгаа хүүхдүүд, би сурагч боллоо гэсэн нэртэй 5 настны сурах бичиг шиг юм бариад яваад байна. 10 сарын 1 хүртэл юу ч байхгүй. Тэгэхээр өнөөдөр ингээд 5 настай хүүхдүүд чинь 94.1 хувийн хүртэл ийм хамрагдалттайгаар суралцчихсан байгаа шүү дээ. Сургуульдаа бэлдээд, дасгал ажлын дэвтэр дээрээ ажиллаад, тэгээд үсгээ заалгах гээд ороод ирсэн чинь өөдөөс яг адилхан юм тавьчихсан. Тэгээд мэдэхгүй, цагаан толгойгоо заагаагүй ийм нөхцөл байдалд хүрчхээд байна шүү. Тэгэхээр үүнийгээ хэзээ шийдэх юм бэ? Тендер зарлагдсан байна. 16 багц ажлын тендер зарлаад, 3.4 тэрбум төгрөгөөр 3 багц ажил дээр нь орж ирээгүй байна. 10 сарын 1 гэхэд энэ сурах бичгээ хэвлээд, тараагаад, хүргээд ингээд явж чадах уу, үгүй юу гэдэг дээр би асар их санаа зовж байна. Энэ дээр Боловсролын яам тодорхой хариулт хэлээрэй. 6-12 дугаар ангийн сурах бичиг ч гэсэн өнөөдөр 62 хувийн л хангалттай. Тэгээд цаашаагаа сурах бичгээ яаж хүргэх юм, яаж хэвлүүлэх юм. Энэ ажлууд чинь ерөөсөө зуун задгай, жаран хагархай хэвээрээ л харагдаад байх юм. Тэгэхээрээ сурах бичиг, хөтөлбөр, багш гэдэг энэ 3-ыг салгахын аргагүй байдаг. Энэ дээр Боловсролын яам чухам яг ямар ажил хийж байна. Үндсэн ажлуудаа сайн хиймээр байна. Үндсэн ажилтайгаа зууралдмаар байна, попрох нь тийм чухал биш гэдгийг хэлье.

Гуравдугаарт нь, ЭМЯ-аас энэ чанаргүй эмүүдийг зах зээлээс гаргана гэсэн ийм юм ярьж байна. Тэгээд чанаргүй эмийг зах зээлээс эргүүлж татаад, чанартай эмийг нийлүүлдэг ийм бодлого хэрэгжүүлбэ гэдгийг бүрэн дүүрэн дэмжиж байна. Энэ маш их хэрэгтэй. Бид өнөөдөр хэний хянаагүй бүгдээрээ л энэ чанаргүй эмийн золиос болж байна шүү дээ. Тэгээд уудаг тэр эм нь үйлчлэхгүй, хоруу чанар нь л үйлчлээд байдаг ийм ч эмүүд байна. Тэгэхээр зэрэг чухам чанаргүй эм хэдэн хувьтай ороод ирсэн юм, хуурамч юмнууд хэр байгаа юм, үүнтэй бүүр цагдаатай нийлж байгаад хатуу тэмцмээр байна. Иргэдийг чанаргүй эмээр ингэж орлогыг зүгээр л шатааж байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр ЭМЯ дуугарч байгаад бүрэн дүүрэн дэмжинэ. Харин энэ дээр тодорхой ямар алхмууд хийгдэх вэ гэдгийг энэ хүмүүсээ мэдээлэлжүүлэх зорилгоор асууя гэж бодсон юм.

Тэгэхээрээ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ цалингийн бодлогыг асууя. Сурах бичгийн асуудал, эмийн асуудал. Баярлалаа.

**П.Ганзориг:** ЭМЯ-аас асуусан асуултыг эхлээд хариулаад явчихъя. Батшугар сайд хариулъя.

**Э.Батшугар:** Гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар Монгол Улсын зах зээл дээр 4300 эм эргэлддэг. Үүнтэй холбоотой маш их иргэдээс гомдол гаргаад байгаа. Чанаргүй эм аль эсвэл хулхины эм гээд. Энэ 7 сард ДЭМБ-ын дэмжлэгээр манайх эмийн лабораторитой болсон. Тухайн лаборатори нь олон улсын стандартын дагуу лабораторитой. Тэгээд нээлт дээр Ерөнхий сайд чиглэл өгсөн. Наад зах зээлд эргэлдэж байгаа эм дээр түүврийн байдлаар шинжилгээ хий гээд. Тэгээд яг процесс хийгдээд явж байгаа. Би сүүлийн мэдээллийг танд хэлэхэд бол 2 эм татагдчихсан байгаа. Нэг нь бол бөөлжихөөр тарьдаг тариа байгаа. Бөөлжихийг зогсоодог. Үүнийг бол бүрэн устгалд оруулаад татчихсан байгаа. Хоёрт нь, яс сийрэгжилтийн витамин чанартай, “Д” кальцитай эм байгаа.

Үүнийг татаад устгалд оруулж байгаа. Энэ 2 эм бол яг лабораторийн шинжилгээний дагуу био химийн шинжилгээнд нь бол стандарт хангаагүй. Цаашлаад ямар алхмууд хийгдэх вэ гэхээр Засгийн газраас Эм эмнэлгийн

хэрэгслийн хуулийн дагуу нэг эх үүсвэрийн худалдан авалтыг хийнэ, мөн нэгдсэн худалдан авалт хийнэ. Гэхдээ дэлхийн хамгийн чанартай улс орны нэг ёсондоо ДЭМБ-ын хатуу зохицуулалттай улс орнуудаас худалдаж авна. Энэ процесс анхнаасаа явсан хэд хэдэн сайн туршлага байгаа. Тэр нь юу вэ гэвэл, цусны бүлэгнэлтийн эсрэг эм байгаа. Нэг ёсондоо хүн гараад очоод цус алдаад байхад эрсдэлтэй энэ эмийг бол 2.7 тэрбумаар нэг эх үүсвэрээс худалдаж аваад, файзераас худалдаж авсан. Үр дүнд нь бол 350 сая төгрөг хэмнэгдээд, тэр мөнгөөрөө хүртээмж нэмэгдээд илүү их тоог нь нэмсэн байгаа юм.

Цаашлаад яривал энэ хөнгөлөлттэй эм дээр ч гэсэн бид нар тодорхой хэмжээний ирэх жил төсвөө тооцоолоод тавьчихсан байгаа. 79 тэрбум нэмж тавьсан. Эмтэй холбоотойгоор, тэрийгээ бол яг дэлхийн хатуу зохицуулалттай улс орнуудын эм дээр нь бид нар түлхүү хөнгөлөлт үзүүлнэ гэж байгаа юм. 100 хувийн хөнгөлөлт. Тэгэхгүй бол энэ таны хэлж байгаа яг зөв л дөө. Янз бүрийн асуудлууд гарна. Харахад бол 2 төрлийн асуудал байдаг юм байна билээ. Нэг нь бол, тун нь өөр, аль эсвэл химийнх нь бодисынх нь хэмжээ нь бага байдаг, цэвэршилт нь бага байдаг гэж ярьдаг. Нэг ёсондоо 80, 90 хувьтай байхад, 89 хувь, 88 хувь байдаг. Аль эсвэл 400мг-ын хебопорфин гэхэд яг шинжлээд үзэхэд нөгөө нь 380мг байх гэх мэтчилэн нөгөө асуудал нь бол яг ёстой тас хуурамч байгаа юм. Тэгэхээр энэ бүхнийг цэгцлэх гээд ЭМЯ-аас ажиллаж байгаа. Мөн эмийн лабораторио бид нар бүрэн дайчилна. Жилдээ 4 мянган эмийн шинжилгээ өгч чадна.

**П.Ганзориг:** Цалингийн сантай холбоотой асуудал. Боловсролын салбарын энэ дээр Сангийн яамнаас хариулах уу? Боловсролын яам эхлээд хариулчихъя. Боловсролын яам 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Наранбаяр гишүүний асуултад хариулъя.

Сурах бичигтэй холбоотой асуултыг Наранбаяр сайд асуусан. Энэ жил 2026 оны 2 сард бага боловсролын сургалтын хөтөлбөр буюу 1-5 дугаар ангийн сургалтын хөтөлбөр батлагдсан. Сургалтын хөтөлбөр батлагдсантай холбоотой сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын орчинтой холбоотой бэлтгэл ажлуудыг үе шаттай хангаж байгаа. Энэ агуулгаараа 2026-2027 оны хичээлийн жилд 1 дүгээр ангийн шинэчилсэн хөтөлбөрийг эхлүүлж байгаа. 1 дүгээр ангийн шинэчилсэн хөтөлбөрийг эхлүүлэхдээ бид нар эхний дөрвөн 7 хоног буюу 1 сарын хичээлийг сургуульд дасан зохицох хөтөлбөр байдлаар зохион байгуулж байгаа. Хуучин 60-80 цагийн бэлтгэл хөтөлбөрүүд, өмнөх хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагддаг байсан бол энэ удаад бид нар дасан зохицох хөтөлбөр гэдгээр оруулж ирж байгаа. Тэгээд эхний 1 дэх 7 хоног сургуультайгаа танилцах, 2 дахь 7 хоног анги хамт олонтойгоо танилцах, 3 дахь 7 хоногт би сурагч боллоо. Тэгээд 4 дэх 7 хоногтоо би сурч чадна гэдэг ийм агуулгаар багш бүрд удирдамж, ажлын зөвлөмжийг нь нэг бүрчлэн хүргээд ийм хөтөлбөрийг явуулж байгаа.

1 дүгээр ангийн сурах бичгийн багц буюу сурах бичиг, дасгал, ажлын дэвтэр, багшийн номтой холбоотой худалдан авах ажиллагаа зарлагдсан. Тэгээд энэ жилийн онцлог хуучин бид нар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр баг байгуулаад багаар сурах бичиг зохиолгоод, тэгээд хэвлэх, түгээх тендерүүдийг хуучин тусдаа зарладаг байсан бол одоо төр, хувийн хэвслүүд буюу паблишинг компаниудаа илүү ашиглаад, хувийн энэ мэргэшсэн компаниуд сурах бичгээ зохиогоод, хэвлэх, түгээхээ хамт зохион байгуулахаар энэ ажлуудыг ингээд яг цогцоор нь хийдэг болж эхэлж байгаа. Өөрөөр хэлбэл, төр өөрөө зохих үйл

ажиллагаанаасаа татгалзаад, мэргэшсэн компаниудыг оруулж ирж байгаа. Энэ агуулгаараа 10 сар гэхэд бид нар 1 дүгээр ангийн сурах бичгүүд зохиох, хэвлэх, түгээх нь хамт явж байгаа учраас бэлтгэл ажил хангагдана.

**П.Ганзориг:** Цалингийн бүтэц тогтолцоотой холбоотой асуулт асуусан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариулъя.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын өгч байгаа зөвлөмжөөр бол үндсэн цалин 70 орчим хувь, 30 хувь нь хувьсдаг. Аль болох цалинг тогтвортой байлгах ийм бүтцийн шилжилт рүү орох нь зөв гэсэн байдлаар ийм судалгаанууд байдаг. Ямар байр суурьтай байгаа вэ. 7 номерын микрофон хариулъя.

**А.Даваажаргал:** Наранбаяр гишүүний асуултад хариулъя.

Өнөөгийн цалингийн зохицуулалтыг зохицуулж байгаа хууль эрх зүйн орчин ер нь 33, 34 хууль болоод явчихсан. Салбар болгон өөрсдийнхөө хуулиар цалингийн асуудлаа шийдвэрлээд явж байгаа. Цалингийн бүтцийн хувьд нэмэгдэл цалин гэдэг зүйл нь үндсэн цалингаасаа бараг 3 дахин их болоод явчихсан салбарууд байгаа. Тэгэхээр эдгээр асуудлыг шийдвэрлэх нь цаг үеийн шаардлага байгаа учраас манай яамнаас Төрийн албан хаагчийн цалин, нийгмийн баталгааны хуулийн төслийг боловсруулаад, Засгийн газрын хурлаар танилцуулж, Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна. Хуулийн үндсэн концепцын хувьд бид нар үндсэн цалинг нийт цалингийн 70 хувьд нь барихаар зорьж байна. Одоо хуульд байхгүй бүтцийн асуудлууд байгаа, цалингийн бүтцийн асуудал байгаа. Эдгээрийг хуульд нь нийцүүлээд ижил албан тушаалд, ижил цалин олгох энэ зарчмыг барьж байгаа.

Хоёрдугаарт, илүү шударга хөдөлмөрийн хөлсний зарчмыг барихаар бид нар хуулийн төсөлд оруулж байгаа. Тухайлбал хийсэн ажлынх нь үнэлгээг бодитоор үнэлээд, хийсэн ажилд нь тохирсон цалин хөлсийг олгодог шударга систем рүү оруулахаар энэ цалингийн хуулийг санаачлаад явж байгаа. Тэгээд ер нь цалингийн нэгдсэн бодлоготой болж, нэг хуулиар цалингийнхаа асуудлыг шийдвэрлэхээр зорьж ажиллаж байна.

**П.Ганзориг:** Наранбаяр гишүүн тодруулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр энэ цалингийн бүтцийн асуудал чухал юм аа. Тэгэхээр Их Хурлаас тодотгол хийж байгаа тохиолдолд цалингийн бүтцийг шинэчлэхээр үүрэг болгох нь зүйтэй гэж бодож байна. Тэгэхгүй бол Хөдөлмөрийн яамны сая хариулсанчлан салбар болгон өөр дээрээ баахан нэмэгдлүүдийг баахан хуулиуд дээр тавьчихсан. Тэгээд тэр нь төрийн албан хаагчдын цалингийн системийг үндсэндээ ганхууллаа шүү дээ. Ийм нөхцөл байдалтай байгааг сая энэ хүргэчихсэн байсан төсвийг нөгөө саруудаасаа татаж авчирч ингэж нэмэгдлүүдийг нь бүгдийг нь бодож өгснөөс болоод өнөөдөр хүрэхээ больчихсон. Нөхцөл байдал ийм л байна шүү дээ. Энэ бодитой байдлаа харцгаая.

Хоёрдугаарт, өнөөдөр тэр сурах бичгийн асуудлыг Боловсролын яам анхаарахгүй бол болохгүй. 7 хоног сургуультайгаа танилцана гэж юу гэсэн үг юм бэ. Тэгээд ангитайгаа танилцана гэж юу гэсэн үг юм. Хичээлийг нь заагаад явахгүй бол 10 сарын 1-ээс энэ чинь ачаалал нь улам нэмэгдэнэ. Өнөөдөр сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр ангид 4 цагтай байхаар заасан байхад, 4.7 гэж баталсныг 5.2.

**П.Ганзориг:** 9 номер хариулах уу? Боловсролын яамнаас хариулъя.

**Т.Ням-Очир:** Тэгэхээр сургалтын хөтөлбөр шинэчлэгдсэнтэй холбогдуулаад агуулга дээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүд гарч байгаа. Энэ агуулгын хүрээнд цаашдаа сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй, тэгээд батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд сурах бичгийг яг энэ агуулгын хүрээнд зохиох, хэвлэх, түгээх процессууд явж байгаа. Тэгэхээр эхлээд хүүхэд сургуульдаа дасан зохицох үйл ажиллагаа шинэ хөтөлбөрийн хүрээнд бид нар оруулж ирж байгаа нь хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа нэг хувилбар гэж ингэж ойлгож болно. Хуучин бол бэлтгэл хөтөлбөр гээд 60-80 цагийн хөтөлбөрүүд явдаг байсан. Энэ хүрээндээ зурлага, татлага, үсэг, тоогоо нүдлэх энэ асуудлууд байдаг байсан бол энэ хичээлийн жилийн хувьд илүү хүүхдүүдийг идэвхтэй, тэгээд сурч чадна гэдэг итгэлийг өгөхийн тулд хөтөлбөртөө нийцүүлсэн ийм зохицуулалт орж ирж байгаа.

**П.Ганзориг:** Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхтуяа:** Өчигдрийн Өргөдлийн байнгын хороон дээр итгэлцүүрийн асуудал хөндсөн. Өнөөдөр энэ багш нараас ирсэн асуултууд байна. Боловсролын яам тодорхой хариулт өгөөрэй. Боловсролын салбарын багш, ажилчид энэ 2026 онд үндсэн цалин нэмэгдэнэ гээд итгээд хүлээгээд сууж байгаа. Тэгээд үндсэн цалин яг нэмэгдэх юм уу, үгүй юм уу гэдгийг маш тодорхой хариулт авмаар байна. Үүнийг Монголын мянга, мянган багш нар чих тавин сонсож байгаа.

Хоёрдугаар асуулт нь, аймаг, сумын багш нар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 5, 3 жилийн нэмэгдэл гэж авдаг. Энэ нэмэгдлээ авч чадахгүй сууцгааж байна. Энэ нэмэгдлийг 10 сардаа багтааж өгч чадах уу. Ням-Очир дарга үүнийг тодруулж өгөөч гэж байна.

Гуравдугаар асуулт, Боловсролын салбараас энэ жил тэтгэвэрт гарсан багш нар 36 сарын тэтгэмжээ авч чадахгүй хүлээлттэй сууж байна. Үүнийг нь өгөх юм уу, он гаргаж өгөх юм уу? яг тодорхой хариулт надад хэлээч гэсэн ийм асуултууд маш олон газраас ирлээ. Тийм учраас энэ дээр нэг тодорхой хариулт авъя. Тэгээд бид нар ер нь нэг нь асууж, нөгөөдөх нь хариулах ийм хоёрын хооронд ажил хэргийн ч юм шиг, тоглоом наадам ч юм шиг ийм байдалтай төрийн ажил яваад байна. Түрүүн Ариунзаяа гишүүн хэлсэн шүү дээ. Бүүр ийм замбараагүй цэгцгүй, үнэхээр нээрээ бүүр хэлэх муу үг ч алга. Тэгээд хуулийн төсөл санаачлаад яг багш нарт хэрэгтэй наалдаж очихоор, хөрсөн дээр буухаар юм хийгээд, санаачлангуут МАН-ынхан тэгдэг юм уу эсвэл энэ дээр нь 2, 3 хүн барьчхаад байж байдаг юм уу? Тэр хууль хэлэлцэхгүй. Би 2 дахь жил рүүгээ орох гэж байна. Багш нар тэрийг асуугаад байдаг. Үүнийг би бүүр ярьж гэж бодож ярьж байгаа шүү. Би энэ 10 сард хууль хэлэлцэхгүй бол яадаг юм. Жагсаал цуглааныг багш нартай үүдэнд, Төрийн ордных нь баруун талд зогсдог юм уу, багш нартайгаа нийлээд.

Энэ Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх байгаа шүү дээ, хууль санаачлах. Тэгээд хэлэлцэхгүй ингээд дарчихсан, бусдынх нь яваад л байна, минийх явахгүй. Ингээд бүтэн 2 жил боллоо. Энэ багш нар бүгд надаас та яагаад хуулиа оруулахгүй байгаа юм гээд, би оруулахгүй байгаа юм шиг ингээд асуугаад байна. Үүнийг би бүүр хэлье гэж хэлж байгаа юм шүү. Тэгээд энэ багш нарт орох ёстой тэр нэмэгдэл, 36 сарын тэтгэмж, 5, 3 жилийн нэмэгдэл бүгд ороогүй. Тэгээд үүнийг хэн оруулах юм, хариуцах юм. Ер нь Сангийн яам нь хариуцах юм уу, Боловсролын яам нь хариуцах

юм уу, хэн хариуцах юм? Ямар ч эзэнгүй, ийм замбараагүй л байдалтай байцгааж байна шүү дээ. Ийм л асуултууд байна.

**П.Ганзориг:** 9 номерын микрофон хариулъя. Мөнхтуяа гишүүний асуултад яг тодорхой хариулмаар байна. Сая 3 багш нарын цалинтай холбоотой, нэмэгдэлтэй холбоотой асуулт асуулаа.

**Т.Ням-Очир:** Боловсролын яам Ням-Очир Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Боловсролын салбар 2022 оноос эхлээд гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилт шилжсэн. Цалин хөлс өөрөө хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсгээ энэ агуулгаараа боловсролын салбарын цалин хөлсний шинэчлэлийг салбарын хүний нөөцийн бодлого, багшийн ажлын ачаалал, гүйцэтгэлийн үнэлгээ, хувьсах зардлынхаа бүтцийн шинэчлэлтэй уялдуулан шинэчлэхээр ажиллаж байгаа. Сая 2026 оны 4 сард Засгийн газар 151 дүгээр тогтоол гаргаж, үүнийгээ дагуулж 100 дагалдах тогтоолуудаар хувьсах зардлаа шинэчилсэн. Үүнтэй холбоотой хувьсах зардлаа шинэчлээд, багшийн цалин хувьсах зардлын бүрэлдэхүүн учраас сургалтын байгууллагын хүүхдийн тоо, алслагдсан байдал, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх өртгөөс шалтгаалаад салбарын онцлогтой ингээд шинэчлэгдээд явна. Мэдээж асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баримталж буй бодлого чиглэлтэй уялдуулна. Тийм учраас хувьсах зардлын шинэчлэлтэй уялдаад цалин хөлсний бодлого цаашаа илүү салбарын онцлогтой ингэж тэлж ачаалал бусад зүйлтэй уялдаж явна гэдгийг танд онцолж хэлье. Тэгэхээр цаашдаа цалин хөлс гэхээсээ илүү хувьсах зардлынхаа аргачлал, ажил бүх зүйлийг тодорхой хийгээд явах юм бол боловсролын салбарын энэ гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилт улам боловсронгуй болоод явна гэж ингэж харж байгаа.

Хоёрдугаарт нь, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д байгаа хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгодог нэмэгдэл, 2026 онд нийтдээ 6817 албан хаагчийн 61.7 тэрбум төгрөгийг олгохоор бид нар тооцсон. Энэ онд 48.9 тэрбум буюу 80 хувьтай батлагдсан. 8 сарын байдлаар бид нар 47.7 тэрбум төгрөгийг 3252 албан хаагчид олгоод байгаа. Тэгэхээр тодотгол хэлэлцэгдээд үлдсэн хугацаанд бид нар энэ батлагдсан төсөвтөө багтаагаад олгох асуудлыг хийгээд явна гэдгийг хэлье. Мөн тэтгэвэрт гарахтай холбоотой Төрийн албаны тухай хуулийн 60.1 дээр байгаа, бид нар 2221 төрийн албан хаагчийн 71.9 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон. Гэхдээ 45 хувьтай батлагдсан байгаа. 8 сарын байдлаар 662 албан хаагчийн 21.4 тэрбум төгрөгийг олгоод байгаа. Үүнийг 2027 оны төсөвтэй уялдуулаад олгоно гэсэн ийм бэлтгэл зохион байгуулалттай байна. Баярлалаа.

**П.Ганзориг:** Мөнхтуяа гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхтуяа:** Ер нь хугацаандаа олгогдоно гэж ойлгож болох уу, Ням-Очир дарга. Ер нь багш нар яг энэ дээр хүлээлттэй байгаад байна. 2026 онд цалин яг нэмэгдэх юм уу. 5, 3 жилийн тэтгэмж олгох юм уу, олгохгүй юм уу? Тэр 36 сарын тэтгэмж гэдгийг яг лавлаж асуугаад байгаа юм. Тэгэхээр олгогдох юм байна гэж Ням-Очир даргын хариултаас би тэгж ойлголоо. Баярлалаа.

**П.Ганзориг:** Түрүүчийн асуултад хариулахдаа, нийтдээ 80 орчим тэрбум төгрөг хэрэгтэй. 40 гаруйг нь олгоод явж байгаа. Тодотгол яаж батлагдахаас хамаараад байгаа дүндээ багтааж олгоод зөрүүг нь 2027 онд олгоно гэж байх шиг

байна. Үүнийгээ нэлээн сайн дахиад тодорхой хэлчих үү та. 9 номер нэмэлтээр хариулъя.

**Т.Ням-Очир:** Тийм, сая Байнгын хорооны дарга тодорхой хэллээ. Тэгэхээр 5, 3 жилийн тэтгэмжийн хувьд бид нар батлагдсан төсөвтөө багтаагаад, үлдсэн хугацаанд олгоно. Харин 36 сарын тэтгэмжийг бид нар 2027 онд төсөвтэйгөө уялдуулаад олгоно.

**П.Ганзориг:** Галбадрах гишүүн асуултаа асууя.

**Ж.Галбадрах:** Өдрийн мэнд хүргэе. Бид төсвөө ярьж байна. Ер нь ажиглаад 2 жил ч боллоо. Ингээд харж байхад бид чуулган дээр ч тэр, Байнгын хороон дээр ч тэр ингээд ярьдаг, асуудал гаргадаг. Тэгээд тэр нь хаанаа зангидагдаад, яг ингээд шийдвэр болоод гардаг юм. Хэд хэдэн санал хэлдэг. Тэгээд яриад хариуцаж байгаа хүмүүс маань та маш зүйтэй санал хэллээ, таны саналыг хүлээж авч байна гэдэг. Эргээд үүнд ямар ч өөрчлөлт ордоггүй ингээд явчихдаг. Энэ хаанаа хэн зангидаад, энэ шийдвэр гаргах вэ. Би Байнгын хороон даргаасаа асуугаад, энд хэд хэдэн чухал санаа саналууд гишүүд маань хэлж байна шүү дээ. Энэ маань ажил хэрэг болдог баймаар байна. Бид нар тодотгол хийж байна. Тэгээд 9 сарын 14 гэхэд энэ ээлжит бус маань өндөрлөнө. Тэр үед нэг шийд гаргах ёстой. Тэр шийдэл дотор орох уу, үгүй юу. Бид тэгээд орохгүй юм бол энд ингээд хий дэмий санал хэлж, камерын өмнө юм яриад сууж байх хэрэггүй байна гэж бодож байна.

Тодотголд хамгийн эхний асуудал хөрөнгө оруулалтаас 272 тэрбум төгрөг хасна. Үүнээс Сангийн яамнаас асууж байсан 33 тэрбумд Боловсролын яамнаас хасна гэсэн байна. Тэгээд энэ ямар шаардлага тавиад, энэ яамнаас цэцэрлэг, дотуур байр, сургууль гээд биччихсэн байна л даа. Нэг мөнгөн дүнгүүд. Энэ ямар шаардлага хангаагүй учраас ингэж хасагдаж байгаа вэ? Би энэ хасахын эсрэг байгаа. Боловсролын яамны хөрөнгө оруулалтаас огт хасахгүй, эсрэгээрээ сургууль, цэцэрлэг нэмж барих хэрэгтэй гэдэг байр суурин дээр хатуу байгаа. Одоо бол инфляц, үнийн өсөлт, ядуурал, ажилгүйдэл шатахууны хомсдол, тэтгэвэр, цалин гээд л маш их олон асуудал яригдаж байна. Тэгэхдээ би өөрөө энэ салбарын хүн учраас энэ чиглэлээр ярихаар байдаг цаг маань явчихдаг. Тийм учраас салбарынхаа юмыг л ярьж байгаа юм. Бид ер нийтээр нь улсын хөгжлөө ингээд эрэмбэлж хармаар байгаа. Яалт ч үгүй эрэмбэлэх юм бол хүний хөгжил орох ёстой. Боловсрол нэгдүгээрт орж ирэх ёстой. Эрүүл мэнд орж ирэх ёстой, хүмүүсийн орон сууцын асуудал орж ирэх ёстой, цалин мөнгө орж ирэх ёстой гээд ингээд явах ёстой. Тэгээд боловсролоо л бид нар сайн чанартай хийхгүй бол сургалт маань чанаргүй л байгаад байх юм бол энэ нийгмийн бүх салбарт байгаа асуудал шийдэгдэхгүй ээ. Үнэхээр цочирдом тооцоонууд зөндөө байгаа шүү дээ салбарт. Эхлээд энэ асуудлаа ингэж гаргаж ирж харахад, жишээ нь, нийт төрийн сургуульд сурч байгаа хүүхдийн 50-иас дээш хувь нь даац хэтэрсэн сургууль, бүлэгт сурч байна. Тэр 35-аас доош байх ёстой юм нь 35-аас дээш байна гээд би дандаа л үүнийг хэлдэг. 370 мянган хүүхэд тэгээд чанаргүй боловсрол олно гэдэг нь бол боловсрол ярих ямар ч үндэслэл алга гэдэг нь тодорхой байсаар байтал энэ асуудлыг сууриар нь шийдэхгүй бол тэгээд хотхоны бага сургууль ч гэдэг юм уу, гэрт ойр сургууль гэдэг гоё нэр өгөөд ингээд яваад байгаа шийдэл чинь буруу шийдэл гэж би харж байгаа.

Өнөөдөр ямар ч сургалтын орчин бүрдээгүй ийм газар л бид нар сургууль байгуулах гээд байна шүү дээ. Тэгэхээр би энэ сургалтын стандарт энэ хотхоны сургууль буюу гэрт ойр сургууль дээр хэр хий гарсан бэ гэдгийг би бүүр тодруулж

асуумаар байна. Тэнд мэдээж спортын заал, цайны газар, номын сан, хүлээлгийн танхим байхгүй. Үүнээс гадна дамждаг өрөөтэй ангиуд хэд байгаа юм. Цонхгүй өрөөтэй анги хэд байгаа юм, анги, танхим. Самбарынх нь өмнө багана нь таглачихсан ийм анги хэд байгаа юм. Би үүнийг яагаад мэдэж байна гэвэл ажлын хэсгээрээ бид нар өнгөрсөн жил явсан. Тэгэхэд ийм орон сууцад, ийм зориулалтын бус байранд хичээллэж байгаа сургуулиуд ерөөсөө очихоор л өөдөөс энэ зориулалтын бус байрнаас минь гаргаж өгөөд, нэг өргөтгөл бариад өгөөч л гэдэг хүсэлт тавьдаг шүү дээ. Тэгэхэд бид нар энэ өргөтгөлийг энэ дээр 14 тэрбум төгрөг нэмээд л тодотголоор орж ирж байна.

Нэг минутаа нэмээд авчихъя.

**П.Ганзориг:** Нэмэлт нэг минут өгье.

**Ж.Галбадрах:** Тэгэхээр тэр 34 дүгээр сургууль дээр очиж байсан. Тэгээд 8 ангитай. Сая миний хэлсэн энэ дүр зураг тэр чигээрээ байсан. Тэнд ерөөсөө хүүхэд чанартай боловсрол олох, тэр агааржуулалт ч авч чадахгүй байна. Хүүхдүүдийн энэ нөхцөлийг бид нар мэдсээр байж ийм төслийг шинэчил гэж ингэж оруулж ирээд байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Тэгэхээр метр квадратын үнэ нь 48 мянган төгрөг гэж өчигдөр хэлсэн. Тэгэхээр энэ чинь өөрөө тэр байрны үнэ. Энэ хотын төвийн өндөр зэрэглэлийн түрээсийн байрны үнэтэй адилхан сургуулийн байрыг бид нар түрээсэлж байна шүү дээ. Тэнд 34 дүгээр сургууль гээд л. Тэгтэл 1 жилд 1 тэрбум төгрөг өгч байна шүү дээ. Ингээд 14 тэрбум. Ирэх жил хэчнээн тэрбум төгрөг болох юм байгаа. Энэ олон газар түрээслэх гэж байна шүү дээ, нэмэгдэх гэж байна. Үүнийг би нэгдүгээрт асуучихъя. Тэгээд үргэлжлээд асууя.

**П.Ганзориг:** Галбадрах гишүүн түрүүн Байнгын хорооны даргаас энэ Улсын Их Хурлын гишүүдийн Байнгын хороо болон чуулган дээр хэлж байгаа үг, асуудлыг яаж бодит ажил болгох вэ гэдэг талаас асууж байна. Би товчхон хариулъя гэж бодож байна. Зарим гишүүд түрүүн асуусан. Ялангуяа энэ төсөв хэлэлцэж байхад, төсвийн тодотгол хэлэлцэж байхад тодорхой асуудлаар Их Хурлын гишүүд үг хэлж, хөндөж байгаа асуудлаараа зарчмын зөрөөтэй санал гаргаж, хураалгаж үүнийгээ суулгуулж болно. Бүгд мэдэж байгаа.

Хоёрт, зөвхөн төсөв хэлэлцэж байх үед бус бид нар тодорхой асуудлуудаар сайдад асуулга тавьж, Байнгын хороогоор сонсож, тэндээсээ бид нар Байнгын хорооны тогтоол гаргаж болно. Их Хурлын тогтоолд санаачилж оруулах бүрэн боломжтой байгаа. Их Хурлын тогтоол өргөн бариад гаргаад, баталсан тохиолдолд тухайн сайд тэрийг хэрэгжүүлэх тодорхой үүрэгтэй. Ингээд хууль зүйн хувьд үүрэгтэй тогтоол болоод явна. Мэдээж энэ салбарын асуудлуудаар Байнгын хорооны асуудлуудаар, Боловсролын салбарын асуудлуудаар олон хууль явж байгаа. Тэр хуульд бид нар тодорхой заалтуудаа шигтгэж оруулах эсвэл бүүр өөрсдөө бие даасан хууль санаачилж өргөн барьж Их Хурлаар оруулах ийм боломжтой. Өнгөрсөн хугацаанд гарч байсан олон тогтоолууд, бодлогын бичиг баримтууд байдаг. Үүний хэрэгжилтээр бид нар ажлын хэсэг гаргаж, хяналт шалгалт явуулж, асуулга зохион байгуулах боломжтой. Тэгэхээр эрхэм Их Хурлын гишүүд дараагийн шатын арга хэмжээнүүдийг шаардлагатай асуудлуудаар авах, хэлж байгаа, ярьж байгаа бодлогын асуудлуудаа бодитой ажил хэрэг болгох боломжууд байгаа шүү гэдгийг дуулгая. Боловсролын яамнаас 9 номерт хариулъя.

**Т.Ням-Очир:** Галбадрах гишүүний асуултад хариулъя.

Энэ жил шилжих болон шинээр хэрэгжиж байгаа гэрээ нь байгуулагдсан төсөл арга хэмжээнүүдээс нэг ч төгрөг татагдаагүй. 5 сарын 31-ний байдлаар гэрээ байгуулагдаж амжаагүй буюу Хэмнэлтийн тухай хуульд хамаарах энэ жилийн 39 шинэ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлах байсны 8 нь хуулийн хугацаандаа амжаагүй. Энэ дээр 21.9 тэрбум төгрөг. 24 төсөл арга хэмжээ хуульд суусныг 97 багц тендер болгож зарласны 87 нь амжилттай болсон. Амжилтгүй болсон 10 төсөл арга хэмжээнүүдийн хэмнэгдсэн мөнгө энэ дээр явж байгаа гэдгийг онцолж хэлье. Түүнээс биш хэвийн үргэлжилж байгаа, гэрээ байгуулагдсан төсөл арга хэмжээ огт хөндөгдөөгүй гэдгийг та бүхэнд онцолж хэлье.

Хоёрдугаарт нь, ачааллыг бууруулах зорилгоор 2022-2023 оны хичээлийн жилээс эхлээд хүүхдийн цэцэрлэгээс эхлээд сургалтын зориулалтаар түрээслэх байруудыг бид нар ашиглаж эхэлсэн. 2022-2023 оны хичээлийн жилд бид нар 130 гаруй байр дээр түрээсийн гэрээ байгуулж, хүсэлт гаргасан хүүхэд нэг бүрийг цэцэрлэгт хамруулж, цэцэрлэгийн хамран сургалтыг 94.5 хувьд хүргэсэн. Энд 35 мянган хүүхдүүд хамаарч байгаа. Жил болгон 17 орчим мянган хүүхдийг бид нар ийм зориулалтаар ингэж авчирсан. Энэ тоо энэ жил 67 болж буурсан. Өөрөөр хэлбэл, хүүхдийн цэцэрлэгийн тоо нэгдүгээрт буурч байна. Хоёрдугаарт, улс, орон нутгийн төсвөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд дуусаж ашиглалтад орж байна. Энэ агуулгаараа ингээд жил ирэх тусам түрээсэлж байгаа байрны тоо сүүлийн 3 жил 50-60 хувиар буураад явж байгаа. Эсрэгээрээ сургуулийн хүүхдийн тоо нэмэгдэж байгаа учраас энэ жил 40 орчим барилга байгууламжаар түрээслээд явж байгаа. Түрээсийн энэ ажил дээр бид нар ажлын хэсэг гаргаж онцгой байдал, салбарын хяналтын хүмүүсийг оролцуулж байранд эрүүл ахуй болон бусад тавигдах шаардлага, орц гарцын аюулгүй байдал хангаж байгаа эсэх, агааржуулалт, дотоод агаарын чанар хэвийн байгаа эсэх, анги, танхимын метр квадрат 35 хүртэлх хүүхэд суухад ашиглах боломжтой эсэх гээд ингээд бүх ажлын хэсэг дүгнэлтээ гаргаад, ингээд эцэслээд явдаг.

Энэ жилийн хувьд бид нар арай өөр зохицуулалт хийж байгаа нь хотхоны сургууль буюу гэрт ойр сургууль хотхон хороолол зохион байгуулах. Сургууль үүнийг хийхийн тулд тоног төхөөрөмжтэй нь, орчинтой нь иж бүрэн хийж байгаа. Энэ агуулгаараа ер нь хотхонд зохион байгуулж байгаа бага сургууль түрээсэлж байгаа. Сургалтын зориулалтаар түрээсэлж байгаа байрнуудаас тавигдаж байгаа шаардлага арай өндөр байгаа. Өөрөөр хэлбэл чийрэгжүүлэх спорт, хөгжмийн дугуйлан, секц явуулах энэ төрлийн хичээлүүд орох боломжтой байдлаар ингэж зохион байгуулаад явж байгаа. Тийм учраас ширээ сандлын стандарт нь өөрчлөгдсөн, хүүхдэд тавигдахад ариун цэврийн байгууламжийн стандартууд нь өөрчлөгдсөн гээд. Жишээлбэл энэ хотхон, хорооллын зориулалтаар түрээсэлж байгаа 21 байрны бараг 17 нь цэцэрлэгийн зориулалтаар өмнө нь ашиглаж байсан байруудыг бид нар шинэчилж тохижуулж ашиглаж байгаа. Энэ агуулгаараа стандарт ер нь гайгүй сайжраад явж байгаа гэдэг ийм дүгнэлттэй байгаа.

**П.Ганзориг:** Галбадрах гишүүн тодруулъя.

**Ж.Галбадрах:** Сургуулийг энэ орон сууцын барилгын доор шийдэж байлаа шүү дээ. Ням-Очир дарга аа, энэ шийдэл мөн байсан. Тэгээд цэцэрлэгийг шийдсэн шигээ сургуулийг шийднэ гэж ингэж бодоод байгаа чинь алдаатай бодлого байгаа юм. Сургуулийн орчин би өөрөө явж очоод үзсэн хүний хувьд л хэлээд байгаа юм. Энэ дамждаг өрөөтэй, 8 ангийнх нь 3 нь өрөө дамждаг гэхээр ойлгодог шүү дээ. Энэ

орж ирээд нөгөө анги руугаа ордог, орон сууцад байдаг шиг тийм өрөөтэй байна. Гал тогоо, нэг доголтой өрөөнүүд дотор явж байна. Агааржуулалт гэдэг энэ мэтчилэн орчны стандартыг та онцгой анхаарч байгаа учраас өндөр шаардлага тавиад төлбөр нь өндөр байгаа гэсэн ийм тайлбар хэллээ гэж би ойлголоо. Тэгэхээр энэ талын бүх энэ түрээсэлж байгаа энэ өрөө 40 орчим объектод гэж байна. Үүнийхээ зураг хөрөгтэй юмыг авч үзэхийг хүсэж байна.

**П.Ганзориг:** Үг хэллээ. Хэрлэн гишүүн асуулт асууя.

**Б.Хэрлэн:** Эдийн засгийн өсөлтийг айл өрхөд бодитоор хүргэсэн энэ төсвийн тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Энд ялангуяа цалин хөлсийг нэмэгдүүлэх тун чухал шийдвэр гарсан байгаа. Тэгэхээр боловсролын салбарын ажилтны цалинг 50 хувиар, эрүүл мэндийн салбарын ажилтны цалинг 20 хувиар, соёл, спорт, цаг уурын салбарын албан хаагчдын цалинг 35-50 хувиар, нийтдээ 149 мянган төрийн албан хаагчийн цалин орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ийм том чухал шийдвэр гаргасан, ийм төсвийн тодотгол орж ирж байна гэж харж байгаа. Тэгэхээр цалинтай холбоотой асуудал сүүлийн хэд хоногт их хэлэлцэгдэж, яригдаж байна. Тэгэхээр өнгөрсөн жил түрүүчийн Засгийн газар 2025 оны өвөл төрийн албан хаагчийн цалин урамшууллын реформыг эхлүүлэх энэ ажлыг эхлүүлж байсан. Тэгээд энэ цалингийн реформынхоо хүрээнд ер нь үндсэн цалинг нэмье гэсэн ийм шийдвэрийг гаргасан байгаа юм. Энэ шийдвэрийг ер нь цалин хөлсийг нэмэгдэлгүй ингээд орхиж ирсэн, он цаг хугацаанд хуримтлагдсан асуудлыг шийдэхэд дорвитой өөрчлөлт оруулсан шийдвэр болсон гэж хардаг.

Ер нь цалин хөлсийг нэмнэ гэдэг эдийн засаг, нийгэмд маш их олон сөрөг үр дагавар авчирдаг учраас нэг амь зогоох төдий хэмжээнд байхад ер нь болно л доо гэж үздэг цалин хөлсний алдартай төмөр онол гэж байдаг л даа. Тэгэхээр энэ онол цалин нэмэх л юм бол инфляц хөөрөгдчихнө. Тэгээд дэмий хэрэггүй үрэлгэн зардлыг ихэсгэчихнэ. Тэгэхээр ер нь нэг их нэмээд байх шаардлагагүй гэсэн ийм байр суурийг илэрхийлээд явчихдаг ийм түгээмэл онол. Энэ ч их хүчтэй байгаад байх шиг байна. Тэгэхээр энэ буруу хандлагад цэг тавихад өнгөрсөн оны шийдвэр томоохон үүрэг гүйцэтгэсэн гэж хардаг.

Өнгөрсөн онд энэ шийдвэрийг гаргахад бид нар сайн мэдэж байгаа шүү дээ, 2024 онд орон нутгийн нэмэгдлийг хөдөө сумдад 40 хувь, аймгийн төвд 20 хувийн нэмэгдэл олгоод явчихсан. Үүнээсээ болоод төрийн албан хаагч, багш, эмч, ер нь төрийн албан хаагчдын цалин хөдөө сумд ажиллаж байх юм бол 40 хувиар нэмэгдээд, нийслэлд ажиллаж байгаа, яг адилхан ажил хийж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдын цалин огт нэмэгдэлгүй болоод ингээд явчихсан. Ийм их хол зөрөө ялгаанууд гаргаад ирсэн учраас энэ зөрчлийг засахад чиглэсэн ийм шийдвэр байсан. Ер нь манайд цалин хөлсний тогтолцоонд нэлээн хэдэн асуудлууд үүсчхээд байгаа. Үүнийг засахад сая хэд хэдэн асуудал дээр анхаараад хуулийн төсөл боловсруулж байгаа гээд хэлж байна. Ялангуяа цалингийн бүтцийн асуудал байгаа. 70:30 гэсэн харьцаатай байх ёстой байтал, өнөөдөр энэ харьцаа нь урвуугаараа болчихсон гээд шулуухандаа хэлэхэд залуу боловсон хүчинд хамгийн халтай ийм тогтолцоо бий болчихсон байгаа.

Зүгээр үр бүтээлтэй, бүтээмжтэй байгаа хүнийг идэвхжүүлэх, урамшуулах талаасаа нэмэргүй болчихсон ийм л тогтолцоо болоод байгаа. Тэгэхээр үүнийг халах тухай дээр өнөөдөр санаачилж байгаа энэ хуулийн төсөл чиглэж байгаа байх гэж бодож байна. Сүүлийн үед яриад байна л даа. Цалингийн 2 тогтолцоотой,

цалинг 2 янзаар тооцдог байсныг нэг янзаар бодвол энэ бүтцийн өөрчлөлтийг нь оновчтой болгох, үндсэн цалинг нь нэмэгдүүлэх замаар нэмэгдлүүдийг нь түүнд нь шингээхэд чиглэсэн энэ бодлогоо хэвээр хадгалж яваа болов уу гэж найдаж байна.

Хоёрдугаарт нь, би нэмэлт нэг минутаа авчихъя. Эрдэнэбат гишүүн хэллээ. Ариунзаяа гишүүн ч хэллээ.

**П.Ганзориг:** Нэмэлт нэг минут өгье.

**Б.Хэрлэн:** Цалин тэгш байх үндсэн зарчимтай. Тэгэхээр төрийн албан хаагчдын цалинг нэмэх явцдаа ер нь нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны албан хаагчдын цалинг орхигдуулчихсан байгаа. Хэрвээ төрийн захиргааны албан хаагчийн цалингийн сүлжээнээс нь харах юм бол төрийн захиргааны албан хаагчийн хамгийн бага цалин 1 сая 166 мянган төгрөг, боловсролын салбарт ажиллаж байгаа ажилтны цалингийн сүлжээн дэх хамгийн бага цалин нь 1 сая 924 мянган төгрөг буюу хоорондоо 750 орчим мянган төгрөгийн зөрүүтэй болчихоод байгаа юм. Эндээс чинь болоод суманд төрийн захиргааны анхан шатын байгууллагад ажиллах хүнгүй болоод байгаа юм. Тэнд ажиллаж байгаа хүмүүс чинь тэр нэг эмнэлэгт очоод, эсвэл сургуульд очоод ойр зуурын ажил хийж байвал арай амьдрал ахуйд нь хэрэгтэй байна гэсэн ийм шийдвэрийг гаргаад яваад байна. Тэгэхээр төрийн алба маань мэргэших, тогтвортой байх энэ боломж байхгүй болоод байна. Тэгэхээр 2027 оны 4 сарын 1-ээс төрийн захиргааны албан хаагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлнэ гэсэн ийм зүйл яригдаад байгаа. Үүнийг 2027 оны 1 сарын 1-ээс болгох ийм боломж байх уу гэдгийг асуух гэсэн юм.

**П.Ганзориг:** Хэрлэн гишүүн их чухал асуудал хөндөж байна. Энэ цалингийн бодлого ялангуяа энэ олон жилийн туршид тухайн жилийн инфляц, амьжиргааны өртөгтэй уялдуулаад мөн тухайн салбарын гүйцэтгэл, бүтээмж, эдийн засгийн үр ашигтай уялдуулж тогтмол нэмж яваагүйгээс болоод хоцрогдчихсон, хуримтлагдчихсан. Тэгээд өнгөрсөн жил боловсрол, эрүүл мэндийн салбарын цалинг нэмэхээс өөр аргагүй байдалд байгаа. Нэмэхийн тулд энэ онд багтааж 75, 76 хувиар нэмэхээр 3 талт хэлэлцээрүүд байгуулсан. Тэгээд 1 талдаа энэ хүний хөгжилтэй холбоотой, улс орны хөгжлийг авч явдаг хамгийн үнэ цэнтэй баялаг нь бол Монгол хүмүүс л байгаа шүү дээ. Эрүүл монгол хүн, боловсролтой монгол хүмүүс авч явна. Энэ салбартаа хөрөнгө оруулалтаа хийдэг, энэ салбарынхаа үнэ цэнийг бид нар бодохгүй, хоцрогдуулж явснаас болоод олон жил хуримтлагдсан юмаа ингээд нэг, хоёрхон жилийн төсөв дээр огцом нэмэхээр төсвийн ачаалал нэг талдаа үүсдэг. Нөгөө талдаа хувийн хэвшлээ нэлээн чирэх ийм хүнд байдалд орчихоод байна. Цалин гэдэг асуудлууд. Боловсролын салбарт ялгаа байхгүй хувийн хэвшлийн боловсролын салбарын байгууллагууд байж байгаа, бүх л салбарт байж байгаа. Тэгээд инфляцын асуудал байж байгаа. Монголбанк энэ дээр тодорхой тооцоолол байгаа юу, үгүй юу. 11, 12 хувь гэсэн юм яриад л байгаа. Тэгэхээр ийм асуудлууд байгаа болохоор Хэрлэн гишүүний саяын хэлдэг асуудлыг төр тогтвортой тодорхой бодлогоо гаргаад, жигд энэ асуудлуудаа шийдэж яваагүйгээс л ингэж цалингийн олон жилийн хуримтлагдсан хоцрогдол үүсэж байгаа. Тэгээд салбар хоорондын ч гэсэн зөрөө үүсэж байгаа гэдгийг бид нар анхаарах ёстой. Эхлээд Батшугар сайд хариулъя.

**Э.Батшугар:** Хэрлэн гишүүн маш зөв юм ярьж байна л даа. Эдийн засгийг дэмждэг гээд гол нь ямар үед дэмждэг вэ гэхээр Монгол Улсын эдийн засаг гээд 2 тусдаа эдийн засаг байгаад байгаа байхгүй юу. Нэг нь уул уурхайн эдийн засаг,

нөгөөдөх нь ард түмний эдийн засаг. Өнөөдрийн нөхцөл байдал 7.9 хувь өссөн нь бол ерөөсөө уул уурхай болон цэвэр экспорт өссөн. Яг эдийн засгийн томъёоллыг бол үйлдвэрчний арга хэрэглээний аргаар 2 тооцдог. Хэрэглээний аргаар нь тооцохоор бол энэ цэвэр экспорт нэмэх нь ард түмний хэрэглээ, хөрөнгө оруулсан төсөв гэж авдаг юм. Тэгэхээр ганцхан цэвэр экспортдоо манай эдийн засаг тэр чигт нь авч яваад байгаа уул уурхайн эдийн засаг чинь өөрөө бол 28-30 хувь эзэлдэг. Нөгөө 70-72 хувь нь ард түмний эдийн засаг байгаа, тэр нь уначихсан байгаа байхгүй юу. Ямар үед цалин нэмэгдэхээр инфляц үүсдэг вэ гэхээр, нийт хэрэглээ нь бүүр халчихсан байхад нь дахиад нөгөө нэг цалин нэмээд шахчихаар чинь нөгөөх чинь тэвэрчхэж байгаа байхгүй юу. Хэрэглээ нь бол уначихсан байхад худалдан авалт уначихсан байхад нэг ёсондоо тэгсэн мөртөө 13 хувьтай өндөр инфляц байгаад байгаа юм.

Тэгэхээрээ цалинг нь нэмж байна гэдэг чинь нэг ёсондоо дам эффект ч байдаг. Тэгээд 1 их наядыг нэмж байгаа юм. Тодотголоор 1 их наяд. Монгол Улсын нийт хэрэглээ ард түмний хэрэглээ бол 55 хувь байдаг. Тэгэхээр 550 тэрбум төгрөг хэрэглээ рүү орно гэж байгаа юм. Тэгэнгүүтээ энэ нь үржүүлэлтийн эффект байдаг юм. Тэр үржүүлэлтийн эффект нь бол 1.9 хувь. Тэгэхээр дахиад бараг 1 их наядыг эдийн засгаар шууд автоматаар шахаад нэг ёсондоо ард түмний эдийн засаг болох борлуулалт нэмэгдэнэ. 8 нэрийн дэлгүүрийн борлуулалт нэмэгдэнэ. Талхны цехийнх нь борлуулалт нэмэгдэнэ. Үүгээр дамжаад ажлын байр нэмэгдэнэ. Нөгөө банкны өрөө төлчих бололцоо нээгдэнэ. Яг онолоороо тэгж явж байгаа юм. Тэгэхээр инфляц энэ үед өсөхгүй. Яагаад гэвэл, нийт ард түмний эдийн засгийн хэрэглээ болон үйлчилгээний салбар уначихсан байгаад байгаа юм. Тэгээд энэ үйлчилгээний салбар өсөлттэй явж байсан. Хэрэглээ өсөж байхад нь дахиад цалин нэмчихвэл энэ чинь өөрөө нөгөө нэг инфляцыг бүүр дэврээд явчих. Хэрвээ нөгөө талд нь юу харагдаад байна гэхээр, Монголбанкны өөрийн валютын нөөц өсөөд байгаа юм. Энэ юу үзүүлж байна гэхээр, бид нар импортоор бараа бүтээгдэхүүн авахгүй, төлбөрийн тэнцэл эерэг байна. Тэгэхээр ард түмний хэрэглээ л буурч байгааг харуулж байхгүй юу. Тэр нь яагаад буурч байгаа гэвэл, ерөөсөө бодит орлого нь буураад байгаа, худалдаж авах чадваргүй болчихож байна гэсэн л тийм зүйл л дээ.

**П.Ганзориг:** Батшугар сайд Монголбанкны өмнөөс төлөөлөөд, Эдийн засаг хөгжлийн яамыг төлөөлөөд цалин нэмсэн, инфляц өсөхгүй ард түмэнд бол үнийн өсөлтийн дарамтад орохгүй инфляц нам доор байна ойрын жилүүдэд гээд хариулчихлаа шүү. Тэгэхээр Засгийн газраас төлөөлж хариуцлагатай мэдэгдэл хийсэн гэж найдаж байна. Тэгэхээр энэ цалингийн нэмэгдлүүд бол цаад утгаараа мэдээж төсвийн урсгал зардлын суурийг тэлдэг, бүгд мэдэж байгаа. Ирэх жил 2027 оны төсөв 10 их наядаар 2026 оноос нэмэгдүүлчихсэн орж ирж байгаа, 43 их наяд. Тэнд урсгал зардал цалинтай холбоотой явж байгаа. Манай Монгол Улсад төрийн албан хаагч нийтдээ 230-аад мянган хүн байж байгаа. Тэгэхээр бид нар төсвөөр дамжуулж бүх асуудлыг шийдэх гэж оролддог энэ гажуудлаасаа гарах ёстой гэсэн би бодолтой байдаг.

Нөгөө талдаа энэ эдийн засгийг чинь чирч явах эдийн засгийн мотор нь хувийн хэвшил байх ёстой. Манай Монгол Улс чөлөөт зах зээлтэй чөлөөт ийм эдийн засагтай улс. Тэгэхээр хувийн хэвслээрээ дамжуулж тэр тусмаа жижиг, дунд бизнесээрээ дамжуулж яаж эдийн засгаа дэмжих вэ гэдэг бодлогоо илүү давхар анхаарч байхгүй бол зөвхөн төсөв төрөөрөө дамжуулсан, төрийн албан хаагчдаараа дамжуулсан бодлого яваад байх нь сөрөг үр дагаврууд ихтэй болов уу

гэж бодож байна. Тэгээд ямар ч байсан Засгийн газрыг төлөөлөөд хариулсан болохоор инфляц бага байх юм байна гэдэгт итгээ дээ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 7 номер хариулъя.

**А.Даваажаргал:** Хэрлэн гишүүний асуултад хариулъя. 2025 оны байдлаар Улсын статистикийн хорооноос гаргасан тоон мэдээллээр төрийн албан хаагчдын дундаж цалинг хувийн хэвшлийнхний дундаж цалинтай харьцуулаад, судлаад гаргаад ирчихсэн байдаг. Тэгээд энэ дээрээ 2 сая 700 орчим мянган төгрөгийн цалингийн тооцооллыг төрийн албан хаагчдын хувьд, хувийн хэвшлийнхний хувьд 2 сая 600 орчим мянган төгрөгийн дундаж цалин гээд ийм тоон үзүүлэлтүүд гаргаад ирчихсэн байгаа. Бид нар 10 жилийн хугацаанд төрийн албаны энэ 4 ангиллын тоон үзүүлэлтүүдийг аваад үзэхээр төрийн тусгай албан хаагчдын тоо бараг 60 хэдэн хувиар өсчихсөн байгаа. Тэгээд яагаад өсчихсөн бэ гэхээр, өнгөрсөн 10 жилийн хугацаанд хамгийн өндөр цалин өссөн салбар нь төрийн тусгай энэ салбарын цалин өссөн байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар нэг зүйлийг анзаараад байгаа нь энэ хэрээрээ шилжилт хөдөлгөөн буюу төрийн албан хаагчдын тогтворгүй байдал.

**П.Ганзориг:** 7 номер гүйцээж хариулъя.

**А.Даваажаргал:** Тэгэхээр энэ хэрээрээ төрийн албан хаагчдын хооронд тогтворгүй энэ шилжилт хөдөлгөөн бий болоод байгаа учраас бид нар нэг ижил албанд гүйцэтгэж байгаа үүрэг дээр нэг ижил цалин олгох энэ зарчмыг барихаар энэ хуулийн төслийг санаачлаад ингээд оруулаад явж байгаа.

Хоёрдугаарт нь, 2022 онд Удирдлагын академид нэг судалгаа хийсэн байдаг. 2023 онд энэ Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв судалгаа хийсэн байгаа. Хамгийн том судалгаа энэ 2 судалгаа байгаа. Энэ 2 судалгааны үр дүн юу вэ гэхээр, 65.7 хувь нь төрийн албан хаагчид ажлаасаа гарах сэдэлтэй байгаа, шалтгаан нь ерөөсөө цалин бага гэдэг. Тэгээд энэ судалгаа 2023 оны 7 сард төрийн албан хаагчдын цалинг 40 хувиар нэмсний дараа дахиад 11 сард аваад үзсэн чинь нөгөө 65.7 маань 32.3 болж буурсан байгаа юм. Тэгэхээр төрийн албан хаагчид ер нь цалингаа нэг ёсондоо голж байгаа, цалингаасаа болоод ажлаасаа гарах сэдэл байгаад байна гэсэн үг. Удирдлагын академийн хийсэн судалгаанаас үзэхэд, төрийн албан хаагчдын амьдралын нөхцөлийг нь судлаад үзэхээр орон байрны.

**П.Ганзориг:** Чинбүрэн гишүүн асуулт асууя.

**Ж.Чинбүрэн:** Байнгын хороодын гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Мэдээж Засгийн газар тодотгол хийхээс өөр нөхцөл байхгүй. Геополитикийн нөхцөл байдал тийм амаргүй байна. Өнөөдөр бензиний үнэ 2 мянган төгрөгөөр нэмэгдчихсэн. Энэ нөхцөл байдалд тодотгол хийж, энэ эдийн засгийн нөхцөл байдлаа сайжруулах арга хэмжээ авахгүй бол болохгүй. Тэр дотроо Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэн энэ төсвийн тодотгол дотор хөдөлмөрийн хөлс нэмэх, хүнээ бодсон бодлого орж ирж байгаад их эмч хүний хувьд их баяртай талархалтай байна. Хэдий мэдээж танах зүйлүүд маш олон байгаа, хасах зүйл их байгаа. Гэсэн хэдий ч цалин хөлсийг нэмэгдүүлэх энэ бодлого ард иргэддээ наалдах ийм төсвийн тодотгол орж ирсэнд баяртай байна. Эндээс би хэд хэдэн зүйлийг асууя. Дараа нь үг хэлэх боломж байгаа. Тийм ээ.

Тэгэхлээр эхний асуулт энэ эмч, эмнэлгийн ажилчдын цалинтай холбоотой, тодотгол дээр Батшугар сайд 12 тэрбум төгрөг нэмэх, дээрээс нь ЭМД-ын санд 79 тэрбум төгрөг нэмэх гэсэн ийм 2 байна. Тэгэхлээр энд эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин нэмэх гэдэг нэг сайдын асуудал биш, энэ бол нэг хүний асуудал биш. Энэ төр залгамж халаатай, Засгийн газрын хэлсэн амласан зүйл үргэлжлэх ёстой, энэ бодлого үргэлжлэх ёстой. Тийм учраас цалин хөлсөө нэмэгдүүлнэ ээ. Тэр дотроо нэг чухал зүйл энэ аймгийн эрүүл мэндийн газрын ажилчдын цалин нэмэгдэх ёстой. Энэ хоцорсон зүйл байгаа. Энэ нь энэ 12 тэрбум дотор орж яваа гэж би ойлгож байгаа зөв үү?

Хоёр дахь асуудал нь, та бүхэн хэлэхдээ бид нэг цалинтай болголоо гэж хэлсэн. Тэгээд таны ярианаас сонсоход нийт цалинг 2026 ондоо 65 хувь болгочихно гэсэн ийм үг хэлж байна, тодотгол дотор. Би сайд байхдаа 30 хувь нэмсэн, 20 хувь нэмэгдээд 50, дээрээс нь 15 хувийг би тэр нөгөө үндсэн цалингийн зөрүү нэг цалин болсонтой холбоотой гэж ойлголоо. Тэгэхлээр энэ 15 хувийн нэмэгдэл нийт хэдэн тэрбум төгрөг болсон бэ гэдэг тоог хэлж өгөөч.

Дараагийн нэг асуух гэсэн зүйл, бид энэ эрүүл мэндийн салбарын цалингийн тогтолцоо энэ чинь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж байгаа учраас яг төрийн албан хаагчидтай ижил хэмжээнд цалин нэмэх тийм бодлого байхгүй шүү дээ. Тэгэхлээрээ даатгалын санг л нэмэгдүүлэх нь өөрөө хамгийн чухал. Тэр дотроо би Сангийн сайд, Сангийн яаманд нэг зүйлд баярлаж байгаа зүйл бол анх удаагаа энэ төрөөс дааж байгаа тусламж үйлчилгээнийхээ санг нэмсэн байна шүү дээ. Үүнийг чинь нэмж өгдөггүй, дандаа зөрөөтэй гараад, даатгалын сан алдагдалтай гардаг хамгийн гол зүйл. Тэгэхээр Санжаадорж даргаас би асуумаар байгаа юм. Ер нь 2027 оныг бид эрүүл мэндийг дэмжих жил болгох гэж байгаа. Тэгэхлээр 2027 онд энэ төсөв хараахан яригдаагүй ч гэсэн бидэнд мэдээллүүд байгаа учраас хэрхэн нэмэгдэх вэ? Даатгалын сан гэдэг нэг ийм асуултыг тодруулчихъя.

Дараагийн чухал зүйлийг Батшугар сайд ярьж байна. Энэ нэг эх үүсвэрийн худалдан авалтын асуудал ярьсан. Намайг Эрүүл мэндийн сайд байхад өмнөх сайдтай холбоотой нэг эх үүсвэрийн худалдан авалт дээр процедурын алдаа байсан. Ер нь бид 2024 оны 5 сард Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт хийхдээ 47 дугаар чухал зүйлийг оруулсан. Энэ нэг эх үүсвэрийн худалдан авалт, үүний гол зорилго ерөөсөө л энэ тендерийн шат дараалсан үнэ нэмэгдлийг бууруулж, ард иргэдэд очиж байгаа эмийг үнэтэй биш болгож очих л ийм зорилго тавьсан. Энэ процедурын алдааг дахин давтахгүйгээр хийх энэ алхмуудаа хийсэн үү, энэ процедуруудыг хийж чадсан уу гэдгийг Батшугар сайдаас асууя. Ингээд асуултууддаа хариулт авъя.

**П.Ганзориг:** Батшугар сайд хариулъя.

**Э.Батшугар:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Чинбүрэн гишүүн бол Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг өөрөө санаачлаад баталсан. Монгол Улсад бол маш их хэрэгтэй хууль байгаа юм. Тэгээд үүний 2 жишээ ярихад бол нэг нь, сая гемофилиний факт тэр 8, 9-ийн эм байгаа. Үүнийг нэг эх үүсвэрээр худалдаж аваад, үүнтэй холбоотойгоор Монголд дахиж тасалдал үүсэхгүй, 12 хувь хэмнэчихсэн. Мөн дэлхийн хамгийн сайн чанарын эмийг оруулж ирсэн, тэгээд мөн вакцины асуудал байгаа юм. Сая вакциныг манайх

Юнисефээс худалдаж авсан. Өнөөдрийн байдлаар 330 мянга ирчихсэн байна. Нийтдээ 500000-ыг захиалсан байна билээ. Нэг зүйлийг хэлэхэд, яг таны хэлсэн энэ юуг хэлэх нь зүйтэй юм гэж бодлоо. Тухайн үед 3 талын хэлэлцээр хийгдээд, тэгээд 75 хувиар цалин нэмнэ гэсэн хэлэлцээрийн дагуу Засгийн газар бол эрүүл мэндийн салбарт тооцооллоо хийж байгаад, тэгээд 190 тэрбумыг нэмсэн байгаа. 90 тэрбум нэмэх гээд байгаа гол асуудал нь юунд тулгарч байгаа юм бэ гэхээр, нөгөө 5 сарын 1-ээс эхлээд нэмэгдлийг нь шинэ цалингаас олгох болсон тийм шийдвэр Засгийн газраас гарсан. Тэгээд яг одоогийн байдлаар нийтдээ 20 хувиар нэмээд, ирэх жил 10 хувиар хувиар нэмчихээр, цалин нь 2025 оны суурь цалинтай харьцуулахад 65-68 хувь нэмэгдэж байгаа юм. Мөн 11 сараас 20 хувь нэмэхэд бол яг нарийн тооцоог нь гаргахад 91.7 тэрбум хэрэгтэй. Үүнийг авчихсан байгаа тодотголд тусгачихсан байгаа.

Мөн цаашлаад мэдээллийн чанартай хэлэхэд, бид нар нэг эх үүсвэр худалдан авалтын журмыг Засгийн газраас хоёр 7 хоногийн өмнө баталчихсан. Тэгээд ирэх жил энэ зарчмаараа худалдан авалт хийх гэж бодож байна. Үүнтэй холбоотой лавлагаа шатны эмнэлгүүд болон бусад эмнэлгүүдээс бид нар мэдээллийг нь авч байгаа. Ямар эмийн хэрэгсэл худалдаж авах шаардлагатай вэ гээд. Тэгээд энэ Юнисеф эд нар бол маш зөв худалдан авалт хийдэг механизм юм байна билээ. 70 орны захиалгыг авч байгаад, тэгээд ДЭМБ-аас хатуу зохицуулалттай улс орнууд руу шууд бөөнөөр нь худалдаж авах захиалга өгдөг. Тэгэхээр хэмжээ, үнийн дүн нь маш их болохоор нөгөө талдаа бол хямдхан үнээр авах тийм бололцоо нээгдчихэж байгаа юм байна. Тийм тогтолцоо байдаг юм байна. Тэгэхээр үүнийг ашиглана гэж бодож байгаа. Мөн цаашлаад бусад улс орнуудын эм, эмийн хэрэгслийн агентлагуудтай холбогдоод явж байгаа. Тэгээд эцсийн үр дүндээ Монгол Улсад хамгийн чанартай эмийг, хамгийн хүртээмжтэй байдлаар мөн иргэдээ хамгийн бололцоотой үнээр оруулах тийм зорилго байгаа.

**П.Ганзориг:** ЭМД-ын сантай холбоотой асуулт асуусан. Сангийн яам, Санжаадорж.

**М.Санжаадорж:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

ЭМД-ын орон нутагт байгаа газрууд дээр ихэнх нь ТЗ ажилладаг юм байна. ТҮ-нүүд байгаа. ТҮ-нүүдийнх нь нэмэгдэл цалинг бид нар тооцоод оруулчихсан. Мөн даатгалаас санхүүжихгүй, улсын төсөв талаасаа санхүүжээд явж байгаа эмнэлгүүд байгаа. Зооноз энэ тэрийг бол тооцоод бид нар оруулчихсан байж байгаа. Энэ жилийн хувьд. Орон нутагт байгаа тэр ТЗ ажилчдын цалинг ирэх оны 2 дугаар улирлаас нэмэхээр тооцоод явж байгаа. Даатгалын сан бол ирэх жилийн төсвийг 15-наас хэлэлцэж эхлэх ёстой. Манай тооцоогоор бол ойролцоогоор 3.4 их наяд төгрөг болохоор ирэх жил дээр тооцсон байгаа. 624 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ гэсэн үг. Энэ жилийн хувьд шимтгэлийн орлого улсын төсвийн татаасны их харьцаа 50:50 байгаа нь ирэх жил улсын төсөв нь илүү өндөр болоод, 60:40 болно. Энэ нь анхан шаттай холбоотой.

**П.Ганзориг:** Хэн хариулах вэ? ЭМЯ-аас Төрийн нарийн бичгийн дарга хариулах уу? 6 номер.

**Н.Эрдэнэбаяр:** Чинбүрэн гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. 2026 онд нэг үндсэн цалинд шилжээд 50 хувь нэмэгдэхэд, 11 сарын 1-ээс нэмэгдэж байгаа нэмэгдлүүдийг оруулаад 342.4 тэрбум төгрөгийн ийм нөлөөлөл үүсэж

байгаа. Ирэх онд 2027 оны 4 сарын 1-ээс цалинг 10 хувь нэмэгдүүлэхэд 50 хувь өссөн цалингаасаа 10 хувь нэмэгдүүлэхээр 2025 оны суурь цалингаас 15 хувь үндсэндээ нэмэгдэж байгаа гэж ойлгож болно. Ингээд тооцоход 689.1 тэрбум төгрөгийн ийм нөлөөлөл байгаа. Ирэх онд дахиад нэмэлтээр. Сая нэмсэн тоо 91.7 тэрбум.

**П.Ганзориг:** Бум-Очир гишүүн төхөөрөмж солиод суучихсан учраас гарчихсан байна. Асуултад нэмээд оруулчихъя. Бум-Очир гишүүн, мөн Нарантуяа-Нара гишүүнийг асуулт дээр нэмье. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Өдрийн мэндийг хүргэе. Засгийн газраас цалин хөлсийг нэмье гээд ороод ирэхэд хэн ч нэмэхгүй, буруу шүү дээ гэж хэлэхгүй нь мэдээж байх аа. Тэгээд хамгийн гол нь яг бид нар тооцоо судалгаагаа, хэрэгцээ шаардлагаа зөв тодорхойлж чадаж байна уу гэдэгт л гол асуудал байгаад байх шиг байна. Сэтгэл хөдлөлөөр жагсаал цуглаанаар хэн илүү олуулаа цугласан нь илүү цалингийн нэмэгдэл хүртээд явдаг нэг ийм гажуудал руу бид орчхож болохгүй байдал ажиглагдаад байна л даа. Тэгэхээр үндсэндээ 1 сарын 1-ээс хойш тодорхой хэсгийнхээ цалинг бид бүхэн нэмсэн. Инфляцад нөлөөлж байгаа нөлөөлөл нь ямар байгаа юм. Хувийн хэвшилд очиж байгаа тэр эрсдэл нь ямар байгаа юм гэдэг дээр та бүхэн маань тооцоо судалгаа хийж байна уу? Хэдийгээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсөөд, эдийн засгийн хувьд эерэг үзүүлэлтүүд ажиглагдаж байгаа боловчиг яг бодит байдал дээр төдийлөн сайн үр дүн гарахгүй байсан хэвээрээ байна.

Тэгэхээр энэ дээр бид бүхэн буруу гажуудсан энэ байдлаа өөгшүүлээд зарим нь эмч нартаа хайртай, зарим нь багш нартаа хайртай, зарим нь болохоор ингээд хоосон үлдээд явдаг нэг ийм байдлыг ингээд хэлэлцээд суугаад байхаар болохгүй байгаад байна л даа. Тэгэхээр яг үндсэн асуудлууд шийдвэр яг яаж гарч байна вэ? Ямар судалгаан дээр үндэслээд эмч нарын цалинг 70 хувь нэмэх нь зөв юм гэж хэн үзээд байгаа юм. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого нь тийм байгаа юм уу? Багш нарын цалин үе шаттайгаар ингээд 50-70 хувь руу нэмэх ёстой гэдэг үндэслэл хаанаас гарч ирж байгаа юм? Зарим буюу Засаг даргын тамгын газар, сумдуудад ажиллаж байгаа төрийн албан хаагч нарын цалинг огт нэмэхгүй байх нь зөв юм уу гэдэг нь болохоор яг юуг үндэслэж ингэж шийдээд байгаа юм бэ? Соёл болон спортын төрийн үйлчилгээний салбарын цалинг 80.1 тэрбум төгрөг тавьж тодотголоор 50 хувь нэмэх гэж байгааг дэмжиж байна. Энэ чинь Засгийн газар цалин нэмье гэж байхад чинь буруу гэж үзэхгүй шүү дээ. Гол нь энэ тооцооллуудаа бид бүхэн яг яаж гаргаад байна вэ гэдэг дээр та бүхэн маань мэргэжлийн яамдуудын хувьд нэг тодорхой тайлбар өгөөч ээ. Цалин хөлсний энэ нэгдсэн бодлого алдагдаад байна гэдгийг бүгд л ярьж байна. Цаашдаа бид бүхэн 70, 80 хувиар гэхээсээ илүүтэй ер нь жигд тодорхой үндэслэлтэйгээр нэмэгдүүлээд явах ийм зөв голдирол руугаа орох нь зөв байх гэдэг ийм байр суурьтай байна. Тэгээд та хэдийнхээ саналыг сонсьё.

Хоёрт нь, 2026 оны төсвийн гүйцэтгэл 50-иас илүү хувь авсан яамд алга. Манай энэ Байнгын хорооны харьяа 4 яам бүгд үндсэндээ 50-иас доош хувийн гүйцэтгэлтэй байна. Нэг үгээр хэлбэл бид бүхний хийх ёстой энэ ажлууд төдий хэмжээнд байна гэж ойлгохоор байна л даа. Тэгээд ер нь болохоор хэмнэхэд хэцүү, нэлээн бүсээ чангалж байгаа л гэж бодоод үндсэндээ төсвийг бид бүхэн баталсан. 400 гаруй тэрбум төгрөгийг бид бүхэн хэмнэж болж л байна. Дийлэнх нь хөрөнгө оруулалтын төслүүд байх шиг байна. Тэгэхээр энэ дээр байгаа энэ хөрөнгө

оруулалт, засвар үйлчилгээтэй холбогдолтой асуудлууд ирэх онуудад яах вэ? Боловсролын асуудал, эрүүл мэндийн байгууламжуудын асуудлууд энэ бусад соёлын төв, спортын энэ байгууламжийн асуудлуудыг бид бүхэн тэр чигтээ царцаж үлдэхээр байна уу, үргэлжлээд явах уу гэдэг дээр тодруулаад асууя.

Дотор нь нэлээн задлаад явах юм бол Эрүүл мэндийн сайд дээр хасагдах биш энэ эрүүл мэндийн хөгжлийн төв 4.5 тэрбум төгрөг нэмэгдэж байгаа юм байна. Энэ яг юун дээр нэмэгдэж байна вэ гэдгийг тодруулъя.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаман дээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5.5 тэрбум гэж байгаа юм байна. 1 тэрбум төгрөгөөр хасагдаж байгаа юм байна. Тэгэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ бодлогоо яг яаж аваад, энэ хөтөлбөрүүд нь ингээд хасагдах, тэгээд түүний үр дүн яаж гарах гэдэг дээр хариултууд авъя. Соёл, спорт, залуучуудын яаман дээр 38 тэрбум төгрөг хасагдаж байгаа.

**П.Ганзориг:** Ганхүлэг гишүүн их чухал асуудал хөндөж байна. Энэ олон жил цалингийнхаа асуудлыг цаг тухайн үед нь шийдээгүйгээс болоод өнөөдөр ингээд төсөв дээр тодотгоод боловсрол, эрүүл мэндийн салбарын цалинг нэмж байгаа нь зөв өө. Тэгэхдээ үнийн өсөлт тухайлбал инфляц дарамт болохгүй гэсэн. Нийтэд ард иргэдэд, ААН-үүдэд ямар тооцоолол байгаа вэ? Энэ дээр Монголбанк хариулмаар байна. Эдийн засаг хөгжлийн яам хариулмаар байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч гэсэн хариулмаар байна. Засгийн газраас бол мөчлөг сөрсөн бодлого явуулж байгаа. Энэ бол инфляцыг ингээд ард иргэд үнийн дарамтад байж байна шүү дээ. Махны үнэ нь буурдаггүй, түлшний хомсдолтой, хязгаарлалттай энэ тээвэр ложистикийн зардлыг өсгөөд, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг өдөөж байгаа хүндрэлүүд байж байна. Энд нөлөөлөхгүй, иргэд үнийн дарамтад орохгүй гэж байна. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам ер нь энэ төсвийн тодотгол болоод цаашдаа төсөвт Монгол Улсын 2027, 2028 оны богино, дунд хугацааны төсөвт үзүүлэх нөлөөг юу гэж харж байгаа юм. Төсвийн урсгал зардлын бааз тэлээд байна шүү дээ. Сууриараа. Эрүүл мэндийн салбар дээр гэхэд нийт зардлынх нь 80 гаруй хувийг зөвхөн цалинд олгож байгаа. Олон улсын жишиг энэ дээд тал нь 60 байдаг. Бусдаар нь тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтуудаа шийддэг.

Ингээд бүтцийн буюу тогтолцооны ийм гажуудлууд яваад байгааг юу гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариултууд өгмөөр байна. Бид нар ингээд нэг аргацаасан, нэг удаа тодотголоо хийчихье, нэг жилийнхээ төсвийг баталчихъя гэж явсаар байтал тогтолцоо, төсвийн бодлого, мөнгөний бодлого нь уялдаа холбоогүй болчихсон ийм асуудлууд байна. Тэгэхээр Монгол банкнаас эхлээд инфляц, үнийн өсөлт, Эдийн засаг, хөгжлийн яам, дараа нь тэр эдийн засгийнхаа энэ асуудлуудыг яаж харж байгаа юм бэ гэдэг дээр хариулмаар байна. Дандаа Сангийн яам хариулна. Төсөв бүрдүүлэх өнцгөөс харж хариулна. Ийм байж болохгүй. Монгол банк хаана байна? Анар Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч хэдэн номер дээр вэ? 8.

**Э.Анар:** Гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тодотголтой холбоотойгоор Төв банкн дээр ерөнхийдөө ямар хэмжээний инфляцад ямар хэмжээний өөрчлөлт гарах вэ гэдэг судалгаа дүн шинжилгээг өөрсдийн хүрээнд хийгдэж байгаа. Ер нь оны эцэс гэхэд 05-аас 07

хувийн нэгж хувиар инфляцад нөлөөлөх болов уу гэсэн ийм судалгаа хийсэн байгаа. Тэгээд ерөнхийдөө оны эцэс рүү бид нарын тооцоолол судалгаагаар 12-13 хувь дээр байх болов уу гэсэн иймэрхүү төсөөлөлтэй байгаа. Баярлалаа.

**П.Ганзориг:** Эдийн засаг хөгжлийн яам байна уу. 8 номер.

**Б.Мөнх-Эрдэнэ:** Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газар Мөнх-Эрдэнэ асуултад хариулъя. Бодлогын хувьд сайд, төсвийн бодлого, эдийн засгийн бодлогоосоо юуг илтгэж байна вэ гэдэг дээр. Ер нь өргөн барьсан ирэх жилийн бодлого ч тэр, төсвийн бодлого өөрөө нэг зардлаа ярьж байгаа, нэг татвараа ярьж байгаа. Тэгэхээр татвар, НДШ-ээр хувийн хэвшилд очих ачааллууд маань 1.5 их наяд төгрөг орчмоор буурч байгаа. Тэгэхээр энэ бол төсвийн тэлэх бодлого явж байна гэж үзэж байгаа. Эдийн засгаа идэвхжүүлэх биш төсвийн хумих бодлого явж байна гээд. Инфляцын тухайд түрүүн Батшугар сайдын хэлсэн нөхцөл байдлыг бид дүгнэж байгаа. Ирэх жилийн инфляц эрэлтийн гаралтай инфляцыг өдөөх эрсдэл байгаа. Гэхдээ зөвхөн цалин нэмсэн гэдэг нь эрэлтийн инфляцыг өдөөнө гэсэн зүйл байхгүй. Төсөв дээр хөрөнгө оруулалт хийсэн ч, ТӨК хөрөнгө оруулалт хийсэн ч, аль аль сувгаараа эрэлтийн инфляц өдөөгддөг. Гэхдээ төсөв нийлүүлэлтийн гаралтай инфляцаа.

**П.Ганзориг:** 8 номер дээр гүйцэж хариулъя. Нэмж хариулах уу?

**Б.Мөнх-Эрдэнэ:** Тийм учраас одоогийн инфляцын шинж тэмдэг ямар байна вэ гэхээр 12.5 хувьтай байгаа 8 дугаар сарын байдлаар. Үүнийг голчлон мах, бензин, гурил, ногоо гэсэн нийлүүлэлтийн гаралтай 4, 5 бүтээгдэхүүн тайлбарлаж байгаа. Дийлэнх нь тэгээд одоогийн нийт инфляцаа 100 хувь гэж үзвэл 65 хувь нь нийлүүлэлтийн барааных, үлдсэн нь эрэлтийн барааных байгаа. Тэгэхээр бид хэд бол дараа жил.

**П.Ганзориг:** Инфляциас гадна Эдийн засаг, хөгжлийн яам энэ төсөв дээр жил болгоны төсвийн тодотгол байна уу, төлөвлөгөө дээр та нар улс орныхоо эдийн засгийн өсөлт, хөгжлийг ямар бодлогоор ингэж дэмжих гээд байгаа юм бэ? Тухайлбал би ЭМЯ-ны жишээ авлаа шүү дээ. Эрүүл мэндийн салбарын чинь нийт зардал энэ санхүүжилтийн 80 гаруй хувь нь урсгал зардал буюу ганцхан бараг цалин болчихоод байна. Энэ чинь олон улсын жишигтэй харьцуулах юм бол бүүр ингээд бүтцийн гажуудалд орчихоод байна шүү дээ. Тэгэхээр та нар энэ салбараар нь томоор нь яаж харж яаж байгаа юм бэ? Төсөв ярихаар ганцхан Сангийн яам хариулаад байдаг. Төсвийн татварын орлого бүрдүүлэх талаас нь тайлбарлаад байдаг, эсвэл татвар буулгая гэхээр төсөв дээр ийм ачаалал ирнэ, цалин өсгөө гэхээр ийм ачаалал ирнэ гээд байдаг. Яг та нар Монгол Улсын эдийн засгийн бодлогыг нь авч явж байгаа яамны хувьд ямар загвар моделиор яаж хараад, яаж хөгжүүлэх гээд, яаж дэмжих гээд байгаа юм бэ? Тэр талаас нь, ард иргэд ААН-ийн нуруун дээр ирж байгаа ачааг яаж хөнгөлж бууруулж явах гээд байгаа юм. Эмзэг иргэдийнхээ орлогыг яаж хамгаалах гээд байгаа юм, жоохон макро талаас нь нэг тодорхой хариулаадхаач. 8 номерын микрофон.

**Б.Мөнх-Эрдэнэ:** Бид нарын тухайд төсвийн хүрээний мэдэгдлээрээ гол төсвийн бодлогын үзэл санаагаа батлуулж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр төсвийн орлого болон зардал аль аль нь эдийн засагт буюу ДНБ-д эзлэх хувь жил бүр буурахаар томъёолж оруулж ирдэг. Энэ хаврын батлуулсан хүрээний мэдэгдэл ч тийм байгаа. Гэхдээ энэ удаагийн төсөв дээр бол ТӨК-удын ногдол ашиг, ОТ-н

ногдол ашиг гээд энэ том бодлого зарчмын шинжтэй зүйлсүүд төсөв дээрээ бүртгээд явъя гэж байгаа учраас нэг удаагийн байдлаар тоо томъёоллоороо өсөж байгаа харагдаж байгаа боловчиг 2028, 2029 оны төсөөллүүдээр үе шаттайгаар төсвийн орлого, зардлын эдийн засагт эзлэх хувь буурна гэж төсөөлж байгаа. Бид макро тоогоор эдийн засаг 6 хувийн өсөлт, валютын нөөцийг 10 тэрбум хүртэл өсгө...

**П.Ганзориг:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 5 номерын микрофон байна уу?

**Л.Гангэрэл:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Гангэрэл байна. Манай дүгнэлтээр ерөнхийдөө энэ цалингийн өсөлтүүд инфляцыг өдөөх эрсдэлийг үүсгэж магадгүй гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байгаа. Ерөнхийдөө цалин нийтдээ 843.7 тэрбум, тэтгэврийн суурь тэтгэвэр дээр 170 тэрбум, ингээд 1 их наяд төгрөгийн, ер нь цалингийн фондын зардал өсчхөж байгаа юм. Энэ цаашаагаа яах вэ гэхээр, хэрэглээний зээлийг өсгөх ийм магадлалтай. Яагаад гэвэл суурь цалингууд өсөөд явчихаар нөгөө цалингийн зээл, тэтгэврийн зээлийн авах хэмжээ нэмэгдэх ийм магадлал өндөр байгаа. Нөгөө талаас урсгал зардал 25.4 хувьд хүрч 2026 оны төсвийг баталж байх үед төсвийн үзэл баримтлал дээр урсгал зардлыг ДНБ-ий 24 хувьд хүргэнэ гэсэн ийм үзэл баримтлалтай байсан. Гэвч энэ өсөлтөөр 1.4 хувийн өсөлтийг бий болгож байна.

**П.Ганзориг:** 5 номер гүйцээж хариулъя.

**Л.Гангэрэл:** Төсвийн зардал мөн 32 хувиас ингээд 33.2 хувь гээд 1.3 функтээр өсчхөж байгаа юм. Ингэхээр энэ төсвийн тодотгол маань ерөнхийдөө төсвөө тэлэх, ингээд хувийн хэвшлийнхээ орон зайг багасгасан ийм л төсвийн тодотгол болж хувирч байгаа юм. Мэдээж инфляцын төсөөлөл дээр манай Монголбанкныхан гол тооцооллоо гаргаж танилцуулах ёстой. Тэгэхээр манай зөвлөлийн зүгээс энэ 9 сард гарах Монголбанкны инфляцын төсөөллийн тайлан мөн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хурлын үр дүнг хүлээж байна. Ерөнхийдөө дүгнээд хэлэхэд инфляц цаашид өдөөх ,инфляц өсөх тийм эрсдэл байна гэж тэгж дүгнэж байгаа юм.

**П.Ганзориг:** Соёлын яам хариулах уу? Эхлээд тэгээд тодруулъя хэдэн номер вэ? 8 номер дээр хариулъя.

**Ц.Ариунсанаа:** Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ариунсанаа. Гишүүний асуултад хариулъя.

Улсын төсвийн тодотголоор манай дээр буурч байгаа гол шалтгаан бол төрийн болон орон нутгийн өмчөөр бараа худалдан авах ажиллагааны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөгдсөн эх үүсвэр Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 5 сарын 31-ний дотор гэрээ байгуулагдаагүй учраас 7 төсөл арга хэмжээний 51.5 тэрбум төгрөг, тэгээд зохион байгуулагдсан тендерээс 218.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүссэн. Үүнээс шалтгаалж болж буурч байгаа. Цалингийн зардал дээр бол 17.8 тэрбум төгрөгөөр нэмэгдээд, бусад урсгал зардлаас 19.8 тэрбум төгрөгийн зардал буурснаар тодотголд орж ирсэн байгаа.

**П.Ганзориг:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Өнөөдрийн бодлогын тогтворгүй байдлын гол алдаа нь улс төрийн тогтворгүй байдалтай холбоотой л доо. Тэгээд та хэд маань үнэнийг нь хэлэх ёстой гэж би бодож байгаа юм. Тэгээд бид нар яг асуулт нь ямар үндэслэлээр нэг салбарыг 70 хувь нэмэх нь зөв юм гэдгийг гаргаж ирсэн юм бэ? Ямар үндэслэлээр тэр салбар дээр огт нэмэхгүй байх нь зөв юм гэдэг ийм тооцоо судалгаа юмнууд гаргаж танилцуулаад байхад ийм шийдвэрүүд яваад байгаа дээрээ яаж дүгнэлт хийх вэ? Бүүр сүүлдээ жоохон утгагүй байдал руу орох ийм эрсдэлүүд үүсэх нь үү гэдэг ийм байдлаас нь би хэлээд байна л даа. Тэгээд сүүлийн 2 жилийн хугацаанд бид бүхэн бодлогын мэтгэлцээн ерөөсөө хийсэнгүй. Улс төрийн хэрүүл, улс төрийн ийм акцууд хийсээр байгаад ийм нөхцөл байдалд очиж байна. Энэ дээрээ зөв дүгнэлт хийх нь зөв юм аа. Цалин нэмснээс болоод хувийн хэвшлийн цалин хөлс дээр дарамт дээр ямар үр дүн гарсан бэ? Судалгаа тодруулга.

**П.Ганзориг:** Эдийн засаг хөгжлийн яам хариулах уу? Хувийн хэвшлийн цалин хөлс дээр ямар дарамт нөлөө үзүүлсэн бэ гэж асууж байна. 8 номерын микрофон.

**Б.Мөнх-Эрдэнэ:** Хувийн хэвшлийн цалингийн хэмжээ яг хэдээр буурна, хэдээр өснө гэсэн тийм тоон тооцоо судалгаа, дүгнэлт байхгүй байна. Ер нь бусад судалгаа, эдийн засгийн нөхцөл байдлаас дүгнэхэд нийлүүлэлтийн гаралтай инфляц бол хувийн хэвшил дээрээ зардал болж очиж байгаа. Тэгэхээр нийлүүлэлтийн гаралтай инфляцыг тогтворжуулаад одоо байгаа 12.5 хувийг ирэх жил 8 хувь, 7 хувь руу очуулж чадвал хувийн хэвшлийн маань зардлын өсөлт тэр хэмжээгээрээ буурна. Нөгөө талдаа бид нар ханш дээрээ анхаарах ёстой. Ханш хэт сулрах юм бол инфляц өснө, зардал нэмэгдэнэ. Тийм учраас экспортоо нэмэгдүүлэх бодлогыг л Засгийн газраас байнга авч хэрэгжүүлж, байнга хянаж явж, валютын ханшаа тогтвортой.

**П.Ганзориг:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Тийм. Тэр эрсдэлийг бид бүхэн тооцоолж үзэх ёстой байх аа. Хагас жилээр нь. Энэ тал дээр тодорхой судалгаануудыг нэмж авах хүсэлтэй байна. Тодотгол дээр хасагдаж байгаа зардалтай холбогдолтой Боловсролын сайдын багц дээрээс энэ Боловсролын зээлийн сангийн 13 тэрбум төгрөг хасагдаж байгаа юм байна. Тэгээд энэ төдий хэмжээгээрээ зээл олголтын асуудал үүсэх үү? Дахиад нөгөө нэг малчдын хүүхдийг сургах журмын асуудал юу болж байна вэ гэдгийг нэмээд тодруулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам саяын ерөнхий яриад байгаа энэ цалин хөлсний нэгдсэн бодлого дээр нэг тодорхой байр сууриа илэрхийлээд жоохон манлайлалтай ажилламаар байна. Энэ дээр яг ямар бодолтой байгаа юм бэ? Ингээд дур, дураараа янз, янзын хэлбэрээр нэмэгдүүлэхээр цаашдаа яваад байх юм уу гэдгийг тодруулъя. Нөгөө талдаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, дэд сан хоёрын энэ хасагдаж байгаа зардлууд ямар үр дүнгүүд бий болгох вэ. Эрсдэл юу байх вэ гэдгийг тодруулъя.

**П.Ганзориг:** Боловсролын яам эхлээд хариулах уу? 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Ням-Очир. Эхлээд малчдын хүүхдийн асуудал Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг

хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх зорилгоор төрийн өмчийн сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэгт хамруулна гэдэг ийм заалт орсон. Энэ заалтын дагуу өөрөөр хэлбэл хуулийн хэрэгжилт хангаж, энэ тогтоол батлагдсан. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулаад 081101, 081103 гээд мал аж ахуй, тэжээл, бэлчээр гэсэн 2 индексээр 2 мэргэжлээр малчны хүүхдүүд сурч байгаа. Энэ онд 23 хүүхдэд 56 сая төгрөгийн тэтгэлэг олгочихсон. Тэгэхээр яригдаж байгаа зүйл хоёрхон индекс байгаа нь жоохон хязгаарлагдмал байна. Ерөнхийдөө индексийнхээ эхний 3 дугаараараа аваад явбал илүү олон ХАА-н чиглэлээр малчны хүүхдүүд хамрагдах боломжтой байна гэдэг. . .

**П.Ганзориг:** 9 номер гүйцээж хариулъя.

**Т.Ням-Очир:** Журмыг шинэчлэх ажлын хэсэг гараад явж байгаа. Тэгэхээр журмын шинэчлэлийг бид нар ондоо багтаагаад оруулаад ирнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Хоёр дахь нь, зээлийн сантай холбоотой асуудал байгаа. Зээлийн сангийн асуудал мэдээж хүнд байгаа. Яагаад гэхээр 2026 онд батлагдсан төсвөөс 31.7 тэрбум төгрөгийг 2025 онд үүссэн өрийг дарахтай холбоотой асуудал ингээд шийдэгдчихсэн. Энэ хэрээрээ зээлийн сан дээр нэлээн тийм өр үүссэн ийм хүндрэлтэй нөхцөл байдлууд байгаа. Гэхдээ 2027 оны төсөв дээр бид нар энэ үүсээд байгаа өрийг тодорхой хэмжээнд бууруулах чиглэлээр арга хэмжээ авахаар 2027 оны төсөв дээрээ саналаа оруулаад явж байгаа.

Угаасаа одоо байгаа дээрээ бид нар өртэй байгаа. Тэгэхээр энэ 2027 оны төсөв дээр бид нар тодорхой 60 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр шийдэхээр ингээд.

**П.Ганзориг:** Дэгээрээ явна шүү, гишүүд ээ. Цалингийн нэгдсэн бодлоготой холбоотой, цалингийн бүтэцтэй холбоотой асуудлаар 7 номер. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

**А.Даваажаргал:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Энэ оны 2 сард бид нар ОУВС-ийнхантай уулзалт хийгээд, Монгол Улсын цалингийн нэгдсэн бодлогын асуудлаар нэгдсэн судалгааны ажлуудыг хийлгэсэн. Улсын төсвийн төлөвлөлт болон энэ өгөгдлийн сангийн хувьд харьцангуй олон улсын жишигт хүрсэн гэж үзэж байгаа. Харин цалингийн нэгдсэн бодлого, уялдаа холбоо муу байгаа гэдэг ийм дүгнэлт гарсан. Үүнтэй холбогдуулаад төрийн албаны шинэчлэлийн зохицуулалт оруулж ирэхийг Улсын Их Хурлаас үүрэг болгосны дагуу Төрийн албаны хуулийн шинэчлэлтийн нэг хэсэг нь энэ төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны нэгдсэн нэг хуультай болно гэдэг энэ зохицуулалтыг хийхээр манай яаман дээр надаар ахлуулаад Ажлын хэсэг гарч байгаа. Энэ ажлын хэсгээс Засгийн газарт удахгүй танилцуулаад Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна.

**П.Ганзориг:** Гүйцээж хариулъя, 7 номер.

**А.Даваажаргал:** Хуулийн үндсэн концепц Монгол Улсын нийт ажиллах хүчний 15 орчим хувийг төрийн албан хаагч нар буюу энэ 213 мянган хүн маань эзэлж байгаа. Тэгэхээр эндээс 20.5 мянга нь төрийн захиргааны албан хаагч нар

байна. 50 орчим мянган төрийн тусгай албан хаагч нар байна. Бид нар өнгөрсөн хугацаанд төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлээд явчихсан. Төрийн захиргаа, төрийн тусгай албан хаагчдын цалин үлдчихсэн байгаа. Тэгээд үүнийг 2027 оны төсөвт нэмэгдүүлэх саналыг бид нар Сангийн яаманд хүргүүлсэн. 2027 оны төсөвт ороод явж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Манай яамны төсвөөс тэр хасагдсан байгаа гээд байгаа асуудал Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 4.2 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн сангаас 49 тэрбум төгрөг хасагдсан байгаа. Бид өнгөрсөн хугацаанд зөв бодлого хэрэгжүүлсний дүнд гэж бид нар өөрсдийгөө хэлж байгаа. Тэр нь халамжийн бодлогыг.

**П.Ганзориг:** Алтаншагай гишүүн асуулт асууя.

**Н.Алтаншагай:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Нэг хэдэн тодруулах зүйл байгаа юм. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт дээр ийм нэг дүгнэлт хэсэг байгаа. Би товчхон уншаад өгчихье. Төр хэтэрхий том урсгал зардалтай байгаа нь эдийн засаг дахь бүх нөөцийг өөртөө татаж, тогтвортой өндөр цалинтай төрийн алба руу шилжих хөдөлгөөнийг ихэсгэж, эдийн засгийг авч явдаг хувийн хэвшлийнхэнд ажиллах хүчний хомсдол үүсгэж, зээлийн олдоц муудан, уул уурхайн салбараас хамааралтай Голланд өвчин гүнзгийрч, бусад баялаг бүтээх салбарууд нурах зэрэг эрсдэл үүсгэж байгааг үргэлжлүүлж болохгүй гэж үзэж байна гэж байгаа. Энэ өөрөө их аюултай дүгнэлт шүү. Энэ нийгэм болон эдийн засгийн энэ хөшүүргүүдийг, хувийн хэвшлийг бид нар ерөнхийдөө ингээд нэлээн нуман тулгуурт оруулаад орхиж байгаа хэлбэр. Яах вэ, энэ тэтгэвэр, тэтгэмж, цалинг их тойрч ярьж байна. Нэмэгдэх нь зүйн хэрэг л байх. Бусад салбарууд ингээд хувийн хэвшлийнхэн дээрээ ямар дэмжлэг очиж, эд нар маань цаашаа хөл дээрээ тогтох юм бэ. Олон энэ жижиг, дунд бизнесүүд нуран унана шүү, ажиллах хүчингүй болно. Нөгөө өндөр цалинтай энэ ажлын байр руу, энэ төрийн хэвшил рүү орох гэсэн энэ урсгал ингээд үргэлжлэх байх. Энэ дээрээ яг энэ хувийн хэвшлүүдээ яаж хамгаалах юм?

Энэ онд худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд гэрээ байгуулсан. 32 төслийг 118 тэрбум төгрөг багцад хуваарилсан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч гэрээ байгуулаагүй 103 тэрбум төгрөг буюу 120 орчим тэрбум төгрөгийг татагдаж байна. Энэ чинь өмнөх төсөв дээр өмнөх оны мөн үед л батлагдаж байсан төсөв байх. Бүгд ярилцаад л хэлэлцээд тойрог дээрээ нэн шаардлагатай гээд л эрэмбэ гаргаж байгаад л хийгдсэн төсвүүд бүгд татагдчихсан. Энэ дээр хэн хариуцлага хүлээх юм. Энэ худалдан авахаас тодорхой мэдээллүүдийг авмаар байна. Зураггүй байсан юм уу, төсөвгүй байсан юм уу эсхүл шүүхийн маргаантай юм уу, эсхүл лобби орсон юм уу? Ингээд энэ олон ажил зогссон. Энэ төрийн 100 хувийн өмчит хөрөнгө оруулалтын санг ААН-ийн хэлбэрээр байгуулж оруулж ирнэ гэж энэ дээр тусгагдсан байгаа. Санхүүгийн схем ойролцоо энэ ТӨК-уд руугаа, үүнийг чиг үүрэг ойролцоо компани сангийн удирдлагад нь хариуцуулаад хийх боломж байхгүй юм уу? Өнөөдөр Засгийн хурлаараа энэ төрийн өмчийг халъя, цөөлье, багасгая л гээд байдаг. Эсрэгээрээ дахиад л төрийн өмчит байгуулъя гээд оруулаад ирж байгаа. Нөгөө төр хэмнэнэ, цомхотгоно гээд байгаа чинь хаана байгаа юм.

Дараачийн нэг зүйл нь, Боловсролын яамныхнаас нэг тодруулж асуух зүйл байгаа юм. Энэ цалинг 50 хувиар нэмэгдүүлсэн шийдвэрийг бүтэн жилийн санхүүжилтийн дутуу үлдэгдлийг энэ төсвийн тодотголоор суулгаж байгаа. Оны эцэст ингээд багш, ажилчдын цалин хөлсийг ондоо багтаан бүрэн олгож

шийдвэрлүүлнэ гэж байгаа юм. Энэ төсвийн тодотголоор орж ирсэн энэ, энэ асуудлуудыг бүрэн шийдэх үү?

Ноднин ерөнхийдөө цалин болон бусад асуудлууд дээр нэлээн хөнгөн хуумгай хандсан шүү дээ. Тэгээд баахан жагсаал болсон. Айж сандраад тооцоо судалгаагүй баахан юм аваачиж хийсэн, тэрний гор нь гарсан. Иргэдтэй уулздаг, боловсролын байгууллагаар орохоор бүгд л цалин нэмэгдлээ ярьж байсан. Үүнийг дагасан тэр эрүүл мэндийн байгууллагын нэмэгдэл гээд яригдаж байсан. Энэ дээр яг тусгагдаж бүрэн шийдэгдэж чадах юм уу. Оны өмнө ярьж байсан юмаа бид бүхэн эргээд л жилийн дараа яриад сууж байна. Ухраад л сууж байна шүү дээ.

**П.Ганзориг:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс эхлээд хариулъя. 5 номерын микрофон.

**Л.Гангэрэл:** Түрүүн хэлсэн. Ингээд төсвийн тодотголоор урсгал зардал 1.4 функтээр нэмэгдээд 25.4 болчихлоо. ДНБ-ий. Төсвийн зардал маань 33.2 хувь гээд 1.2 функтээр нэмэгдээд ерөнхийдөө нийт эдийн засагт, төсөвт эзлэх хувь хэмжээ маань ихсээд байна. Энэ нь хувийн хэвшлээ шахах ийм үзэгдэл цаашид улам ингээд явагдаж байна гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байж байгаа. Ер нь бид нар анх 2024 оноос эхлээд л өгсөн дүгнэлтдээ, нийт эдийн засагт төсвийн оролцоог багасгая, ТӨК-удынхаа хувьчлах, заримыг нь олон нийтэд нээлттэй компани болгох гэх мэтчилнээр ингээд төрийн оролцоогоо багасгая гэсэн ийм л дүгнэлтүүдийг өгч байгаа. Тэгэхээр энэ тодотгол маань ерөнхийдөө ухралт болсон ийм тодотгол болж ирж байна.

Хоёр дахь юм нь, энэ төсвийн ажилчдын цалин 50 хувь нэмэгдсэнээр гарцаа байхгүй хувийн хэвшлийн ажилчдын цалин нэмэгдэх ийм шахалтад хувийн хэвшлийнхэн маань орно. Сая энэ статистик харж байхад, гадаад худалдааны салбар ерөнхийдөө агшилттай ийм дүр зурагтай байна. Тэгэхээр ерөнхийдөө хүмүүсийн худалдан авах чадвар нэлээн бууралттай, үнийн өсөлттэй холбоотойгоор ингээд барааны борлуулалт жоохон муу байна гэсэн ийм үр дүнтэй байгаа. Тэгэхээр хэрвээ хувийн хэвшил маань цалингаа өсгөх ийм дарамт хүрч ирвэл энэ дахиад үнэ өсөх ийм шахалт руу орж ирнэ. Тэгэхээр ерөнхийдөө инфляцыг нэлээн өдөөх ийм эрсдэлд хүргэх гээд байна гэсэн ийм дүгнэлтийг бид өгч байгаа.

**П.Ганзориг:** Сангийн яамнаас 2 асуулт асуусан. Сангийн яамны төлөөлөл байхгүй байх шиг байна. Дэлгэржаргал дарга, 4 номерын микрофон.

**Ж.Дэлгэржаргал:** Алтаншагай гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр ер нь төсөв батлагдаад яг гэрээ байгуулах хугацаа бараг 7 сарын хугацаа байгаа. 11 сарын 15-нд хөрөнгө оруулалтууд батлагдаад, 7 сарын хугацаанд захиалагч өөрөө үүний яг зохион байгуулалт хийхэд хангалттай хугацаа гэж үздэг. Өмнөх жилүүдэд Төрийн хэмнэлтийн хууль батлагдаагүй байхад төсвийн гүйцэтгэл дуусах 12 сар, 11 сард гэрээнүүд хийгддэг байсан. Энэ нь өөрөө дараа жилүүддээ төсвийн ачаалал үүсгэх, гүйцэтгэл гарахгүй байх эрсдэлтэй байсан учраас энэ 5 сарын 31 гэдэг хугацаа бий болсон. Энэ жилийн хувьд 296 төсөл яг хууль дээр шинээр хэрэгжихээр багцаар батлагдсан. Багцаар батлагдах төсөл арга хэмжээг сайд өөрөө хуваарилаад, нийтдээ 819 төслүүд шинээр худалдан авах ажиллагаа зарласан байгаа. Тэгэхээр нийтдээ яг 5 сарын 31 болоход 252 тэрбум

төгрөг яг санхүүжих дүн талдаа хэмнэлтэд орсон. Төсөвт өртөг нь мэдээж өндөр байгаа. Тэгэхээр үүнийг Хэмнэлтийн хуульд зааснаар бид нар 2 төрлийн хэмнэлт хийгддэг.

Нэгдүгээрт нь, гэрээ байгуулж амжаагүй, санхүүжих дүнг бүхэлд нь хэмнэлтэд оруулж байгаа.

Хоёрдугаарт нь, гэрээ байгуулсан боловчиг яг төсөвт өртөг болон гэрээний үнийн дүнгийн зөрөө болох тендерийн хэмнэлтийг бид нар хэмнэлтэд оруулдаг. Энэ дээр нийтдээ 29 тэрбум байгаа. Тэгэхээр хэмнэлтэд орсон төсөл арга хэмжээ тухайн жилдээ хэрэгжих боломжгүй. Гэхдээ хуульд дараагийн төсөв дээрээ төслийнхөө бэлтгэл ажлыг илүү хангаад төлөвлөөд явах нь нээлттэй байгаа. Яг гэрээ байгуулаагүй төслүүдийг бид нар процессоор нь ямар шалтгаанаар вэ гээд харахаар тендерийн маргаан үнэлгээ хийгдэж дуусаагүй, огт тендер зарлаагүй төслүүд байгаа. Тэгэхээр яг цэвэр тухайн төсвийн ерөнхийлөн захирагч болон захиалагчийн чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээ.

**П.Ганзориг:** Боловсролын яам хариулъя. 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд орж ирсэн энэ 674.9 тэрбум төгрөг нь Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 151 дүгээр тогтоолоор албан тушаалын цалинг 50 хувиар нэмэгдүүлсэн. Нэмэгдлийг энэ 50 хувь нэмэгдүүлсэн цалингаас бодож олгох зөрөөг шийдвэрлэх энэ эх үүсвэр гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, 151 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай эх үүсвэр мөн.

**П.Ганзориг:** Алтаншагай гишүүн тодруулъя.

**Н.Алтаншагай:** Нэг тодруулах зүйл байгаа юм. Энэ нийслэлийн үнэт цаасны санхүүжилтээс 750 тэрбум төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр тусгасан байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ орон нутгийн үлдэгдэл гээд 998 тэрбум төгрөг. Энэ 2 дээр нэг тодорхой тайлбар аваадахъя.

Энэ яаж ямар учиртай юм гэхээр, энэ нийслэл чинь өөрөө маш их тулгамдсан асуудалтай шүү дээ. Зам, түгжрэл, утаа гээд маш олон бүтээн байгуулалтуудыг зогсоочихсон. Гадаад зээллэгийн гээд нэг баахан асуудал байж ярьж байгаа. Тэр нь ингээд нэг ч олигтой үр дүнд хүрээгүй зогсчихсон. Тэгээд энэ үнэт цаасаар 758 тэрбум төгрөгийг босгоод банканд байршуулчихсан. Үүнийг нь ингээд дээрэмдэж байгаа юм уу.

Хоёрдугаарт, энэ орон нутгийн үлдэгдэл гэдэг энэ 998 тэрбум төгрөг нь бусад орон нутаг байна уу, нийслэлээс дахиад ингээд шомбодчихов уу?

**П.Ганзориг:** Сангийн яам хариулъя. 4 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Гишүүний асуултад хариулъя. Түрүүн тэр цалинтай холбоотой асуудлууд нэлээд гараад байгаа учраас тэн дээр ерөнхий тайлбар өгөх нь зөв байх. 50 хувь гэдгийг хаанаас тогтоосон юм бэ гээд асууж байсан. 50 хувь нь

боловсролын салбар дээр түрүүлээд 50 хувь тогтчихсон байсан учраас бид нар эрүүл мэндийн салбарыг яг 50 хувь дээр нь аваачиж тавьсан. Бусад салбарыг жигдлэх зорилгоор 50 хувь тавьсан. Энэ нь өөрөө инфляцын эсрэг гол зорилго зорилт байсан шүү. Ер нь Төрийн албаны тухай хуулиараа бол хувийн хэвшил дээрээс төрийн албаны цалин 5 хувиар доошоо орсон тохиолдолд бид нар цалингийн асуудлыг ярих ёстой байсан. Тэр нь ноднин бол энэ жилийн төсвийг өргөн барихдаа цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байхаар инфляцтай чиглэсэн байдлаар оруулсан. Гэхдээ Улсын Их Хурал дээр энэ нь буруу байна, цалин хөлс нэмэх шаардлагатай байна гэдэг зүйл гаргаад, тэгэхдээ тухайлан яг 2 салбар дээр явчихсан учраас бид нар тэр салбар луугаа очиж тавигдаж байгаа.

**П.Ганзориг:** Гүйцээж хариулъя. Тэр нөгөө нийслэлийн үнэт цаасны 770 тэрбум төгрөг орон нутгийн төсвөөс татсан.

**М.Санжаадорж:** Нийслэлээс болохлоор үнэт цаас хасаж байгаа эсэх нь бол Сэлбэ дэд төвийн гүйцэтгэлийн асуудал байгаад байгаа. Сэлбэ дэд төв дээр бонд бол өөрөө зарцуулах хэмжээ нь нийтдээ 500 сая доллартой тэнцэхүйц хэмжээний зарцуулалтын зарлага энэ жил дээр ингээд бичигдчихсэн байж байгаа гэсэн үг. Эндээс нийслэлийн санхүүгээс нь бид тодруулга аваад, яг энэ хэмжээний мөнгө гарахаар байна гэдэг тэр зарлагыг нь үлдээгээд, үлдсэн хэсгийн зарлагыг бууруулсан. Өөрөөр хэлбэл зарцуулах эрх буурч байгаа гэсэн үг. Тэрнээс санхүүжилтийг нь бид нар татаж авч болохгүй. Бонд анх гаргасан тэр зорилтоороо зарцуулах ёстой. Нэг дэх нь.

Хоёрт нь, нийслэл болон бусад орон нутгийн аймгуудаас зардлууд нэлээн буурч байгаа. Энэ нь мөн урсгал зардал дээр бууруулж байгаа зарчмынхаа хүрээнд буураад явж байгаа шүү.

**П.Ганзориг:** Алтаншагай гишүүн тодруулъя.

**Н.Алтаншагай:** Энэ төрийн үйл ажиллагааны хэмнэлт, таналт хийж чөлөөлье, санаачилга арга хэмжээг санхүүжүүлнэ гээд энэ дотор байгаа шүү дээ. Төсвийн хэмнэлт болон таналтын үр дүнгийн урсгал зардлаас 443 тэрбум төгрөг, нийслэлийн үнэт цаасны санхүүжилтээс 758 тэрбум төгрөг л гэж байгаа юм. Яг энэ 758-ыг нийслэлээс татчихсан уу гэж байгаа юм. Дээр нь орон нутгийн үлдэгдэл гээд байгаа шүү дээ. Тэр дотор нийслэлээс хэдэн төгрөг ийшээ орчихсон бэ.

**П.Ганзориг:** 4 номер хариулъя. Сангийн яам Санжаадорж.

**М.Санжаадорж:** Нийслэлийн үнэт цааснаас татсан зүйл байхгүй. Энэ жилийн зарцуулах хэмжээний зардлын эрхийг нь үлдээгээд, үлдсэн эрхийг нь хассан. Өөрөөр хэлбэл, энэ Сэлбэ дэд төвийн бондын мөнгө бол нийслэл дээр би ойлгохдоо арилжааны банкн дээр дансанд нь мөнгө байгаа гэж ойлгож байгаа. Тэндээ бол тэр мөнгө нь байж байгаа. Нэг дэх асуудал нь.

Хоёр дахь асуудал нь, нийслэлийн хувьд өмнөх оны үлдэгдэл болон өмнөх онд зарцуулаагүй үлдэгдэл болон нэмж орлого олсон энэ хэсгээрээ зарцуулах зардлын хэрэгцээ шаардлага байгаа, тулгамдсан асуудлууд байгаа гэж ойлгож байгаа. 998 тэрбум төгрөгийг бол бид нар орон нутгийн энэ талд нь ерөнхий байдлаар бусад хөрөнгө оруулалт гээд тавьчихсан байгаа. Эндээс нийслэл бол хэчнээн төгрөгийн зарлага гаргах нь бид нарт саналаа одоогоор ирүүлээгүй байна.

Бид 998-ыг яаж гаргасан гэхлээр, нөгөө алдагдалтай тулгаад тавьчихсан байхгүй юу. Тэрнээс нийслэлийн хэрэгцээ нь үүнээсээ өндөр гэж ойлгож байгаа юм.

**П.Ганзориг:** Баатархүү гишүүн асуулт асууя.

**Ц.Баатархүү:** Сайн байцгаана уу. Монголчууд чинь хурлыг тэгээд энэ төрд байгаа хүмүүс фэйсбүүк дээр рийл их сайн хийдэг болчихоод байгаа шүү дээ. Хурал рийл 2-ыг л их сайхан хийнэ. Тэгээд энэ Байнгын хороон дээр энэ олон дарга нарыг ингээд авчраад суулгаад байх нь зөв байдаг юм уу, буруу байдаг юм уу. Бид нар бодмоор юм шиг байгаа юм. Нэг бол сайд нь суудаг, нэг бол Төрийн нарийн бичгийн дарга нь суугаад салбараа ингээд хариулаад явахгүй нэг их олон дарга суугаад үр дүн гардаггүй. Иргэд хэлээд байна шүү дээ. Та нар хэлэлцээд л байдаг, хэрэлдсээр л байдаг, үр дүн хаа байна л гэдэг юмыг нэхээд байна л даа. Тэгээд 1 зүйлийг энэ төрийн албанд ажиллаж байгаа хүмүүстээ бид нар тодорхой хэлмээр байна. Монгол Улс хамгийн их орлоготой жилээ энгийнээр зүйрлэвэл, хамгийн их цалин авсан тухайн жилд айл өрх хамгийн их өр тавьж байгаатай адилхан зүйл болж байна. Уул уурхайн баялгаа түүхэндээ байхгүйгээр хамгийн их борлууллаа, орлого боломжийн сайн орж ирлээ. Гэтэл төсвийн алдагдлаа 2 дахин нэмэгдүүлж байна. Нэг цагт энэ зүйрлэх юм бол 224 вагон нүүрс гарч байна. Монгол Улсаас 16 секундэд нэг вагон нүүрс гарч байна. Орлого байна, тэгээд бид нар орлогоо яаж зөв хуваарилах вэ гэдэг асуудлыг өнөөдөр ярьж байна. Тэгээд манай нийгмийн салбарынхан энд ирсэн байна. Нэг зүйлийг би асуумаар байна. Тэтгэвэр, цалин нэмэхийг бүгдээрээ дэмжиж байгаа. Өөр арга байхгүй. Гэхдээ зүйрлээд хэлбэл, байрныхаа түрээсийг азын сугалаагаар төлж байгаа юм шиг энэ жил ингээд нэмдэг. Цалин, тэтгэвэр тогтвортой нэмэгдэх ёстой. Дараа, дараагийн жилүүдэд ямар эх үүсвэрээс энэ цалин, тэтгэврээ шийдэж явах юм бэ. Компанийн үлдэгдэл, цэвэр ноогдол ашиг гэдэг жил болгон өөр байна шүү дээ. Өөр байна шүү дээ. Тухайн жилийн уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс шалтгаална. Бид нар бодит үнэнийг хүлээн зөвшөөрмөөр байна аа. Урд хөршийн гангийн үйлдвэрийн эрэлт буурвал, бидний орлого буурна.

Тэгэхээр 2027 оны төсвийг өргөн барьчихсан байна. Энэ цалин, тэтгэврийн төсөөллөө ямар эх үүсвэрээс, 2028 оныхоо төсөөллийг ямар эх үүсвэрээс тавих юм бэ гэдгийг нэгдүгээрт нь асуумаар байна.

Хоёрдугаарт нь, энэ боловсролын салбар байна. Бид нар энэ боловсрол гэхээр ер нь ингээд энэ ЕБС-д их анхаарах нь зөв. Нэмээд энэ их сургуулиа хаячхаад байх юм. Манай их, дээд сургууль хөгжөөд 70, 80 жил болж байна шүү дээ. Өнөөдөр оюутны төлбөр дээр л амьдардаг ийм их сургуулиуд болсон. Нөгөө судалгааны их сургууль, нөгөө олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай Монгол хүнийг бэлтгэх тэр их сургуулийг хаясан. Энэ боловсролын зээлийн сан юм уу, тодорхой хэсгийг нь энэ дэлхийн томоохон их сургуультай хамтарсан хөтөлбөр хийх бид нарын истаны орны жишээ байна. Бид нар жишээ авах дуртай Назарбаевын их сургууль гэдэг шиг Сингапурт байдаг сургуулийн жишээг авмаар байна. Энэ дэлхийн томоохон нэр хүндтэй сургуулиудыг Монголд байршуулаад, хамтарч ажиллаад энэ боловсролоо өөд нь татах энэ бодлого байна уу, байхгүй байна уу?

Гуравдугаарт нь, энэ цалингийн тухай бид нар ярьж байна л даа. Тэр нь хувийн хэвшлийн цалинг зах зээл тодорхойлж байна. Хувийн хэвшлийн энэ цалинтай өрсөлдөхүйц цалинг төр өгөхөөс өөр арга байхгүй. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Улсын сургуульд нэг сайн багш байна. Хэдэн жил ажиллалаа. Үр дүн гаргалаа. Хувийн сургуульд шилжлээ. Хувийн сургуульд

амжилттай ажиллах юм бол тэгээд хувийн хэвшил рүү шилжээд л явдаг шүү дээ. Бид нар сургуульд ажиллаж байгаа энэ багш нараа тогтоож чадахгүй байгаа.

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье.

**Ц.Баатархүү:** Тэгэхээр энэ цалингийн реформ дээр, ингээд жил болгоны төсөв дээр ямар нэг хэсэг жагссан, жагсаагүй гэхгүйгээр тухайн салбарын зах зээлийн дундаж нийцүүлдэг байдлаар л нэг мөсөн шийдчихье. Хөдөлмөрийн яамныхан. Манай мэдээлэл технологийн салбарт Ай ти-гийн инженер яг энэ төрийн албаны цалингаар төрд ажиллахгүй шүү дээ. Үүнийг бүгд мэдэж байгаа шүү дээ. Өнөөдөр хамгийн өндөр цалин авч байгаа хэсэг уул уурхайд ажиллаж байна, мэдээллийн технологийн салбарт байж байна шүү дээ. Үүнийг тооцох хэрэгтэй. Эрүүл мэндийн салбар маш сайн хариулж байна гэж харж байна. Энэ цалингийн нэмэгдэлд энэ сувилагчдын асуудал орж байгаа юу?

Хоёрдугаарт, энэ төсвийн тодотгол дээр 3 дахь шатлал, 2 дахь шатлалын эмнэлгүүд дээр байгаа нөгөө эм ар ай аппарат, компьютер томографын аппаратууд чинь эвдэрчихсэн байна. Эмнэлгийг нь нэрлээд яах вэ. Үүнийхээ засвар үйлчилгээг оруулсан юм уу. Иргэд очоод шинжилгээ өгье гэхээр шинжилгээнийх нь тэр ийлдэс бүгдээрээ дууссан.

**П.Ганзориг:** Сангийн яамнаас хариулъя. 4 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Гишүүний асуултад хариулъя. Цалингийн бодлогын хувьд нэгдсэн бодлого дээр бид нар санал нэгтэй байгаа. Нэгдсэн бодлого өөрөө бол ижил төрлийн ажил хийж байгаа хүмүүст ижил төрлийн цалин олгох гэдэг энэ бодлого байгаа юм. Энэ нь өөрөө зөвхөн төрийн албан хаагчдаас гадна хувийн хэвшил энэ дээр оролцож байна гэж ойлгож байгаа. Тэгэхдээ түүчээлэгч нь хувийн хэвшил байх ёстой учраас 5 хувиар жаахан хувийн хэвшил нь илүү байвал зүйтэй гэдэг хууль бол өөрөө Төрийн албаны хуулийн зарчим дээр байж байгаа. Энэ дагуу бид явах нь зүйтэй байна гэж явж байгаа.

Нөгөө талдаа, бид нар урсгал зардал маань ингээд зарлагын бүтцийн хуульд нэлээд өндөр болоод байгаа. Нөгөө талдаа хөрөнгө оруулалтын зардал багасаад байдаг. Гэтэл орлого маань тогтвортой байж чадах уу гэдэг асуултыг та асууж байна. Төрийн өмчийн компанийн яг энэ шинээр батлагдсан ирэх жилээс мөрдөж эхэлж байгаа энэ хуулиар бол ноогдол ашиг өөрөө 30-аас доошгүй байна гэдэг ийм заалт орчхоод байгаа юм. Нөгөө талдаа, энэ ТӨК-удын нийт балансын тэр актив хөрөнгийнх нь үнэлгээ ДНБ нь 70 хувь буюу 70 их наядаас дээшээ гарчхаад байгаа юм. Тэгснээ өр төлбөр нь дахиад 40 их наяд гэхчихсэн ийм том дүнтэй яваад байгаа юм. Тэгэхээр энэ компаниудыг бид нар ашигтай ажиллах ёстой гэдэг зүйлийг ярьж байгаа. Ашигтай ажиллуулах нь бол жишээ нь уул уурхайн компанийн хувьд Эрдэнэс Монгол гэж энэ нэгтгэлийг байгуулсан гол зорилго нь тэр гэж бид ойлгож байгаа. Тэгэхлээр энэ дагуугаа ашигтай ажиллана.

Нөгөө талдаа бид нар бол төсвийн орлогыг бүрдүүлэхдээ татварын орлого, татварын бус орлогын харилцаа 90:10 гэсэн харьцаатай байгаа. Хэрвээ ТӨК-ийн энэ орлогыг бид нар оруулж ирэх юм бол 80:20 луугаа орох боломжтой гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл, орлогоо төрөлжүүлэх нь бидний хувьд илүү чухал байгаад байна гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Дээрээс нь, бид нар энэ тодотголыг хийж байгаа нь төсвийн жил дуусах дөхчихсөн энэ цаг хугацаанд тавьсан зорилго маань

тодорхой богино хэмжээний ийм тодотгол хийж байгаа. Том хэмжээний асуудлуудыг бид нар энэ тодотголоор шийдэж чадахааргүй байгаа.

Өмнө нь танилцуулж байсан гол нь инфляцын өсчихсөн байгаа 13 хувийн энэ инфляцад нөгөө цалин хөлс, тогтмол орлого буюу тэтгэвэр нэмэгдэж хасагдахгүй шүү дээ. Энэ чинь тогтмол байгаа, энэ идэгдээд байгаа энэ орлогоо хамгаалах, энэ иргэдийгээ хамгаалах асуудал. Дээрээс нь бид нар удирдаж чадах энэ инфляцаа яаж бууруулах вэ гэдэг энэ асуудал дээр илүү харж ингээд ажилласан байгаа. Сувилагчийн цалинг бид нар нэмэгдүүлэхээр угаасаа орчихсон байгаа.

Түрүүн Эрүүл мэндийн хөгжлийн төв дээр яагаад 5 тэрбум төгрөгийн цалин нэмчихсэн бэ гээд асууж байсан. Тэн дээр нэг мөр хариулчихъя. Тэн дээр нөгөө резидент эмч нарын цалин байгаад байдаг. Резидент эмч нар маань бол өөрсдөө бол яг сургуулиа төгсчихсөн, тэгээд нарийн мэргэших гээд ажиллаж байгаа. Эмнэлэг дээр бол хамгийн гол ажлуудыг нугалж байгаа хүмүүс учраас бид нар энэ хүмүүсийг мартаж болохгүй. Цалинг нь нэмээд ингээд явж байгаа зүйл байгаа. Баярлалаа.

**П.Ганзориг:** Боловсролын яам, 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Баатархүү гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн их сургуулиудыг сургалтын төлбөрөөс шууд хамаарлын хувь хэмжээг бууруулах, их сургуулийг чанартай тийм төрөлжсөн сургалтууд явуулах, академик болон санхүүгийн эрх чөлөөг бий болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх чиглэлээр дэмжих бодлогыг хэрэгжүүлж эхэлж байгаа. Энэ нь нэлээн эрчимтэй явна. Төрийн хувьд улсын төсвөөс хариуцах ашиглалтын зардал болон эрдэм шинжилгээний зардлын татаасыг 2023 онд баталсан хуулийнхаа дагуу олгож байгаа. Энэ сайдын хөтөлбөр арга хэмжээн дээр суугаад явж байгаа. Үүнийг бид нар тогтвортой олгох чиглэл дээр анхаарч байна. Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгох хуулийн төслийг бид нар боловсруулчихсан. Засгийн газраар үүнтэй холбоотой танилцуулгаа оруулаад, тун удахгүй энэ хуулийн төслийг ондоо.

**П.Ганзориг:** 9 номер гүйцээж хариулъя.

**Т.Ням-Очир:** Ондоо багтааж өргөн барих энэ бэлтгэл ажил зохион байгуулалтууд хийгдэж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

**П.Ганзориг:** Эрүүл мэнд дээр нэмж хариулах уу 6 номерын микрофон.

**Н.Эрдэнэбаяр:** Баатархүү гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Тоног төхөөрөмжийн асуудлууд ер нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар манай Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар дээр яг энэ хамаарагдаж явж байгаа бодлогын асуудлууд. Тэгэхээр энэ дээр бид нар ойрын хугацаанд бодлогын энэ баримт бичгүүдийг боловсруулах чиглэл дээр ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл, бид нар маш олон ийм үнэтэй тоног төхөөрөмжүүдийг авч байгаа. Хамгийн гол нь үүний засвар үйлчилгээний асуудлууд эрүүл мэндийн салбар дээр их тулгамдаж байдаг. Тэгэхээр үүнийг бид нар бодлогын хүрээнд яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр тооцоо судалгаанууд хийгдээд явж байгаа. Яг өнөөдрийн явж байгаа түвшин дээр Эрүүл мэндийн яам энэ дээр энэ эвдэрсэн аппаратуудын тусламж үйлчилгээг тухайн байгууллагын төсөвт нь зохицуулалт хийх байдлаар явж байгаа. Мөн ерөнхий зарчим нөгөө оношийн хамааралтай бүлэгт энэ тоног төхөөрөмжийн

зардлуудыг шингээж ингэж тооцож явдаг, ийм л зүйл байж байгаа. Яг өнөөдрийн байдлаар улсын 2 дугаар эмнэлэг дээр байдаг улсын хэмжээнд яг улсын салбар дээр байгаа энэ петситгийн.

**П.Ганзориг:** 6 номер гүйцээгээд хариулъя.

**Н.Эрдэнэбаяр:** Пэтситигийн засвар үйлчилгээ улсын төсөв дээр дангаараа тавигдаж явдаг. Тэгэхээр цаашдаа бид нар энэ яг хаанаа явбал хамгийн зохистой вэ гэдэг энэ судалгаанууд хийгдэж байгаа. Тэгээд энд ирэх жилүүдээс нэлээн шийдэгдээд явна гэж хэлэх байна.

**П.Ганзориг:** Баатархүү гишүүн тодруулъя.

**Ц.Баатархүү:** Энэ төрийн сайдын хэлсэн үг шууд ингээд л биелдэг гүйцэтгэлтэй л байх хэрэгтэй. Тэгээд хувийн сургуулиудын төлбөрийг хуваах зарчмаар явна гээд Боловсролын сайд амлаж байсан. Энэ жил хувийн сургуулиуд бүгдээрээ л төлбөрийг нь бүтнээр нь авч байна. Тэгээд сайд нь үг хэлэхээр, энэ төрийн нарийн, аппарат нь сайдынхаа хэлсэн үгийг биелүүлэх гэж ажилладаггүй юм шиг байгаа юм. Эсвэл сайд нь ямар ч судалгаагүй хэлдэг юм уу, тийм зүйл байгаа шүү. Боловсролын сайд, энэ боловсролын салбар ингээд попоор ажил хийж болохгүй, бодлоготой байх ёстой, хамгийн их бодлого гаргах ёстой гэдгийг хэлье. Эрүүл мэндийн салбар дээр энэ үнэтэй тоног төхөөрөмж аваад, энэ нь эвдэрдэг, үүнийх нь засвар үйлчилгээг яг тогтмол шийдэж явах ёстой юм байна билээ шүү. Үүнийг анхаарах ёстой.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн салбарт нэг зүйлийг хэлье. Та нар ингээд нэг их олон хүний үзлэг хийх тухай ярих юм. Яг зөв менежмент нь эрт илрүүлгийг хэдийг хийв, хэдэн хүнийг оношлов, хэдийг эмчлэв.

**П.Ганзориг:** Эхлээд Боловсролын яам хариулъя. тэр хувийн сургуулиудын төлбөрийг бүтэн жилээр нь авахгүй ээ. Хувааж төлөх ёстой гээд Боловсролын сайд хавар байхаа мэдэгдэж байсан. Тэгээд энэ ийм хуулийн зохицуулалт боломж нь байгаа юм уу. Байхгүй байхад нь хий хоосон иргэд олон нийтэд хүлээлт үүсгээд байдаг юм уу? 9 номер дээр Ням-Очир дарга маш тодорхой хариулаадах. Хууль, тогтоол ийм юм гарсан юм уу? Хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу? нэмэлтээр хариулъя.

**Т.Ням-Очир:** Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын тухай хууль дээр эцэг эх, асран хамгаалагч, сургууль, багш гуравласан гэрээ байгуулах ийм зохицуулалт байдаг. Энэ гуравласан гэрээний загварыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу манай Боловсролын ерөнхий газар баталж мөрдүүлэхээр байгаа. Энэ заалт дээр бид нар хэрвээ суралцагчийн сургалтын төлбөртэй холбоотой асуудал үүсэхээр бол энэ асуудлыг заавал энэ гуравласан гэрээнд тусгана гэж ийм зохицуулалтыг оруулсан байгаа. Дээрээс нь сая асуусан асуулттай холбоотой сайдын албан ёсны тушаал гарсан. Тэгэхээр бид нар хэрвээ сургалтын төлбөрийг нэмэх гэж байгаа бол эцэг, эх, асран хамгаалагчид энэ асуудлаар хичээлийн жилийнхээ дуусахаас өмнө дор хаяж 3 сараас өмнө мэдэгдэх.

**П.Ганзориг:** нэмээд 9 номероо гүйцээж хариулъя.

**Т.Ням-Очир:** Эцэг, эх, асран хамгаалагчийн гаргасан хүсэлтийн дагуу улирлаар хувааж төлөх боломжийг олгох, үүнийгээ байгуулах гэрээнийхээ заалтад тусгах. Ийм холбогдох тушаал шийдвэрүүдийг 2026 оны 5 сард гаргасан. Энэ тушаал гарахаас өмнө гэрээ байгуулагдчихсан төлбөрөө төлчихсөн ийм асуудлууд байсан. Үүнтэй холбоотойгоор гомдол, саналууд ирсэн. Энэ дээр нэгэнт тушаал шийдвэр гарахаас өмнө гэрээ контрактууд байгуулагдаад явчихсан учраас бид нар холбогдох мэдээ мэдээллүүдийг өгсөн. Харин тушаал шийдвэр гарснаас хойш асуудлууд үүссэн тохиолдолд бид нар сургуулиудтай уулзаад, эцэг, эх, асран хамгаалагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох арга хэмжээ аваад явж байгаа.

**П.Ганзориг:** Тэгэхээр 2026 оны 6 дугаар сарын 2-нд гарсан тушаал, түүнээс хойшоо мөрдөгдөнө гэж ойлголоо шүү дээ тийм ээ. Тэгэхгүй иргэд, олон нийтэд хүлээлт үүсгэчихдэг. Тэгээд энэ иргэдийн төлбөр төлөх, энэ хувийн сургуулийн төлбөрүүд айл өрхөд нэлээд том хэмжээний санхүүгийн ачаалал өгч байгаа. Энэ төлөвлөлтөд нь буруу ойлголт, нөлөөлөл үзүүлдэг асуудлууд байгаа. Ингээд нэг мөр тодорхой болж байгаа юм байна гэж ойлголоо.

Хосбаяр гишүүн асуулт асууя.

**Г.Хосбаяр:** Өчигдөр писа үнэлгээ танилцуулсан, үр дүнгүүдийг тодорхой хэлж байна. Тэгэхээр энэ үр дүнгүүдийг ер нь Боловсролын яам энэ бодлого үйл ажиллагаандаа онцгойлон авч үзэж ажилладаг байлгүй дээ гэж ингэж бодож байна. Тэгээд бид нар чинь энэ 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгож зарласан. Тэгээд энэ боловсролыг дэмжих жилийн хүрээнд бодлогын ямар том өөрчлөлт юу, юун дээр ямар ахиц дэвшил гарав гэдгийг би Боловсролын яамнаас асуумаар байна. Нэг талдаа багш ажилчдынхаа цалинг нэмчихдэг юм байж. Нөгөө талд нь, дамаа хөдөө орон нутагт энэ боловсролын байгууллагын тоног төхөөрөмж, барилга байшин шинээр барих, их засвар хийх зэрэг ингээд маш их асуудлууд байгаа. Тэгээд ноднин төсвийн хуулийг дагаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуульд өөрчлөлт оруулъя гээд оруулж ирсэн, Засгийн газар. Тэгээд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн энэ өөрчлөлтийг л хийчихвэл хувийн хэвшил юм хийгээд ийм болчихно гээд байсан. Тэгээд тийм юм байхгүй. Одоогоор ямар ч ахиц дэвшил байхгүй байгаа. Тэгэхээр энэ боловсролын жилд Боловсролын яам энэ яг энэ хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, суурь энэ материаллаг бааз талд яаж анхаарч, ямар бодлогын өөрчлөлт хийж ажиллав гэдгийг асуумаар байна.

Сая Баатархүү гишүүний ярьдаг, хувийн сургууль эцэг, эхтэй гуравласан гэрээ хийсэн гэдгээр бүтэн жилийнхээ төлбөрийг ингээд хүүхдүүдээс аваад, энэ ард иргэдэд, айл гэрт ингээд санхүүгийн дарамт үзүүлээд байна гэж ингэж хараад байна л даа. Тэгээд энэ дээр ямар ч өөрчлөлт байхгүй байна билээ. Бүх хувийн сургуулиуд ер нь наад тушаалыг чинь биелүүлж байгаа газар байгаа юм уу. Энэ дээрээ нэг тодорхой хэлээч. Тэгэхгүй бол дараа оны 3, 4 сард хүүхдийн сурах сургалтын төлбөрийг урьд оны 8 сард авдаг, 6 сард авдаг нь ямар учир байдаг юм бэ. Энэ дунд чинь ний нуугүй хэлэхэд мөнгө угаалт байгаа шүү. Хувийн сургуулиуд өр тавьж, байшин барилга, сургуулийн барилга барьчхаад, тэрийгээ 8 сард өр зээлээ төлдөг. Тэгээд энэ дундаас чинь эрсдэл гараад, дараагийн 3, 4, 5 сард сурах хүүхдийнхээ багш нарын цалинг тэр сургууль яаж өгөх гээд байгаа юм. Ямар орлого олж өгөх гээд байгаа юм. Тэгэхээр ийм их эрсдэлүүд байгаа учраас энэ тушаал, шийдвэрийнхээ биелэлтэд онцгой анхаарч ажилламаар байна.

Дараа нь дахиад Эрүүл мэндийн яам ирэх жилийг дахиад эрүүл мэндийг дэмжих жил болгоод, Засгийн газар зарлах гэж байна. Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн яам ер нь ямар төлөвлөгөө, ямар тооцоо судалгаа, бодлоготой байна вэ? Ер нь энэ салбарыг дэмжих жил болгож зарлаж байгаа дээр ер нь эртнээс төлөвлөж байгаад, яг нэг бодитой барьцтай томоохон асуудлуудаа бодлогын түвшинд шийдээд явдаг. Ийм байхгүй бол нэг хий хоосон амлалт өгч, зарлаад тэгээд ямар ч үр дүн байхгүй, ямар ч шийдсэн асуудал байхгүй ингээд яваад байна л даа. Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн яам бодож байгаа, төлөвлөж байгаа юм байвал хэлээч.

Боловсролын яам тэр писа үнэлгээнийхээ үр дүнг нэлээн сайн үйл ажиллагаандаа, цаашдынхаа төлөвлөгөөнд тусгаж явах байх гэж ингэж харж байна. 2022 онд хийсэн, сая 2025 онд ингээд 2 дахиа хийсэн байна. Нэг их айхтар үсрэнгүй ахиц дэвшил өөрчлөлт гараагүй байна билээ. Тэгэхээр үүнийгээ яаж ер нь цаашдаа ахиулж, ахиц дэвшил гаргах вэ. Яаж энэ үнэлгээгээ ахиулах вэ гэдгийгээ сайн тооцоорой гэж ингэж хэлмээр байна. Эд нар дээрээ хариулт авъя.

**П.Ганзориг:** Боловсролын яам 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Хосбаяр гишүүний асуултад хариулъя. PISA үнэлгээний 9 дэх мөчлөг 2025 онд зохион байгуулагдаж, Монгол улс 2 дахь удаагаа PISA үнэлгээнд хамрагдлаа. 15 настай 7146 суралцагч Монгол Улсыг төлөөлж писа үнэлгээг өглөө. Байгалийн ухааны ай дээр манай сурагчдын гүйцэтгэл 12 оноогоор ахисан. Ийм тодорхой ахиц үзүүлсэн 10 гаруй орны нэгд Монгол улсад нэрлэгджээ. Үүнийг бид нар сайн амжилттай гэж харж байгаа. Монгол хэл буюу унших чадвар, математикийн айд дээр 2022 оны түвшнээ тогтвортой хадгалсан байна гэсэн ийм үзүүлэлтийг авсан. Гэхдээ үүнийг бид нар илүү цаашаа нарийвчилж судлах болно. Ингээд писа үнэлгээнийхээ үр дүнг бид нар Засгийн газрын хурлаар танилцуулна. Энэ үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх бодлогоо танилцуулна. Мөн Байнгын хорооны хурал дээрээ орж ирж дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулга өгч, бодлого чиглэлээ тодорхойлох зүйлээсээ Байнгын хорооны гишүүдээсээ чиглэл, зөвлөмж авч ажиллах болно гэдгээ албан ёсоор хэлье.

Боловсролын сайд яг энэ Франц улсад OCD буюу ЭЗХАХБ-ын холбогдох удирдлагуудтай уулзаж энэ писа үнэлгээнийхээ үр дүнтэй холбоотой бодлогын том уулзалтуудыг хийж байгаа, энэ цаг мөчид. 2026 оныг боловсролыг дэмжих жил болгож зарласан. Хамгийн гол зүйл бид нар ЕБС дээр хөтөлбөрийн шинэчлэлээ эхлүүлээ. Тэгэхээр хөтөлбөрийн шинэчлэлийг бид нар зөвхөн хөтөлбөр гэдэг талаас нь биш багшийн арга зүй, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцөл, санхүүжилт гээд ингээд цогцоор нь харж байгаа. Тийм учраас цаашдаа хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ ийм цогц эко систем байдлаар хийдэг болно гэж. Ингээд хөдөлмөрийн менежментийн том цикл эхэлж байна. Багшийн 3 тулгуурт бодлогыг бид нар зарласан. Багшийн 3 тулгуурт бодлогын хүрээнд багш бэлтгэх тогтолцоогоо эхлүүлэхээс эхлээд саяын таны хэлдэг нийгмийн баталгаа цалин хөлс, хангамжтай нь холбоотой. Тэгээд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангаж байх чиглэлээр ингэж цогцоор нь асуудлуудыг харж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл, танхимын сургалт буюу багш нарыг танхимд авчирч сурахаас илүү сургуульд суурилсан энэ багшийн тасралтгүй хөгжлийн шинэ тогтолцоо илүү цаашаа боловсронгуй болоод явна гэдэг ийм шинэчлэл багш дээр хийж байгаа.

Дараагийнх нь хот, хөдөөгийн ялгааг арилгах буюу сургуулийн бүтцийн шинэчлэлийг боловсролыг дэмжих жилийнхээ хүрээнд бид нар эхлүүлж байна. Сум

дундын сургууль, төрөлжсөн ахлах сургууль, гэрт ойр сургууль буюу хотхон хороолол байрлах сургууль гээд. Ингээд энэ агуулгаараа сургуулиудыг илүү төрөлжүүлж илүү ээлтэй аюулгүй байлгах чиглэлээр ажиллана гэж харж байгаа.

Дараад нь цахим шилжилт дээр том бодлогууд эхэллээ. Хүүхэд бүрд оногдох тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхээс эхлээд. тэгээд дэд бүтэц.

**П.Ганзориг:** Гүйцээж хариулъя 9 номер.

**Т.Ням-Очир:** Сургалтын зориулалтаар ашиглаж байгаа цахим платформуудыг ашиглах чиглэлээр энэ цахим шилжилт дээр нэлээн том өөрчлөлт гарч эхэлнэ. Өөрөөр хэлбэл, багш бүр хиймэл оюуны туслахтай болох. Суралцагч бүр хиймэл оюуны туслахтай болохоос эхлээд өөрөөр хэлбэл технологийг боловсролд зөв зүйтэй ашиглах, технологи зөв ашиглаж чаддаг. Үүнийгээ шүүмжлэл сэтгэлгээгээр сургалт үйл ажиллагаандаа авч хэрэглэж явдаг энэ зүйлийг бид нар цахим шилжилтийн хүрээнд эхлүүлж байгаа.

Дараад нь үнэлгээний тогтолцоо буюу ер нь писа үнэлгээнийхээ 2 дахь үр дүнг хүлээж аваад маш том дата сантай болчихлоо. Энэ дата сангаа цаашаа бодлого дээрээ яаж авч явах вэ? Ялангуяа энэ хот, хөдөөгийн ялгааг бууруулах, тэгээд нийгэм эдийн засгийн үзүүлэлттэй холбоотой энэ гайпуудыг цаашаа яаж бодлогын түвшинд авч явах вэ, санхүүжилтээ яаж үүнтэйгээ уях вэ гэдэг дээр нэлээн том шинэчлэл гарна гэж харж байгаа. Тэгээд хамгийн гол нь Засаглал менежментийн асуудал дээр шинэчлэлүүд хийгдэнэ. Баярлалаа.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн яам хариулъя 6 номерын микрофон.

**Н.Эрдэнэбаяр:** Хосбаяр гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. ЭМЯ-аас 2027 оны Эрүүл мэндийг дэмжих жил болж байгаатай холбоотой 4 үндсэн зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөж, ингэж бид нар батлуулж ажиллаж байгаа. Энэ хүрээнд бид нар гол нь өрхийн болон төрийн эрүүл мэндийн зардлыг бууруулах, өвчлөлийн хүндрэлээс сэргийлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна гээд. Тэгээд энд үндсэн гол гол концепцууд нь нэгдүгээрт нь, бид нар архаг өвчтэй иргэдийн эмчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх энэ асуудлыг цогцоор нь харж, ялангуяа эмийн зардлын дарамтыг бууруулах дээр онцгойлон анхаарч ажиллана гэдэг зорилтыг тавьж байгаа. Ялангуяа хөнгөлөлттэй эм хэрэглэж байгаа 873 мянган зорилтот ийм бүлгийн хүмүүс байж байгаа. Тэгээд энэ дээр бид нар 584 мянга буюу 67 орчим хувьд нь энэ артерийн даралт, цусны бүлэглэлтээс сэргийлэх болон чихрийн шижингийн эмийг хэрэглэж байгаа. Эмчилгээгээ тогтмол хэрэгжүүлснээр цаашдаа эрүүл мэндийн салбарт ирж байгаа зардлыг бууруулах боломжийн тогтолцоо бүрдэнэ гэж.

**П.Ганзориг:** 6 номер гүйцээж хариулъя.

**Н.Эрдэнэбаяр:** Хоёрдугаарт нь, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлд арга хэмжээний төлөвлөгөөг тусгасан. Эрүүл мэндийн цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоог өргөжүүлж, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулж, иргэний шинжилгээний хариуг солилцдог, өвчний түүх зэрэг мэдээллийг тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд шаардлагатай үед цахимаараа харж чаддаг энэ боломжуудыг бүрдүүлнэ. Тэгээд энэ

дээр төрийн байгууллагуудын бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтыг бодит мэдээлэлд тулгуурлан шийдвэрлэх энэ нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.

Гуравдугаарт нь, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үр дүнг нэмэгдүүлж, илэрсэн эрсдэл өвчлөлийг эмчилгээ болон эмчийн хяналттай холбох тогтолцоогоор нь сайжруулъя гэдэг энэ зорилтыг тавьж байгаа. Зөвхөн үзлэгт хамрагдсан хүний тоог нэмэгдүүлэх бус эрт илрүүлгийн үр дүнд иргэдийн эрүүл мэндэд гарч байгаа бодит өөрчлөлтийг үнэлнэ гэдэг ийм гол санаа байж байгаа.

Дөрөвдүгээрт нь, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг тасралтгүй хөгжлийг дэмжинэ гэдэг.

**П.Ганзориг:** Хосбаяр гишүүн тодруулъя.

**Хосбаяр:** Ням-Очир даргыг ойлгож байгаа. Та энэ ажил дээр ирээд нэг их удаагүй байгаа байх. Анхнаасаа энэ боловсролын жил болгож зарлах, эрүүл мэндийн жил болгож зарлахын утга агуулга нь юу юм бэ. Эсвэл жилд заавал нэг салбарын нэр дурдаж байх ёстой юм уу, эсвэл энэ Засгийн газар чинь зорилго, зорилт тавиад яг нэг ийм асуудлыг шийдье. Боловсролын салбарт өчнөөн олон асуудал байгаа шүү дээ. Багш, ажилтнуудын цалин хөлсний асуудал, тэр барилга, тоног төхөөрөмж, их засварын асуудал, энэ сургалтын агуулга, цахим шилжилт, тэгээд саяын энэ санхүүгийн, тэр хувийн сургуулиуд өчнөөн олон мянган хүүхдүүд сургуулийн сургалтын төлбөрөө урьдчилж төлж байгаа ч гэдэг юм уу. Ингээд өчнөөн олон асуудлууд байхад яг ямар зорилгоор энэ яг тэр боловсролын жил болгож зарласан юм бэ? Энэний утга агуулгыг ер нь мэдэж байгаа юм уу? Үүнийг нэг хэлээд өгөөч.

**П.Ганзориг:** Боловсролын яам, 9 номерын микрофон нэмэлтээр хариулъя.

**Т.Ням-Очир:** Мэдээж улс орны хамгийн чухал боловсролын салбар. Тийм учраас боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалт, санхүүжилт, боловсролын бодлого чиглэлийг илүү тодорхой болгож сайжруулах, хүртээмж чанарыг нэмэгдүүлэх ийм зорилгоор боловсролыг дэмжих жил болгож зарласан. Энэ агуулгаараа ялангуяа төвлөрсөн төв суурин газар ачааллыг бууруулах, анги дүүргэлтийг бууруулах, илүү сургалтын таатай орчин нөхцөлд хүүхэд залуучуудыг сургах, шаардлагатай тоног төхөөрөмж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээнүүд хэрэгжсэн. Тийм учраас боловсролд хэрвээ бид нар энэ боловсролыг дэмжих жилд зөв сууриудыг тавигдчих юм бол дараа дараагийн жилүүдэд боловсролд зарцуулах төсөв, санхүү тогтвортой байх, бодлого тогтвортой байх ийм суурь нөхцөл бүрдэнэ гэж харж байгаа.

**П.Ганзориг:** Саранчулуун гишүүн асуулт асууя.

**О.Саранчулуун:** Сайн байцгаана уу. Өчигдрийнхөө яриануудаа үргэлжлүүлэе гэж бодож байна. Өргөдлийн байнгын хороон дээр асуусан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар яриад, ингээд ухаад үзэхээр нөгөө хүрээний бузрыг дэлгэвэл далай гэдэг шиг ерөөсөө дуусахгүй юм. Уг нь 2 жилийн турш энэ дээр ажиллаад, тэгээд нэг жоохон өөр асуудлууд байна. Ингээд явчихъя гэхлээр ерөөсөө дуусахгүй байна. Зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн асуудал дээр анхаармаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв гэж байгууллага

байгаа, 2025 онд 1 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан байна. 2026 онд батлагдсан төсөв нь 1.3, 2026 онд тодотголоор 2.3 тэрбум болчихсон. Өөрөөр хэлбэл, баталсан төсвөөсөө 900 саяар бараг илүү зардал гарсан байна л даа. Би үр дүнг нь асуумаар байна. 2025 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүний ажил эрхлэлт маш бага байсан, 20 хувь хүрэхгүй байгаад байна. Тэгээд энэ 900 сая төгрөг нэмэгдээд нэлээн илүү гарсан юм чинь маш олон хүмүүс ажилд орсон байх ёстой доо. Хэдэн хүн ажилд орсон юм, хүмүүсийг ажилд оруулах процессоо задалъя. Яг яаж ажилд оруулдаг юм гэдгийг надад нэг мэдээлээдэх. Хэрвээ өнөөдөр хариулж амжихгүй бол Хөдөлмөр эрхлэлтийн сан, дэд сан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв зэргийг бүх төсөв задаргаатай нь ингээд албан бичгээр явуулах хэрэгтэй. Задлах хэрэгтэй. Тэгэхдээ заавал хариулна гэсэн үг шүү.

Дараагийн нэг асуудал байгаа. 2018 онд Монгол Улсын Засгийн газар нэг тогтоол гаргасан байгаа юм л даа. Энэ дээр байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэнд улиралд 60 мянган төгрөг өгдөг нэг ийм халамжийн үйлчилгээ байгаа. Ер нь халамжид 72 төрлийн үйлчилгээ байгаа. Эдгээрийн ихэнх нь ямар индексээр тооцдог вэ гэдэг нь тун тодорхой бус байгаа. Тэгэхээр асуух гээд байгаа юм л даа. Амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан тогтооно гэсэн байсан. Амьжиргааны баталгаажих доод түвшин нь хэзээ шинэчлэгдэх юм. 5 бүсээр хэзээ шинэчлэгдэх талаар хариуг яг тодорхой гарч байгаа юм. Тэгэнгүүтээ энэ нь өөрөө энэ 72 төрлийн мөнгөн үйлчилгээнээс амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан тогтоодог. Хэдийнх нь дүн өөрчлөгдөх юм. 2026, 2027 онд өөрчлөгдөх юмуу гэдэг тодотголд хариу хэрэгтэй. Яагаад гэвэл, та нар бод доо. Улиралд буюу 3 сард нэг удаа 60 мянган төгрөг авдаг, байнгын асаргаанд шаардлагатай хүн сар бүрийн 478 мянган төгрөг авч байна. Тэгээд нийгмийн халамжийн үйлчилгээ буюу нөгөө мөнгөн бус үйлчилгээ болоод ирэхээрээ тухай бүр тариф гаргана гээд, тариф нь тодорхой биш байх юм.

Тэгэхээр нэгдүгээрт, ингээд мөнгөн бусаар хүнийг хөл дээр нь босгох, хөгжүүлэх үйлчилгээг нь тодорхой дүн тавьж өсгөхгүй, урсгал зардал шүү дээ гээд ингээд явахгүй, мөнгөн үйлчилгээг нь нэмэхгүй. Тэгээд ажилд орох гэхээр ажил хөдөлмөрт оруулж байгаа үйлчилгээ нь тодорхойгүй ийм байхаар чинь энэ бүлэг хүн ам амьдралыг яаж даван туулах вэ. Энэ нийгмийн ийм хямрал дор. Тэгэхээр яг энэ 72 төрлийн үйлчилгээний хэд дээр нь хөдөлгөөн гарах вэ. Энэ үнийн өсөлт, энэ олон төсвийн өөрчлөлттэй холбоотойгоор яг энэ үйлчилгээний дүн ингэж өөрчлөгдөх тоо хэрэгтэй.

Гурав дахь асуулт нь, би энэ зун маш олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдтэй уулзсан. Тэгээд эцэг, эхчүүд асууж байна. Сонсголонгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төв дээр үйлчилгээ үзүүлээд ерөөсөө болохгүй байна гэж байгаа. Би нэг минутаа авчихъя.

Тэгэхээр тэр үйлчилгээ 5 хоног, 7 хоног, 14 хоног гээд л дуусчхаад байгаа болохоор яг утгаараа сэргээн засах явахгүй байна гээд байгаа. Үүний төсөв энэ жил яаж.

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье.

**О.Саранчулуун:** Тэгэхлээр нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ аваад Хятад руу маш олон хүмүүс явж байна. Эмчилгээнд явж байна. Бүх мөнгө цаасаа гаргаад хөл дээр нь босгочих гээд. Тэгээд Монголд хөл дээрээ босож чадахгүй

байгаа хүмүүс тэнд очоод хөл дээрээ босоод байгаа байхгүй юу. Тэгэхээр сэргээн засах энэ үйлчилгээний хүүхдийн сэргээн засах асуудал дээр мөнгийг нь гаргаад байгаа. Гэхдээ мөнгийг нь зарцуулж байгаа хүмүүс дунд нь маш их олон юм завааруулж байна. Үйлчилгээний төрөл чанар дээр ерөөсөө анхаарахгүй байгаад байна. Тэгээд маш их гомдол над дээр ирсэн байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төв дээр ч, тэр хүүхдийн сэргээн засах дээр ч тэр. Тэгэхээр тэр даргыг нь хэзээ сонгон шалгаруулах юм. Жилд нэг удаа томилдог журмаа барих юм уу, яах юм. Тэр уламжлалаар явах юм уу. Яг Засагтайгаа адилхан ингээд солигдоод, солигдоод, дунд нь энэ хүмүүсийн үйлчилгээ орхигдоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр яам ямар ажлууд хийх тухайгаа нэг тайлбарлаад өгөөч.

**П.Ганзориг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариулъя. 7 номерын микрофон.

**А.Даваажаргал:** Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар дээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ дэд сан жилийн 6 орчим тэрбум төгрөгийн санхүүжилттэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа. Энэ дэд сангийн үндсэн үйл ажиллагаа хөдөлмөр эрхлэлтэд зуучлах биш бэлтгэх үйл ажиллагааг эрхэлдэг. Хөдөлмөр эрхлэлтэд зуучилж байгаа үйл ажиллагааг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар дээрээ зохион байгуулаад явдаг. Энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үндсэн үйл ажиллагаа нийтдээ 4 чиглэлээр санхүүжилтээ гаргаад явж байгаа. Үүний нэг нь хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх буюу сургах ажил байгаа. Энэ хүрээнд 2026 оны хагас жилийн байдлаар 300 хүнийг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэж сургасан. Мөн хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйл ажиллагааг дэмждэг санхүүгийн дэмжлэг мөн хөнгөлөлтийг энэ дэмжих сангаас олгодог. Энэ дэмжих сангийн үйл ажиллагааг өдөр тутам эрхэлж явуулж байгаа байгууллага нь тэр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хариуцаж байгаа агентлаг үйл ажиллагаа явуулж байгаа.

Хоёрдугаарт нь, тэр Сонсголонгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн сэргээн засах үйлчилгээний төв ажиллаж байгаа. Тэгээд би сая энэ хурлаас өмнө өглөө энэ байгууллага дээр өөрөө очиж ажиллалаа. Нийтдээ 8 хөтөлбөр төвийн даргын тушаалаар хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Эрүүл мэндийн яамнаас 4 оноштой хүүхдүүдийг тэнд эмчилгээнд хамруулаад ажиллаж байна. 3 хэвтэн эмчлүүлэх тасаг, амбулаторийн үйлчилгээ мөн сэргээн засах 8 төрлийн үйлчилгээг энэ байгууллага хэрэгжүүлээд явж байгаа. Байгууллагын даргын хувьд нээлттэй сонгон шалгаруулалтаар томилогдоно. Үүрэг гүйцэтгэж ажиллаж байгаа. Энэ даргын сонгон шалгаруулалтыг зарлачихсан байгаа. Тэгээд энэ дээр өрсөлдөх эрх нь хүмүүст нээлттэй.

Ер нь байгууллагын үйл ажиллагааг нэлээн ил тод нээлттэй болгосон гэж би яамны зүгээс үзэж байгаа. Энэ байгууллага улсын комисс ч аваагүй, Хятадын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр баригдсан хэрнээ өнөөдрийг хүртэл зөөврийн устай, бохир нь соруулдаг ийм байдалтай явж байгаа. Тэгээд аж ахуй талаасаа эхлээд нэлээн шийдвэрлэх шаардлагатай зүйлс байгаа. Тэгээд үүнийг шийдвэрлэхийн төлөө ингээд ажиллана. Би өнөөдөр газар дээр нь очиж ажиллаад байгууллагын удирдлагуудад энэ үүрэг даалгавруудыг өгсөн. 2018 онд тогтоогдсон асаргааны тэтгэвэр, тэтгэмж зарим нь 2022 онд ч тогтоогдсон тэтгэвэр, тэтгэмжийн асуудлууд байгаа. Нийгмийн халамжийн хуулийн 18 дугаар зүйлд зааснаар энэ

амьжиргааны доод түвшинтэй уялдуулж шинэчилж өөрчилнө гэсэн ийм зохицуулалттай. Бид нарын одоо олгож байгаа асаргааны тэтгэмж болон

**П.Ганзориг:** 7 номер гүйцээж хариулъя.

**А.Даваажаргал:** Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгож байгаа нийгмийн халамжийн тэтгэвэр 478 мянган төгрөг байгаа. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгож байгаа амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 478 мянган төгрөг, асаргааны тэтгэмж 330 мянган төгрөг, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмж 484 мянган төгрөг. Таны ярьж байгаа тэр 2018 онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан асруулж байгаа иргэнд улирал бүр олгож байгаа тэтгэмж 60 мянган төгрөг, ахмад настан болон тэжээгч нь нас барсан 0-18 хүртэлх насны хүүхдэд 432 мянган төгрөгийг олгож байгаа. Энэ 2026 онд шинэчлэгдсэн. 2027 онд үүнийг шинэчлэхийн тулд амьжиргааны доод түвшинтэйгээ уялдуулах шаардлага үүснэ. Шинэчлэхийн тулд энэ нэлээн өндөр төсвийн ачаалал үүсэхээр ийм нөхцөл ажиглагдаж байгаа. Тэгэхдээ яам ямар бодлого барьж байгаа вэ гэхээр, тооны араас хөөцөлдөөд яваад байх биш Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөр эрхлэлт рүү.

**П.Ганзориг:** Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Дахиад тодруулчихъя. Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв баталсан төсвөөсөө 974.7 сая төгрөгийн илүү зөрөө гэж гараад байгаа байхгүй юу. Төсвөөс нь илүү хэтэрчихсэн байна гээд. Тодотголоор. Тэгэхээр 1 тэрбум төгрөгийн илүү зардал яагаад гараад байгааг тайлбарлаад өгөөч. Тэгээд 300 хүнийг хөдөлмөрт бэлтгэгдсэн гэхээр чинь 2026 оны тодотгол дээр байгаа энэ дүнг харахаар 2.3 тэрбум орчим төгрөгөөр 300 хүнийг хөдөлмөрт бэлтгэсэн гэсэн үг үү? Энгийнээр тооцоолох юм бол. Нэгж нэг хүн дээр хэдэн төгрөг оногдох вэ? Хэрвээ хөдөлмөр эрхлэлтийг зүгээр бэлтгэдэг юм бол тэр МСҮТ, сэргээн засалтын сургалтын төвүүд байдаг шүү дээ. Тэд нар чинь юу хийдэг юм. Тэд нараас энэ тэгээд ямар ялгаатай болж таарав. Байгууллага нь өөрөө.

**П.Ганзориг:** 7 номер хариулъя.

**А.Даваажаргал:** Нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төв нь өөрийн гэсэн тусдаа сан байхгүй нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сангаасаа санхүүжилт гаргадаггүй. Энэ сан нь өөрөө Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар дээр 106 тэрбум төгрөгөөр 2026 онд төсөвлөгдсөн энэ сангаас дэд сан болгож 5.9 тэрбум төгрөгийг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт рүү шилжүүлээд ингээд ажиллуулж байгаа. Тэр 2.3 тэрбум төгрөгийн 300 хүн гэдэг нь биш. Энэ санхүүжилтээр юу хийж байгаа вэ гэхээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэх, өөрөө бизнесийн үйл ажиллагаа явуулах бусад хүмүүсийг жишээлбэл оёдлын үйлдвэр байгуулж байгаа тохиолдолд энэ дэмжих сангаасаа хөнгөлөлттэй зээл авдаг. Санхүүгийн тусламж авдаг, нөгөөдөх нэг чиглэлийн үйлчилгээ нь тэр 300 хүнийг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх сургалтын үйл ажиллагаа болж тэр санхүүжилтийн нэг тоо зөрөөд байгаа асуудал энэ байгууллага дээр байсан МСҮТ-ийг Боловсролын яам руу шилжүүлсэн.

**П.Ганзориг:** Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Тэр Боловсролын яаман дээр байгаа МСҮТ тэгвэл хэнийг хөдөлмөрт бэлддэг юм нэгдүгээр асуудал. Боловсролын яам тэгвэл хариулчих. Дараа нь зээл олгодог гээд байх юм. Зээл чинь санхүүгийн үйлчилгээ шүү дээ. Тэгэхээр яагаад энэ хүмүүсийг бизнес эрхлэх зээл энэ тэрийг чинь банк санхүүгийн байгууллага л шалгуураар нь олгомоор байх юм. Гэтэл яагаад үүнийг яамны дэргэдэх энэ сангаас зээл гэж гаргаад байгаа юм. Дээрээс нь бизнесийг ямар ч туршлага байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс л юм чинь, энэ мөнгөөр гээд нэг оёдлын машин авч өгчхөөд, тэгээд тэрийгээ бизнес гэж нэрлээд тоог нь нэмээд, тэдэн хүнд зээл олгосон, тэдэн хүн ажилд орсон гэдэг ийм л тоо гарч ирээд байгаа байхгүй юу даа. Тэгээд үүнийгээ больчихооч. Эсвэл үүнийг нь тэр банк санхүүгийн байгууллага руу нь шилжүүлбэл яадаг юм. Ер нь та энэ дээр ямар бодолтой байдаг юм. Танай яамны яг бодлыг чинь би асуумаар байгаа юм. Дахиад асууя. Тэр МСҮТ тэгээд юу хийдэг болж таарав. Ялгаа нь юу юм бэ.

**П.Ганзориг:** Боловсролын яам 9 номер дээр хариулъя.

**Т.Ням-Очир:** Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Мэргэжлийн боловсролын сургууль, политехник, коллежууд батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөнийхөө дагуу тухайн ажил мэргэжлээр сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлж байгаа. Мэргэжлийн болон техникийн боловсролын энэ 70 орчим сургалтын байгууллагад ялгаатай хэрэгцээтэй тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй 633 суралцагч суралцаж байгаа. Энэ суралцагчдын тоогоор хувьсах зардал нь 3 дахин нэмэгдэж олгогддог. Энэ нь болохоор тухайн хүүхдэд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материалыг шийдэх, тухайн хүүхдэд хичээл сургалт удирдаж байгаа багшийн цалин хөлсөнд бодогдож олгогдох гээд ийм байдлаар зохион байгуулагдаж байгаа.

**П.Ганзориг:** 7 номер нэмж хариулъя.

**А.Даваажаргал:** Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ Сэргээн засах хөгжлийн төв дээр байсан Мэргэжлийн боловсролын сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв рүү шилжүүлчихсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг тэнд явуулж байгаа. Тэн дотроо дотуур байртай, сургалтын заал, танхимтай ийм байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа. Үүний санхүүжилт Боловсролын яамнаас шилжиж орж ирэх байсан боловч орж ирээгүй байгаа юм. Тэгээд энэ сангийн дүн тан дээр харагдаад байна гэсэн үг.

**П.Ганзориг:** Баясгалан гишүүн асуулт асууя.

**Ж.Баясгалан:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд яг энэ төсвийн тодотголоо оруулж ирчхээд салбарынх нь сайд нар, Сангийн сайд байхгүй байгаа нь маш учир дутагдалтай байна. Яг асуумаар байгаа юманд хариулах ёстой хүмүүс нь байхгүй байгаад байдаг. Би та нарт яг сонссон, Ерөнхий сайдын хэлсэн нэг үгийг хэлье л дээ. Монгол Улсын Засгийн газар олон түмэнтэйгээ зовлон, жаргал нэгтэй байж, үнийн өсөлтийн шуурганаас хамгаалахын төлөө өөрөөсөө хамаарах бүхнийг хийх үүргээ ухамсарлаж байна. Тийм ч учраас сайд нарын зардлаас 1.4 их наяд төгрөгийг танаж, 11 дүгээр сарын 1-ээс эмч, төрийн үйлчилгээний бүх албан хаагчийн цалинг нэмэх, ахмад настан бүрд баталгаа болгон шинээр суурь тэтгэвэр олгох зэрэгт зориулан 2026 оны төсвийн тодотголоо өргөн барилаа. Төсөв бол

эмнэлэг, сургуулийн тог, дулаан, эмч, багшийн цалин хөлс, хүүхдийн мөнгө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж юм аа. Төсвийн тоо бүрийн цаана монгол хүний цалин, тэтгэвэр тэтгэмж, монгол айлын ахуй амьдрал бий. Айл өрх амьдралын бодит нөхцөлдөө нийцүүлж орлого, зарлагаа тооцоолдог шиг улс орон ч төсвөө хэмнэлттэй, гамтай, хэрэгтэй зүйлд нь зарцуулах хэрэгтэй гэж тодотгодог.

2026 оны төсвийн тодотголын төсөл хүнээ бодсон шийдвэр юм гэж Улсын Их Хурал дээр Ерөнхий сайд танилцуулсан. Энэ хүнээ бодсон юм бол би нэг юмыг тодруулж асуумаар байна. Бүүр маш тодорхой хариулаарай. Төсвийн нэг хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж гэж хэлсэн шүү дээ. Гэтэл яагаад өнөөдөр энэ нийгмийн эмзэг хэсэг болсон 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгодог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэг ч төгрөгөөр нэмээгүй юм бэ. Яагаад, энэ хүмүүс жагсдаггүй болохлоор нь нэмээгүй юм уу? Эсвэл энэ хүмүүс санал өгч чадахгүй, санал өгөх үед нь тэр сонгуулийн байрыг нь орох боломжгүй тийм нөхцөлөөр нь хүртээмжгүй байдлаар нь хангадаг учраас эд нар хэрэггүй гэж үзээд нэмээгүй юм уу. Энэ хүмүүс чинь өнөөдөр амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч байгаа шүү дээ. Түрүүн хэлж байна. Амьжиргааны доод түвшнийг тэтгэвэр тэтгэмжтэй харьцуулж тогтоодог гэж. Тийм ээ, харьцуулж тогтоодог. Гэтэл өнөөдөр байгаа амьжиргааны 2026 оны доод түвшин чинь 543700 төгрөг. Улаанбаатар хотод. Тэгэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь өөрөө 484 мянган төгрөгийн тэтгэмж авч байна. Хүнд хэлбэрийн хүүхэдтэй иргэн шүү. Жирийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд 478 мянган төгрөг, үгүй энэ чинь хүнээ асарч байгаа тэр асрагчид 330 мянган төгрөг авч байгаа шүү дээ. Үгүй хаана байгаа юм бэ, нөгөө амьжиргааны доод түвшнээс уялдуулж нэмэх чинь. Хамгийн их халамж хэрэгтэй, хамгийн их төсөв тодотгоход шаардлагатай бүлэг чинь энэ юм биш үү.

Би үүнийг энэ амьжиргааны түвшинтэй уялдуулаач гэдгийг Сангийн сайд, Ерөнхий сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарт 5 сарын 13-ны өдөр албан бичиг өгсөн. Ингэхлээр тэр яамдуудад энэ очсон байх ёстой. Яагаад энэ уялдаагүй юм бэ? Төсөв тодотгож байгаа юм бол өнөөдөр хамгийн хүнд амьдарч байгаа иргэдээ яагаад орхиж байгаа юм бэ? Ноднин бид нар энэ талаар зөндөө ярьсан шүү дээ. Ерөнхий сайд тэр үед ирээд уулзаж байсан шүү дээ. Ирэх жил бүгдээрээ үүнийг хамтдаа давъя гэж.

Үгүй, тэгээд. 1 минутаа авчихъя.

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье.

**Ж.Баясгалан:** Үүнийг хийх боломжууд байгаа шүү дээ. Яагаад, нийгмийн халамжийн сангаас олгодог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, асрамжийн тэтгэврийг нэмээгүй вэ гэдгийг та нар бүүр яг хариулаадхаарай. Улсын төсвийн 36 ерөнхийлөн захиран зарцуулагчдад хязгаарлалт хийсэн. Гэхдээ энэ 36 биш, яг 19 дээр нь л хязгаарлалт хийсэн. Төрийн дээд албан тушаалтны гадаад томилолт хамаарахгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал бууруулаагүй байгаа. Ингэхлээр энэ үлдсэн 17 төсвийн ерөнхийлөн захирагчдын томилолт, зочин төлөөлөгчдийг хүлээж авах энэ асуудлаа болиод, энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргааны тэтгэмжээ нэмж болдоггүй юм уу? Энэ дээр яагаад салбарынх нь яам санаачилгатай ажиллаагүй юм бэ. Энэ төсөв дээр яагаад энэ иргэдийг орхисон юм бэ гэдгийг асуумаар байна.

**П.Ганзориг:** Эхлээд Сангийн яам хариулъя. Энэ төсвийн тодотголыг өргөн барихдаа Засгийн газраас баримталж байгаа нэг бодлого нь бол эмзэг хэсгийнхээ орлогыг үнийн дарамтаас хамгаалах гэсэн бодлого барьж байсан. Энэ дээр яагаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ энэ орлогыг хамгаалах бодлогын арга хэмжээ аваагүй вэ гэдэг дээр хариулаад, дараа нь холбогдох салбарын яам нь хариулъя. 4 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яам, Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр төсвийн тодотгол бол нэлээд хязгаарлагдмал хүрээнд хийж байгаа. Мэдээж хэрэг яг таны гишүүний хэлсэн тэр инфляцын цохилтод бид нар яаж хариу үйлдэл үзүүлэх вэ гэдэг дээр бол гол чиглэл явж байгаа. Ингэхдээ хэд хэдэн зарчим барьсан. Мэдээж хэрэг, хэрэгцээ шаардлага маш өндөр байсан. Ингэхдээ урсгал зардал дээр бид нар эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зардлаас нэг төгрөг ч хасаагүй. Дээр нь нэмээд бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зарцуулж байгаа зардлыг, дээрээс нь хүүхэд хамгаалалттай холбоотой зардлыг бол нэг төгрөг ч хасалгүйгээр ямар ч байсан оруулж ирсэн. Ингээд нэг талдаа хэмнэлт хийсэн, нөгөө талдаа энэ төсвийн тодотгол маань өөрөө ирэх жилийн төсөвтэйгөө маш холбоотой байж байгаа. Өөрөөр хэлбэл, ирэх жилийн 1 сарын 1-ээс эхлээд бид халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхээр тооцоод оруулаад ирчихсэн байгаа. Тэргүүн ээлжид бол 11 сарын 1-ээс цалин хөлс нь бол огт нэмэгдээгүй байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдыг бид нар оруулж ирсэн. Үүн дээр нэмээд бид нар эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг боловсролтой ижил түвшинд аваачихаар оруулж ирсэн. Орхигдсон зүйлүүд байгаа. Мэдээж хэрэг, гэхдээ энэ дээр төрийн тусгай, төрийн захиргааны албан хаагчдын цалинг яагаад нэмээгүй юм бэ гэдэг асуудал ярьж байна. Үүнийг ирэх оны 4 дүгээр сарын 1-ээс нэмэхээр хойшлуулж оруулж ирж байгаа юм. Энэ дээр мэдээж хэрэг, бид нар инфляцын эсрэг бодлогынхоо хүрээнд үе шаттайгаар яаж аль хэсгийг нь тэргүүн ээлжид, дараачийнх нь 2 дахь нь, 3 дахь нь ямар байдлаар ч гэдэг юм уу, ийм байдлаар уялдуулж орж ирсэн гэдгийг та ойлгоорой.

Нөгөө талдаа, бид нар хасах тэр эрэмбэд бол огт ийм зардлуудыг энэ зорилтот зардлууд оруулаагүй байгаа шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

**П.Ганзориг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 7 номерын микрофон.

**А.Даваажаргал:** Энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгож байгаа нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудал Баясгалан гишүүн ээ, энэ нэмэгдсэн. 2026 оноос нэмэгдээд, бид нар нэмэгдсэн тарифаараа олгоод явж байгаа. Жишээлбэл, би танд ингээд харьцуулсан тоонуудыг нь хэлэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн халамжийн тэтгэвэр 397500 төгрөг байсан. Өнөөдөр 2026 онд 478 мянган төгрөг болоод нэмэгдчихсэн байгаа. Тэр амьжиргааны доод түвшинтэй уялдуулна гэдэг хуулийн зохицуулалт байгаа. Тэрнээс амьжиргааны доод түвшинтэй адилтгах нь юм уу, тэнцүүлнэ гэсэн зохицуулалт байхгүй байгаад байгаа. Тэгэхээр бид нар яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгож байгаа нийгмийн халамжийн тэтгэврийг 20 хувиар нэмсэн санагдаж байна тийм ээ. Тэгээд бусад тэтгэмжүүдийг 8.6 хувиар нэмсэн. 2027 оны Төсвийн хууль дээр 10 хувиар нэмэхээр саналаа тусгаад ингээд явж байгаа. Тэгэхээр энэ асуудал яг амьжиргааг хамгаалж байгаа бүлгийн хүмүүст зориулаад тодорхой хэмжээгээр.

**П.Ганзориг:** Баясгалан гишүүн тодруулъя.

**Ж.Баясгалан:** Маш ойлгомжгүй байна аа. Нэгдүгээрт, Сангийн яамнаас тодруулъя. Инфляцын түвшнийг нөлөөлөхгүй арга хийхийн тулд тэр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмчихвэл инфляцын түвшин нэмэгдэх гээд байна гэж ойлголоо. Та дахин, дахин хэллээ шүү дээ. Бид нарын энэ хийсэн аргачлал инфляцын түвшнийг нэмэгдүүлэхгүй байх, энэ мөнгөний ханшийг унагаахгүй байх зорилготой гэж. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмжийг нэмчих юм бол инфляц өсчих гээд байгаа юм уу? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд наад асуудлыг чинь би өөрөө хөөцөлдөж байж оруулсан болохлоор маш сайн мэдэж байгаа. Би тодорхой юм асуусан шүү. 2026 оны төсөв чинь энэ өгч байгаа нэмэгдсэн мөнгө чинь тэр мөнгөндөө хүрэхгүй амьжиргааны доод түвшинд ирэх онд 10 хувь нэмээд ч хүрэхгүй шүү дээ. 2027 онд хэдээр төлөвлөсөн юм.

**П.Ганзориг:** Сангийн яам хариулъя. 4 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Тодорхой асуусан болохлоор тодорхой хариулъя Сангийн яам Санжаадорж. Тэгэхээр тэтгэврийг инфляцтай уялдуулж нэмэх, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулж нэмэх асуудлыг бид нар зэрэг авч явдаг. Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын цалин хөлсийг сүүлийн 2 жил нэмээгүй явж байгаа гэдгийг та мэдэж байгаа байх. Тэгэхлээр халамжийн асуудлыг бид нар 1 сарын 1-ээс нэмнэ. Төсөв орох болгонд, тодотгол орох болгонд эсвэл бид зөвхөн халамжийг нэмээд явах уу, үгүй юү гэдэг асуудал маань түрүүний ярьдаг амьжиргааны тэр баталгаажих доод түвшин, төсвийн маань бололцоо, энэ бүх зүйлтэй уялдах ёстой байх. Бид нар тодорхой нийгмийн нэг бүлэг сегментийг ялгаж авч байгаад шууд энэ дээр ийм бодлого хийнэ, энэ нь ийм байх ёстой гэдэг байдлаар яриад явах эрх нь танд байгаа байх. Засгийн газрын хувьд нэгдсэн төсвийн бодлогын хүрээнд бол би танд тайлбарлалаа.

**П.Ганзориг:** 7 номерын микрофон. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

**А.Даваажаргал:** 2026 онд санхүүжилтийн асуудлууд бүгд нэмэгдсэн. 8.6-20 хувийн хооронд нэмэгдсэн. 2025 оны 12 сарын 31-ний өдрийн Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор ингээд нэмэгдчихсэн байгаа. Гэхдээ яам ерөнхийдөө Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгыг бид нар өргөн бариад ингээд ажиллаж байгаа. Энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ үнэлэмжийн асуудлыг дахиж харахгүй бол нэлээн алдаатай, процессын хувьд ч гэсэн нэлээн төвөгтэй асуудлууд энэ өнгөрсөн хугацаанд үүсчихсэн байгаа.

Баясгалан гишүүн ээ. Тэгэхээр бид нар энэ дээр та бүхэнтэй хамтраад ажиллана. Энэ дээр яаж байгаа вэ гэхээр, ядаж чадамжийн үнэлгээг нь хийхгүй бол сонсголын бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй, хөдөлмөрлөх боломжтой хүмүүсийн тэтгэмжийг бид нар өсгөөд байх нь зөв үү, буруу юу? Ер нь энэ тэтгэмжийн асуудлыг нэмэхдээ тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний чадамжийн алдагдалтай нь уялдуулж нэмдэг ийм шинэ тогтолцоо руу орохгүй бол нэгдсэн байдлаар бүгдэд нь нэг тоогоор нэм.

**П.Ганзориг:** Гүйцээж хариулъя, 7 номер.

**Даваажав:** Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгож байгаа энэ тэтгэмжийг бид нар тооцохдоо хөгжлийн бэрхшээлийнх нь хөдөлмөрийн чадамжаа алдсан алдалтынх нь тэгээд хөдөлмөрлөх чадавхын үнэлгээг эхлээд нэгдүгээрт, зөв хийх шаардлагатай байгаа. Хөдөлмөрлөх чадавхтай хөгжлийн бэрхшээлтэй хүнд заавал тэр өндөр асрамж, тэтгэмж өгөөд байх шаардлага байхгүй гэж үзэж байгаа. Тэгэхээр үнэхээр хөдөлмөрлөх чадвараа алдчихсан, хөдөлмөрлөх чадваргүй, бие даан амьдрах чадваргүй хүмүүстээ тэтгэмжийн асуудлыг нэмэх нь зөв өө. Тэгэхээр ингээд бүгдийг нь зрителиэр нь, бүгдээр нь ингээд нийлүүлээд нэмчих нь өөрөө бодлогын хувьд алдаатай байгаад байна. Тийм болохоор бид нар халамжийн шинэчилсэн найруулга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын өөрчлөлтөөр энэ асуудлыг шийдвэрлэхээр зорьж байгаа.

**П.Ганзориг:** Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Өдрийн мэнд. Надад 3 цогц асуулт байгаа юм. Нэгдүгээрт, Сангийн яам ер нь товчхон дүгнээд хэлчихмээр байгаа юм. Санжаадорж дарга тийм, үгүйг гээд хариулчихмаар байна. 2026 оны төсвийн тодотгол орлого талаасаа 1.5 их наяд дутах юм байна. Тэрийг ТӨК-ийн ноогдол ашгаар санхүүжүүлжчихье. Зарлага талаасаа орон зайг гаргахын тулд ерөөсөө нийслэлийн бүсийг 2 дахин чангалж байна шүү дээ. Нийслэлийн үнэт цаасны 758 тэрбумын орон зай авъя. Мөн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардал орон нутгийн гэж байгаа. Орон нутаг ч юу байх вэ дээ нийслэл шүү дээ. Тэгэхээр нийслэлээс ерөөсөө 1.7 их наядын зарлагын орон зайг татаад л шилжүүлэг хийчхэж байна шүү дээ. Тэгэхээр нийслэлээ бүсийг нь 2 дахин чангалаад, ТӨК-уд ноогдол ашгийг нь татаад ингээд төсвөө тодотгож байгаа юм байна гэдэг ийм дүгнэлт хийе. Тийм, үгүйгээ л хариулчих хэрэгтэй нэгдүгээрт.

Хоёрдугаарт, манай орон шиг тэгээд шинжлэх ухааны хөгжлөө, ШУТС-ийн санхүүжилтээр хэмждэг орон ч байхгүй дээ. Тэгээд энэ дээр бүсээ чангалж байна гээд байсан. ШУТС дотор Үндэсний ШУТС гэж нэмж сан байгуулсан юм уу. Энэ дээрээ 11.5 тэрбумын нэмэлт орлого тавьсан байна. Боловсролын зээлийн сангаасаа хөөрхий 13.6 тэрбумыг хасчхаад, Үндэсний ШУТС гэж нэмж сан гаргаад, 11.5 гээд орж ирж болох юм уу. Хүүхдүүдийнхээ боловсролын боломжоос хулгайлангуутаа нэг ШУТС гэсэн нэр дор илүү мөнгө тавиад ороод ирчихсэн. ШУТС дотор илүү мөнгө тавьснаараа Монгол Улсын шинжлэх ухаан хөгжчихсөн үү. Чаддаг юм бол батлаад ирээрэй.

Гуравдугаарт, Боловсролын Зээлийн сан, Боловсролын яам 2025 оны төсвөө тодотгохдоо бид нар Боловсон зээлийн сангаас уг нь хасаагүй юм. Тэрийг Санжаасүрэн дарга сайн мэдэж байгаа. Бид нар хасаагүй. Түрүү жил тодотгол орсон ч гэсэн хасаагүй юм. Энэ жил 13.2 тэрбумаар хасчихжээ. Сая Төрийн нарийн бичгийн дарга хэлж байна, угаасаа хүнд байгаа гээд. Хүнд байгаа дээрээ хасчхаж. Тэгээд энэ зардлыг буцаад юу нэмж орж ирснийг бүгдээрээ харъя л даа. Нөгөө төсвөө бүсээ чангалсан гэсэн хаана байгаа юм. Боловсролын яам төсвөө 1.1 тэрбумаар нэмж орж ирсэн. Боловсролын үндэсний төв төсвөө 1.9 тэрбумаар нэмж орж ирсэн байна. Боловсролын газар төсвөө 1.3 тэрбумаар нэмж орж ирсэн байна. Боловсролын ерөнхий газар төсвөө 4.4 тэрбумаар нэмж орж ирсэн байна. Нөгөө Боловсролын яам чинь агентлагтайгаа нийлээд төсвөө 8.7 тэрбумаар нэмээд ороод ирж байна. Үүнийг чинь юу гэж ойлгох юм. Нөгөө боловсролын жил хаана байна. Боловсролын жил гэдэг чинь хэдэн дарга нарынхаа төсвийг нэмэх юм уу? Хүүхдүүдийнхээ боломжоос нь авангуутаа, боловсролын хэдэн агентлагийнхаа

төсвийг нэмж ордог энэ ямар учиртай юм. Энэ ямар хэний хаанахын логик вэ? Ингэж болох юм уу? Үүнийг хүлээн зөвшөөрөхгүй, энэ дээр зарчмын зөрөөтэй санал гаргаж бүсээ чангалж байгаа энэ агентлагууд бүсээ чангалаач. Тэгээд хэдэн хүүхдийнхээ боловсролын зээлийн сангийн мөнгөнөөс нь хусчихсан болов уу? Тэр Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлт хаана байна. Би хэлж байгаа шүү дээ. Боловсролын сайд болон Боловсролын төрийн нарийн бичгийн даргын ажлыг Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлтөөр хэмжинэ шүү. Эргэн төлөлт болгон дараагийн хүүхдэд боловсролын боломж болж очдог юм. Энэ жил Боловсролын зээлийн сангийн шалгаруулалт явсан. Яг хэдэн хүүхэд шалгарсан бэ? Яг хэдэн хүүхэд. Уг нь хэдэн зуугаараа шалгардаг байсан. Энэ жил хэд шалгарч байгаа. Өмнө нь шалгаруулсан хүүхдүүдийнхээ санхүүжилтийг нь өгч чадаж байна уу. Эргэн төлөлт юу болсон.

**П.Ганзориг:** Батнайрамдал гишүүн маш тодорхой тоонуудтай нэлээн хэдэн асуулт асуусан болохоор ажлын хэсгээс их тодорхой, тодорхой хариулаад явчхаарай. Тоогоор нь Сангийн яам, 4 номерын микрофон, дараа нь Эдийн засгийн яам бэлдэж байгаарай.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж\* гишүүний асуултад хариулъя. Тийм, орлого бол түрүүн нэг гишүүний асуулт дээр гарч байсан. Орлого бол өөрөө уул уурхайн чиглэлтэй орлогууд нэмэгдэж байгаа боловч энэ нь өөрөө нөгөө хуримтлагддаг орлогууд дээр орчихоод байгаа юм. Ирээдүйн өв сан руу ихэнх нь гэсэн үг. АМНАТ-ын орлого. Тэгэхлээр бусад орлого ялангуяа импортын орлого нэлээд буурч байна. Энэ буурч байгаа орлогыг нөгөө талд нь бид нар ТӨК-ийн ноогдол ашгаар нөхөхөөр оруулж ирсэн.

Хоёр дахь нь, энэ нийслэлийг 2 дахин бүсийг нь чангалчихлаа гэж хэлж байна. Нэгдүгээрт, Сэлбэ дэд төвийн энэ жил гарах гүйцэтгэл нь 1.5 их наяд гэж тавиад ч гарах гүйцэтгэл нь 700 байгаад байгаа учраас бид нар 700-гаар нь тавьж өгсөн. Өөрөөр хэлбэл, гарах бодит гүйцэтгэлээр нь гэсэн үг. Тэгэхдээ нийслэл маань өөрөө орон нутгийн төсөв учраас орон нутгийн дансан дахь мөнгийг Сангийн яам шууд татаж авах эрх байхгүй хуулиараа. Тэгэхээр тэр дансандаа үлдэж байгаа. Зарцуулах эрхээр нь авсан. Хоёр дахь нь болохлоор, бид нар нийт зарлага дээр 998 тэрбум төгрөгөөр нэмээд, алдагдлаа -2 хувь дээр аваачсан. Энэ 998 тэрбум төгрөг нэмж байгаа эсэх нь бол дийлэнх нь буюу бараг 95 хувь нь нийслэлийн зарлага гарна гэж бид нар ойлгож байгаа. Нийслэлийн зарлага гарч байгааг нь бид нар бусад хөрөнгө гээд тавьчихсан. Яагаад гэхлээр, нийслэл өөрөө ИТХ-тай учраас ИТХ-аараа хөрөнгө оруулалтаа деталь нэг болгоноор нь батлах учраас би энд тавьж болохгүй болчихоод байгаа юм. Гэхдээ гаргах хэрэгцээ шаардлага нь нийслэл дээр асар өндөр байгаа. Нөгөө яриад байсан 2.8 их наядын дансандаа мөнгөтэй байгаа гэдэг ийм л асуудал болж байна. Баярлалаа.

**П.Ганзориг:** Эдийн засаг хөгжлийн яам хэдэн номер вэ. 8 номерын микрофон.

**Б.Мөнх-Эрдэнэ:** Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ. Миний хувьд энэ шинжлэх ухааны сангийн талаар мэдээлэл байхгүй байна. Уучлаарай. Сая миний авсан мэдээллээр, манай яаман дээр энэ удаагийн тодотголоор шинжлэх ухааны салбарын ажилтнууд, төрийн үйлчилгээний ажилтнуудын цалинг нэмэхээр ийм л тодотголын санал өгөөд Сангийн яаман дээр боогдсон гэж ойлгож байгаа.

**П.Ганзориг:** Сангийн яамнаас хариулах уу? Уг нь энэ Эдийн засаг хөгжлийн яаманд өнгөрсөн жил хууль нь гараад танай дээр энэ Үндэсний шинжлэх ухаан технологийн энэ сан чинь байгуулагдаад ингээд явж байгаа шүү дээ. Харьяалагдаад. Эдийн засаг хөгжлийн яам уг нь хариулах ёстой. Сангийн яамнаас нэмж хариулах уу, хариулах хүн байна уу? Эдийн засаг, хөгжлийн яамны уг нь хариуцаж байгаа, харьяа байгууллагын асуудал яриад байдаг. Батнайрамдал гишүүний асуултад дараа нь бичгээр маш тодорхой хариулт өгөөрэй. Маргааш бэлтгэлтэй ирээд хариулаарай. Өнөөдрийн хувьд би аль болох энэ Ажлын хэсгийн гишүүдийг нэг айхтар шахаж шаардахгүйгээр ойлголтыг нь сайн өгөх зорилгоор мэдээллийг чинь өгүүлэх гээд ингээд яваад байна шүү. Манайхан хойгуур сууж байгаа хүмүүс гарч ороод үзэсгэлэнгийн хуралд оролцож байгаа юм шиг байдалтай, сэлгүүцсэн байдалтай зарим нөхөд ингээд яваад байна шүү. Энэ хуралдаа суугаарай, нэрс нь ирчихсэн байж байгаа. Тэгээд энэ гишүүдийнхээ асуултуудыг сонсоод, хариултуудаа доор нь бэлдээд, тодорхой хариулаад явах ёстой шүү. Сангийн яам нэмэлтээр мэдээлэл өгөхөөр 4 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж\* гишүүний асуултад хариулъя. Үндэсний ШУТС гэж байгаа. Энэ захиалгат шинжлэх ухааны төслүүдээ хэрэгжүүлдэг сан. Энэ сангийнх нь зарлага болохоор анх батлагдахдаа 11.6 тэрбум төгрөг батлагдаад, тодотголоор 11.4 тэрбум төгрөг болоод 200 сая төгрөгөөр буурчихсан байгаа.

**П.Ганзориг:** Боловсролын яам 9 номерын микрофон. Тэгээд маргааш Эдийн засгийн байнгын хороон дээр хариултуудаа бэлдэж ирээд, та бүхэн хариултаа өгөөрэй. Батнайрамдал гишүүний асуултад. 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Ням-Очир. Сая Батнайрамдал гишүүний хэлсэн тоонууд бол ер нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас ерөнхийдөө нийтээр нь хасчихаар Боловсролын зээлийн сангаас 13 орчим тэрбум төгрөг хасагдах ийм тооцоолол хийгдэж байгаа. Сая таны дурдсан тэр Боловсролын ерөнхий газар, БҮТ гэдэг дээр харагдаад байгаа. Энд төсвүүд энэ онд дутуу батлагдсан цалингийн сангийн зөрөөг зохицуулсан гээд. Түүнээс биш зээлийн сангаас татсан мөнгийг шилжүүлж тавьсан асуудал ерөөсөө биш ээ. Харин Боловсролын зээлийн сан болон бусад бүх салбарын төсвийн байгууллагуудыг тодотголын дагуу бууруулах, зориулалт арга хэмжээтэй холбоотой манай салбараас 133 тэрбумд хөрөнгө оруулалт нь ороод 133 тэрбум төгрөг ингэж тодотголоор буурсан байгаа. Энэ жилийн хувьд зээлийн сан дээр.

**П.Ганзориг:** 9 номер гүйцээж хариулъя.

**Т.Ням-Очир:** Энэ жилийн сонгон шалгаруулалтын тухайд Топ 100-гийн сонгон шалгаруулалтад бакалавр дээр 10, магистр дээр 20, доктор дээр нэг хүнийг сонгон шалгаруулаад энэ онд батлагдсан төсөвтөө багтааж сургахаар гэрээ контрактууд байгуулагдсан. Мөн энэ жил нэгэнт эрхээ аваад, урилгаа авсан хүүхдүүд дээр хяналтын тоо гэж гаргаад бакалавр дээр 40, магистр дээр 20 хүүхдийг шалгаруулаад, үүний шаардлагатай эх үүсвэрүүдийг нь судалж шийдвэрлэхээр бид нар Засгийн газрын танилцуулга, тогтоол оруулаад үүн дээрээ шийдэхээр ажиллаад явж байгаа. Эргэн төлөлтийн хувьд энэ жил 33 тэрбумаар төлөвлөгөө тавьж өгсөн. Эхний 6 сарын байдлаар уг нь 6.2 тэрбумын эргэн төлөлт хийгдчихсэн явж байсан.

Тэгээд сая энэ зуны 3 сар 2.5 тэрбумын эргэн төлөлт хийгдээд, одоогоор 9 орчим тэрбум төгрөгийн эргэн төлөлттэй байна. Манай зээлийн сангийн ажлын албаны мэдэгдэж байгаагаар ер нь 15 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийх боломж байна гэсэн ийм тооцоо гаргаж өгсөн байгаа.

**П.Ганзориг:** Батнайрамдал гишүүн тодруулъя.

**О.Батнайрамдал:** Үнэхээр бүсээ чангалж байгаа төсөв юм бол яагаад танай яам, агентлагууд чинь төсвөө нэмээд ороод ирчихсэн бэ гэдгийг л асуугаад байна шүү дээ. Боловсролын газар нь төсвөө 32 хувиар тэлээд ороод ирчихсэн, юу хийх гэж байгаа юм. Боловсролын Ерөнхий газар төсвөө 4.4 тэрбумаар тэлээд ороод ирдэг, юу хийх гэж байгаа юм. Тэр хүүхдийн Боловсролын зээлийн сангийн мөнгийг хасаж байснаас хэдэн хүүхдийн зээлийг өгчхөж болдоггүй юм уу. Энэ жил шалгарсан хүүхдүүд бакалавр 10, магистр 20, доктор хөөрхий ганцхан шалгарч байгаа нь ганц биш шүү дээ. Зөндөө олон хүүхдүүд мундаг явж байгаа. 31 хүүхэд шалгарч чааваас. Яг үнэнийг хэлэхэд үнэхээр чааваас л гэж хэлмээр байна. Хэдэн агентлагуудынхаа төсвийг нэмж ирчхээд, боловсролын зээлийг хасна болохгүй шүү. Энэ дээр би өөрөө зарчмын зөрөөтэй санал гаргаж, та нарын агентлагуудын чинь төсвийг бүгдийг нь Боловсролын зээлийн санал руу оруулна, болохгүй шүү дээ.

**П.Ганзориг:** Боловсролын яам 9 номерын микрофон нэмэлтээр хариулъя.

**Т.Ням-Очир:** Өмнөх жилүүдэд улсын төсвийн байгууллагын төсвийг 9 хувиар бууруулсантай холбоотой 2025 оны төгсгөлийн саруудад санхүүжилт гараагүй, хязгаарлагдсан. Үүнтэй холбоотойгоор энэ байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлс дутуу тавигдсан. Тэгэхээр энэ цалин хөлсний л зөрөө ингэж харагдаж байгаа шүү гэдгийг хэлье. Тэгээд тэрийг салбар дотроо зохицуулж байгаа асуудал байгаа.

**П.Ганзориг:** Батнайрамдал гишүүн тодруулъя.

**О.Батнайрамдал:** Тэгэхээр хэлээд байгаа юм. Боловсролын зээлийн сан бусад сангууд шиг биш байхгүй юу. Маш их зээл хэдэн зуун, тэрбумаар гарчихсан. Та нарын хийж байгаа эргэн төлөлт болгон дахиад хэд хэдэн хүүхдийг гадаад, дотоодод сургах боломж байхгүй юу. Малчдын хүүхдүүдийг сургах боломж, хууль нь бүгд гарчихсан. Журмаа шинэчилж байгаа юм байна. Гэхдээ журмаа шинэчлэхдээ та нар Байнгын хорооны тогтоолтой шүү. Яг энд сууж байгаа гишүүд бүгдээрээ дэмжээд Байнгын хорооны тогтоолыг жилийн өмнө гаргасан. Тэгэхээр шинэ журмыг Боловсрол байнгын хорооны тухайн үедээ гаргасан Байнгын хорооны тогтоолын дагуу батална шүү. Дахиад нэг журам гаргачхаад тэр нь бөөн асуудал болоод үлдэх вий дээ. Эргэн төлөлтөө сайжруул. Эргэн төлөлтийн нэг төгрөг чинь дараа нь дахиад л нэг хүүхдийн боломж болж очих байхгүй юу. Тэр агентлагуудынхаа төсвийг хий илүү оруулж ирдэг. Түүнийг хүлээн зөвшөөрч болохгүй. Тэгээд яах гэж төсөв тодотгож байгаа юм. Тэгвэл яах гэж бодсон юм. Зээлийн сангаас хүүхдийг хасаж байгаа юм.

**П.Ганзориг:** Үг хэллээ Бум-Очир гишүүн асуулт асууя.

**Д.Бум-Очир:** Өдрийн мэнд хүргэе. Хувийн сургуульд төсөв тавьж өгсөн гэдэг ийм маргаан өчигдөр Өргөдлийн байнгын хорооны хурал дээр гарсан. Манай Их Хурлын зарим гишүүд энэ асуудлыг хөндсөн. Тэр лаборатори тоног төхөөрөмж гэсэн

Боловсролын яаман дээр. Үнэхээр тийм төсөв би өнөөдөр нэлээн хайгаад, тэгээд би олсонгүй. Хаана байгаа юм. Манай гишүүд эрх эрх биш оргүй юм яримааргүй юм. Энэ дээр Боловсролын яаманд залруулга юм уу, тодруулга хийгээч, би олоогүй шүү. Тэр 3, 4 тэрбумаар хувийн сургууль дээр тоног төхөөрөмж, лаборатори энэ тэр гэж үнэхээр суулгачихсан байгаа юм бол манай энэ Боловсролын яамныхны буруу болно гэж би ойлгож байгаа. Бараг хууль зөрчсөн үйлдэл болох болов уу гэж бодож байна. Тэгэхээр үүнийгээ маш тодорхой нэг талд нь гаргаач ээ. Би төсвөөс олоогүй учраас лавлаж тодруулж асууж байгаа юм шүү нэгдүгээр зүйл.

Хоёрдугаар зүйл юу вэ гэхээр, улсын сургуулийн хүүхдүүд багтаж ядаад 40-50-иараа сууж байгаа энэ цаг үед, хувийн сургуулийн нөөц бололцоог ашиглан тэнд хүүхдүүдээ оруулъя гэж байгаа нь миний ойлгож байгаагаар буруу биш. Би хүүхдүүдээ 1 ангид 30, 40-өөр нь суулгаж байхын оронд тэнд нэг хувийн сургуулийн нөөц бололцоо, анги дүүргэлт нь бага байгаад, болж байгаа тохиролцоонд хүрч байгаад оруулчихаасай гэж бодож байна. Тэр хүүхдүүдийн өмнөөс бодоход. Тэгэхээр үүнийг би учиргүй буруу үйлдэл биш болов уу гэж бодож байгаа юм. Гэхдээ ингэж зохион байгуулах гэж байгаа нэрээр хувийн сургуулиудад ямар нэгэн байдлаар хувьсах зардлаас бусад хэлбэрээр мөнгө шилжүүлж юм уу, юм болж байгаа бол үүнийг бид яах аргагүй анхаарах ёстой асуудал мөн. Үүнийг Боловсролын яам нэг талд нь гаргаад өгөөч гэдгийг би хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл, яг хувийн сургуулиудтайгаа яаж тохиролцож байгаа юм бэ? Үүнийг жаахан дэлгэрүүлээд тайлбарлаад өгөөч. Өөрөөр хэлбэл, аль нэг улсын сургуулийн хажууд нь нэг хувийн сургууль байлаа. Хүүхдүүд нь багтахгүй боллоо. Тэр хувийн сургуультай тохиролцлоо. Тэгэхээр хэдэн ангийг тийш нь оруулчих юм уу, тэр ширээ сандал нь бэлэн юм уу, тэр ширээ сандлыг нь улсаас Боловсролын яам хангаж өгөх гэж байгаа юм уу. Хувийн сургууль нь ширээ сандалтайгаа багштайгаа, сурах бичигтэйгээ орж ирэх гэж байгаа юм уу эсхүл та нарын тэр маргаан үүсгээд байгаа тэр тавьчихсан байгаа төсөв гэдэг чинь тэр хувийн сургуульд ширээ сандал худалдаж авч өгөх гээд байгаа юм уу? Ийм нэг үл ойлгогдох байдал бий болчихоод, нийгэмд хүмүүс асууж тодруулах шаардлага гараад байна шүү дээ.

Дараагийн нэг зүйл нь, тэр хувийн сургуульд орчихсон хүүхдүүд, хувийн сургууль биш шүү дээ тийм ээ. Улсын сургуульд сурч байгаа хүүхдүүд аль хувийн сургуулийн байгаа анги юм уу? тэр улсын сургуулийн багш нь дагаад очих юм уу, хувийн сургуулийн багш нь заах юм уу? дээр нь хөтөлбөр нь яах юм бэ? Тэр хувийн сургууль чинь өөрийн гэсэн хөтөлбөртэй байж байгаа шүү дээ. Улсын сургуулийнхаа хөтөлбөрөөр явах юм уу, эсхүл тэнд хувийн сургуулийн өөрсдийнх нь боловсруулчихсан байгаа хөтөлбөрийн дагуу явах юм уу? ирэх жил яах вэ. Нөгөө хувийн сургууль чинь уучлаарай манай анги дүүргэлт хэтэрчихсэн учраас энэ хүүхдүүдээ буцаагаад ав гэх үү. Энэ хооронд хүүхдүүд маань шилжих хөдөлгөөн хийгдэх үү гэх мэтчилэн нэлээн дэлгэрэнгүй тайлбар байна. Үүнийг би буруу гэж байгаа юм биш шүү. Энэ зохицуулалт яаж хийгдэж байгаа юм, ямаршуу үйл ажиллагаа зохион байгуулалт явж байгаа юм, ямар хувийн сургуулиуд ингээд эндээс үзэх юм бол улсын сургуулийн ачааллыг үүрэлцье гээд хүсэлтээ өгсөн хувийн сургуулиудын буруу ч юм шиг ийм байдалд орох гээд байна шүү дээ тэр чинь. Ингээд энэ улс орныхоо нөхцөл байдлыг, боловсролынхоо нөхцөл байдлыг ойлгоод чадах мэдэхээрээ тусалъя гэж яваа сургуулиуд байгаа болов уу гэж би ойлгох юм. Тэгэхээр энэ нэг үл ойлголцол тодорхойгүй байдал, үүсээд байгаа нөхцөл байдлыг нэг тодруулж хэлж өгөөч гэж хүсмээр байна.

**П.Ганзориг:** Боловсролын яам, 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Ням-Очир. Сая Байнгын хорооны хурал эхлэхээс өмнө коридорт сэтгүүлчдэд яриа өгсөн. Тэгээд ярьсан яриа нэлээн буруу тийшээ гуйвуулагдаад, ингээд буруу мэдээлэл тарж байгаад харамсалтай байна. Энэ асуултыг асуусанд талархал байна. Бид нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын ачааллыг бууруулах хүрээнд гэрт ойр сургуулиудад хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Сая би өмнөх асуултууд дээр зөвхөн хотхон хороолол байгуулах бага сургуулиудын асуудлыг ярьсан. Нөгөө нэг хувилбар нь төрөлжсөн ахлах сургуулиуд зохион байгуулах асуудал байгаа юм. Энэ хүрээнд Боловсролын яаман дээр ажлын хэсэг гарсан. Ажлын хэсэгт хувийн хэвшилтэй түншилж хамтарч ажиллах, санал боловсруулж, танилцуулах ийм үүрэг чиглэлийг өгсөн. Энэ хүрээнд өөрийн гэсэн байртай, тоног төхөөрөмж нь бүрэн хангагдсан, төрөөс тавьж байгаа бидний шаардлагыг хүлээж авч, хамтарч ажиллах ийм сургуулиудын саналыг нэгтгэж танилцуулах ийм үүрэг чиглэл өгчихсөн. Нийслэлийн боловсролын газраас гаргаж танилцуулсан тэр танилцуулга дотор хувийн хэвшлийн 5 сургуультай хамтарч ажиллах боломж байна гэдэг ийм танилцуулга хийсэн. Яг өнөөдөр 9 сарын 1-ний байдлаар бид нар хувийн хэвшлийн нэг л төрөлжсөн ахлах сургуультай буюу Эрдэм овоо гэдэг сургуультай бид нар хамтарч ажиллаад эхэлчихсэн байгаа. Бусад 4 сургуультай нь бид нар хамтарч ажиллаж эхлээгүй байгаа. Эрдэм Овоо сургуулийн хувьд байр байшин, тоног төхөөрөмж нь 100 хувь хангагдсан. Төрөөс ямар нэгэн хөрөнгө оруулалтад нэг ч төгрөгийн дэмжлэг авахгүй, эрх зүйн хувьд энэ боломж байхгүй. Тийм учраас энэ хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжтэй холбоотой төсвөөс нэг ч хувийн сургуульд төр юм худалдаж авч өгөхгүй гэж ойлгож болно.

Харин бид нар сургууль дээр төрөөс гаргасан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд нийцүүлээд хувьсах зардал дээр нь тэр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар зардал оногдож байгаа юм, тэрний дагуу хувьсах зардал олгох л асуудал яригдаж байгаа юм. Тийм болохоор хувийн хэвшил өөрийнхөө сул орон зайн дээр төртэй хамтраад энэ асуудлуудыг хэлэлцэх ийм зүйл байгаа. Шинэ санаа имперал, нэг нь Грийн юу билээ? сургууль нь байхгүй байна. Энэ нийслэлээс танилцуулсан 5 сургууль энэ байна шүү. Нэг нь Их засаг Кинг гэсэн ийм 4 сургуулийн нэр танилцуулагдсан юм. Энэ дотроос СХД-т ийм сул суудалтай үйл ажиллагаа эхлүүлэх гэж байгаа шинэ байртай сургууль байгаа юм байна. Үүнийг бид нар хүсэлт тавья гээд нийслэл талаасаа тэр Их засаг Кинг сургуульд санал тавигдсан. Энэ сургууль хүлээж аваагүй. Бид нар өөрсдөө менежментээ хийгээд аваад явна гэж байгаа. Нөгөө 3 сургуулийнх нь хүсэлт байж байгаа. Бид нар яг Эрдэм Овоо сургууль шиг төрөөс тавих гэж байгаа шаардлагыг хүлээж аваад, хүүхдүүдээс нэг ч төгрөгийн төлбөр авахгүй. Баталж өгсөн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу төрөлжсөн сургуульд явуулахаар бид хамтарч ажиллая гээд судалгаа үргэлжилж байгаа л гэсэн үг. Тэгэхээр төрөлжсөн ахлах сургуулийн хүрээнд хувийн сургуулиуд дээр баахан тоног төхөөрөмж худалдаж авч өгөөд, баахан мөнгө өгөх асуудал ерөөсөө байхгүй шүү гэдгийг албан ёсоор хэлье.

**П.Ганзориг:** Нарантуяа- нараа гишүүн асуулт асууя.

**М.Нарантуяа-Нара:** Өдрийн мэнд хүргэе. Бүгдээрээ сайн байцгаана уу. Хэд хэдэн асуултууд байна. Тэр нь болохоор зэрэг дөнгөж сая Аубакир сайд цалинтай ээж 50 мянга хөтөлбөрийг нэмэх боломж байхгүй. Жил бүр 64 тэрбум дунджаар

гардаг гэсэн байна. Тэгээд 64 тэрбумыг 50 мянгаар хуваагаад үзэхээр сая 280 мянган ээжүүд болоод байна. Тэгэхээр 280 мянган ээжүүд бараг Монголын нийт эмэгтэйчүүдийн тоо биш шүү. Тэгээд бүх эмэгтэйчүүд бага насны хүүхэдтэй, төрөөд ингээд яваад байдаг юм уу? Би бүүр гайхчихлаа. Өмнө жил судалгаагаар энэ цалинтай ээжүүдийн цалинг 500 мянга болгоход ийм, ийм үзүүлэлттэй, ТӨК-удаас ингэж, ингэж гаргаад 170 тэрбум байхад хангалттай. Бүгдийг нь 500 мянга болгох боломжтой юм байна гэсэн яриа яригдаж байсан шүү дээ. Тэгсэн чинь юу болоод ингээд сая 280 мянган ээжүүд бүгдээрээ авдаг болчхов? Энэ ямар учиртай байна вэ гэдгийг асууя, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Цалинтай ээж хөтөлбөрийг аймаг, сум, орон нутгаар та нарт бүсчлээд дата хөтөлбөр байгаа биз дээ. Тэгэхээр эндээс жишээлбэл, Баян-Өлгий аймагт энэ 64 тэрбумын чинь хэд нь явдаг юм, тэр талаар надад мэдээлэл өгөх хэрэгтэй байна. Тэгээд энэ хүүхэд хамгааллын асуудалд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дорвитой юу ч хийж чадахгүй байсаар байгаад өнөөдрийг хүрсэн. Тэр үнэнийг өнөөдөр энэ нийгэмд болж байгаа зүйл энэ сошиалд ил тод захаасаа зөвхөн мэдэгдэж байгаа нь л гэхэд энэ болж байгаа олон, олон асуудлуудаар баталгаажиж болно. Тэгсэн чинь энэ жил танай яам хэдэн төгрөгийн төсвийг, би та нарын амнаас хэлүүлэх гээд байгаа юм. Хэдэн төгрөгийн төсвийг хүүхэд хамгаалалд зарцуулснаас хэдэн хувийн үр дүнтэй ажиллаж байна. Тэгээд дээрээс нь энд Хүүхэд хамгааллын 108-ын юу гэж байгаа юм. Хүүхдийн тусламжийн 108 үйлчилгээний төв дээр 1 тэрбум төгрөгийн нэмэлт оруулчихсан байж байгаа юм. Тэгсэн мөртөө хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх Түр хамгаалах байран дээрээ 968 сая хасчихсан байгаа юм. Тэгэхээр танай яамны гол зорилго юу юм? Хүүхдээс ирж байгаа дуудлагыг хүлээж аваад рапорт дата ингээд их болгоод, хүүхдүүд олон юманд өртөж байна гэдэг дата мэдээлэл нь чухал юм уу, эсхүл хариу арга хэмжээ авах нь чухал юм уу? Би үүнийг хараад гайхаад асууж байна.

Дээрээс нь энэ Хүүхэд хамгааллын хүүхдийн төлөө сангийн мөнгө гэж байна. Энэ Эрүүл мэндийн яам болон Нийгмийн хамгааллын яамтай хоёулантай нь холбоотой асуудал. Хүүхдийн төлөөх сан гэж би дөнгөж гишүүн болсноосоо хойш энэ мөнгийг юунд зарцуулж байна? Яагаад хүүхдийн эрүүл мэндэд, энэ Монголд эмчлэгдэх боломжгүй өвчлөлд зориулж болохгүй юм бэ гэхэд одоогийн байдлаар 18 тэрбум болсон байна. Энэ журмыг нь өөрчлөхгүй болохгүй байгаа гээд тэгж байсан. Тэгвэл энэ хэдэн төгрөг болсон юм. Энэ журмыг нь өөрчлөх асуудлыг хэзээ хэн шийдэх юм, Улсын Их Хурал шийдэх үү, эсхүл танайх өөрсдөө шийдэх юм уу. Хэрвээ шийдэж болдог бол өөрчилмөөр байна.

Дээрээс нь Эрүүл мэндийн яам тэр эмнэлгийн зөвлөл энэ жилийн хугацаанд 5 тэрбумын гадаадад эмчлэгдэх хүүхдүүдийн зардалд төсөвлөсөн байснаас хэд нь гарчхаад байгаа юм. Дөнгөж сая хамгийн сүүлийн хагалгаандаа 4, 5 сард орсон хүүхэд хагалгааны хагас 50 хувийнхаа зардлыг авч чадахгүй, өнөөдөр ингээд эмчилгээний мөнгө хүрэлцэхгүй байна гээд дахиад хандив гуйгаад явж байна. Ийм, ийм асуудлуудыг шийдэх гэж энэ гадаадад эмчлэх эмчилгээний зардлын танай нэг төсөв байгаа шүү дээ. Энэ сан чинь эдгээрийг шийдэх л гэж байдаг юм шүү.

**П.Ганзориг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 7 номерын микрофон.

**А.Даваажаргал:** Нарантуяа-нараа гишүүний асуултад хариулъя. Нэлээн олон асуултууд байгаа учраас би зарим асуултын хариуг танд бичгээр өгье.

Хүүхдийн мөнгөний хувьд хүүхэд асарч байгаа ээжүүдийн мөнгөний хувьд гэвэл нийтдээ 0-3 нас хүртэлх насны хүүхдээ асарч байгаа 169100 ээж, аавуудад олгогдож байгаа. Тэгээд 1 хүүхдэд 50 мянган төгрөг гэхээр жилийн 78.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод явж байна. Аймгуудаар нь би танд задаргааг нь гаргаад өгье. Яг хүүхэд хамгааллын зардалтай холбоотойгоор энэ Хүүхдийн төлөө сангийн журмыг Засгийн газраас баталж байгаа. Энэ сангийн хөрөнгийг захиран зарцуулах субъект нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хуралдаж шийдвэрээ гаргаж, захиран зарцуулдаг. Хүүхдийн төлөө сангийн журмыг өөрчлөхтэй холбоотой асуудлыг Засгийн газрын хурлаас тогтоолд өөрчлөлт оруулах байдлаар шийдээд явна. Баян-Өлгий аймагт яг хэдэн төгрөг нь хуваарилагдаж байгаа асуудлыг би танд бичгээр гаргаад өгье. Эсвэл манай хүмүүс танд гаргаад танилцуулахад бэлэн байна.

**П.Ганзориг:** Нарантуяа-нараа гишүүн тодруулъя.

**М.Нарантуяа-Нара:** Асуултуудын хариултыг бүгдийг бичгээр авах юм байна гэж ойлгож болох уу. Уг нь энэ маш тодорхой асуудал шүү дээ. Жишээлбэл, хүүхэд хамгааллын салбарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ онд хэдэн төгрөг төсөвлөснөөс, хэдэн төгрөг зарлагадаад, хүүхэд хамгааллыг хэдэн хувиар яаж бодитоор сайжруулсан юм бэ гэдгийг танай дээр уг нь тодорхой баймаар юм. Жил дуусах гэж байна. Бүртгэл нь байх ёстой шүү дээ. Тэгээд тэрийг яагаад хэлэхгүй байгаа юм, нэгд.

Хоёрт, Боловсролын яамнаас асуучихмаар байна. Энэ сургуулийн гал тогоо гэдэг юмыг хуучин нөгөө нэг хувийн хэвшлүүд аваад, хөөрхөн гуанз ажиллуулаад ингээд явдаг байсан. Ингээд сургуулиуд өөрсдөө хариуцдаг болсноос хойш жонхуурсан заваарсан юм болж байна шүү дээ. Багш нар нь өөрсдөө хичээлээ заагаад орж ирээд аяга тавгаа угаагаад, үйлчлэгч нар нь анги танхимаа цэвэрлэж байснаа орж ирж манжин луувангаа арилгаад ингээд сууж байна шүү дээ. Ийм, ийм завхарсан асуудлыг та хэд яаж шийдье гэж ярьсан юм. Уг нь тодорхой хэмжээний хувийн хэвшлүүдэд жоохон ч гэсэн ажлыг нь өгөөд, тэгээд энэ багш нар, үйлчилгээний ажилтнуудыг энэ гал тогоотой хольж.

**П.Ганзориг:** Эхлээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 7 номер дээр хариулъя. Дараа нь Боловсролын яам.

**Даваажаргал:** Хүүхэд хамгааллын зардал дээр 2026 оны хувьд 17.6 тэрбум төгрөг суугдсан байгаа. Энэ зардлаас тодотголоор ямарваа нэгэн зардал огт хасагдаагүй. Байгууллага үндсэн үйл ажиллагаандаа ингээд зарцуулаад явж байгаа. Би нарийвчилсан тоон мэдээллүүдийг би танд бичгээр гаргаад өгье.

**П.Ганзориг:** Боловсролын яам 9 номерын микрофон.

**Т.Ням-Очир:** Нарантуяа-Нараа гишүүний асуултад хариулъя. Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль 2019 онд батлагдсан. Энэ хуулиар Ерөнхий боловсролын сургууль дээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сургууль бие даан явуулахаар ингэж хуульчилсан. Өнгөрсөн хугацаанд тухайн үед түрээсийн гал тогоотой байсан сургуулиудыг тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг нь бэлтгэх, шаардлагатайг батлах энэ процессууд явагдаад, одоо бол сургууль, хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээ, ер нь бие даан явуулах энэ шилжилт дуусах шатдаа орж байгаа. Энд сургуулиуд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй болоод хүний нөөцтэй болж байгаатай холбогдуулаад сургууль дээр

зөвхөн халуун үйлдвэрлэл буюу бэлэн яг хутгахад бэлэн болсон бүтээгдэхүүнүүд ирээд, үүнийг хоол үйлдвэрлэлд ашиглахаар ийм зохицуулалтуудыг энэ жил худалдан авах ажиллагаа юмнуудад хийж байгаа. Өөрөөр хэлбэл, тэр ногоо арилгадаг, мах жижиглэдэг энэ асуудлууд бол цэвэр хувийн хэвшлийнхэн хийхээр ийм зохицуулалтыг бэлэн болгож байгаа гэсэн үг. Тэгэхээр сургууль.

**П.Ганзориг:** Нарантуяа-Нараа гишүүн тодруулъя.

**М.Нарантуяа-Нараа:** Би эндээс асуугаадахъя. Ер нь энэ сургуулиуд өөрсдөө бие дааж хариуцна гэдэг энэ нэгдүгээрт, би маш олон сургуулиудаар явахад багш нарын хамгийн түрүүнд хэлж байсан асуудал гал тогооны асуудал байсан. Энэ дундаа ялангуяа тэнд үйлчилгээний, тогооч, бэлтгэл тогооч, туслах тогоочоор ажиллах хүмүүсийн цалин нь 800 мянга. Гэтэл захын гуанзанд тийм ажил хийж байгаа хүн 1 сая 500-гийн цалинтай. Тэгэхээр тэнд ажилд орох хэн ч байхгүй учраас багш нар өөрсдөө бүх юмаа хийж байсан. Тэгээд одоо бэлтгэл хоол авчрах гэж байгаа юм байна. Энэ нь төрийн шахаа болчихгүй байгаасай л гэж хүсэх байна.

Дээрээс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ жилд хүүхэд хамгааллын салбарт 17 тэрбум төгрөг төсөвлөснөөс, хүүхэд хамгааллын нөхцөл байдал ямар байдалтай явж байгаа вэ гэдгийг Монголын ард түмэн хараасай гэж бодсон учраас би үүнийг тодотгож асуусан юм. Аубакир сайд хэлэх юм байвал нэмээд хэлчихгүй юү.

**П.Ганзориг:** Аубакир сайд нэмж хариулъя.

**Т.Аубакир:** Нарантуяагийн асуултад хариулъя. Энэ Баян-Өлгийн асуудлыг л байн, байн хөндөөд л байх шиг байна. Халамж илүү авчихлаа, олон хүүхэд төрлөө. Баян-Өлгий аймгийн хувьд хүүхдийн мөнгө авдаг 47809 хүүхэд байгаа. Хөвсгөл аймагт 50929, Өвөрхангай аймагт 44 мянган хүүхэд. Жишээлбэл: Төрсөн хүүхдийнхээ тоогоор л хүүхдийн мөнгө хуваарилагдана. Тэжээгчээ алдсаны тэтгэмжийг тэжээгч нь нас барсан хүн л тэтгэмж авдаг. Энэ маань мөн тэжээгчээ алдсантай холбоотой хүүхдүүд Баян-Өлгий аймагт 530 хүүхэд тэжээгчээ алдсан гэж тэтгэмж авч байгаа бол Архангай аймагт 563 хүүхэд, Баян-Өлгий 530, Архангайд 563 гээд ингээд харьцуулъя л даа. Энэ дээр Баян-Өлгий аймагт илүү тэтгэмж, илүү халамж аваад байгаа юм шиг тийм буруу ойлголтыг.

**П.Ганзориг:** Гишүүд дэгээ барина шүү. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгөх үү. Үг хэлэх гишүүд байна уу? Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн, Галбадрах гишүүнийг нэмчхээрэй. Саранчулуун гишүүнийг нэмье. Эрдэнэбат гишүүн үг хэлье.

**С.Эрдэнэбат:** Төсвийн тодотголыг түрүүн би хэлсэн. 2026 оны төсвийн тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ дотор нь анхаарах зүйлүүд байна. Би тухайлбал, төсөв дээр юм арайхийж тавиулдаг. Харамсалтай нь хэрэгжилт байдаггүй. Түрүүн манай Хөдөлмөрийн яам хэллээ. Хэдэн хүний сургалт гээд тэр хуучин арга барилаа өөрчил өө. Түрүү жил яг станцын хувьд ХАБ дээр анхаараарай гээд хэлэхийн завдалгүй, мөнгө тавиагүй, хэрэгжүүлээгүй, тэгээд нийт системийн хэмжээнд 400 орчим сая төгрөг гэлүү дээ. Тэгсэн. Гайтай юм шиг 3 дугаар станцад ХАБ-тай холбоотой 100 тэрбумын асуудал гарч ирээд улсаараа яах гэж ирсэн шүү дээ. Тэгээд энэ их төсвийн хажуугаар зарим хийх ёстой ажлуудыг хийгээрэй. Би олон удаа ярьж байгаа шүү. Олон удаа яриад асуудал тавиад, тэгээд

би хувийн юм ерөөсөө гуйгаагүй нэхээгүй. Энэ ХАБ, эрүүл ахуй, энэ хүүхдүүдийн сургалтын орчин, эрүүл мэндийн салбарын аюулгүй байдал, аялал жуулчлал, малчдын эрүүл мэндийн асуудал гээд олон зүйл тавьсан асуудал дээр хэдүүлээ анхааралтай хандъя.

Ингээд төсвийн тодотгол болоод сан мөнгө нь ихдээд байгаа, хадгалаад байсан ажилгүйдлийн сантай нийллээ гээд ингээд нэг юм руу явчхаад байгаа. Тийм учраас энэ тал дээр анхаараарай. Ямар ч мөнгө тавиад, юу ч хийгээгүй эсхүл хийх гэж байна гээд оны сүүлд баахан худлаа хүн цуглуулж сургалт зөвлөгөөн хийсэн. Би юу хийдгийг нь мэднэ шүү дээ ер нь бол. Тэгэхээр энэ тал дээр та хэдэд удаа дараа хэлсэн учраас энэ Байнгын хороон дээр албан ёсоор хэлчихье. Асуулга тавина, хийсэн ажил болгон дээр чинь. Би асуудал тавина. Энэ дээр би тодотгол үзээд хэлье. Тэтгэвэр тэтгэмжийн хувьд зөв өө. Энэ хүнд байгаа үед бид нар тодотгол хийгээд шийдэх ёстой. Цалин хөлсний хувьд ч гэсэн. Үлдэж байгаа хүмүүс дээрээ бодож үзээрэй. Нөгөө барьцах асуудлыгаа ар араасаа явчих вий гэдэг дээр би анхааруулж хэлмээр байна.

Боловсролын зээлийн сан гээд нэг зүйлийг хэлье. Тэгээд хөдөө гадаа явахаар зээлээ төлж чадахгүй байна, та нар сургалтын төлбөрийн зээл өгөөч гээд миний өрөөгөөр дүүрэн л өргөдөл байна. Жирийн малчин, ажилчны хүн бол тэгээд цалингийн зээл, тэтгэврийн зээл гээд баахан зээл аваад, сургалтын төлбөр төлдөг. эргэн төлөлт байхгүй. Тэр чөлөөлөхийг нь чөлөөлөөд, хөнгөлөхийг нь хөнгөлөөд, төлүүлэхийг нь төлүүлэх гэдэг ийм юман дээрээ анхаараарай. Би та нарт юу гэж хэлэх вэ. Манай боловсролын зээлийн сан гээд би зарим зүйл дээр нь хэлэхэд 400 сая төгрөгөөр, зарим нь ч бараг тэрбум төгрөгөөр гадаад юу авдаг. Тэгэх шаардлага нь байна уу, байхгүй байна уу. Монгол Улсад тийм нэн шаардлагатай байна уу, үгүй байна уу? Түүний оронд ядарсан хэдэн малчдын овоо гайгүй сурдаг хэдэн хүүхдүүдийн сургалтын төлбөрт, нэг хүүхэд сураад тэгээд эргээд төлдөггүй, монголдоо эргэж ирдэггүй энэ дээр нэлээн хатуухан ярихгүй болохгүй байна билээ. Тэгээд энэ тал дээр би жич асуулга тавьчихсан. Нийт 10 мянган багшийг сургана, 2000 багшийг ингэнэ, англи хэлний тэдэн багшийг сургана гэсэн. Миний мэдэхийн одоо энэ чиглэлээр боловсролын ялгаа гээд байгаа чинь тэгээд англи хэлний багш нарыг нь сургаад, хөдөө байгаа сумд байж байгаа, захын хороололд байж байгаа хүүхдүүдийн багш нь ядаж нэг AELTS-ын оноо авчих хэмжээний сургалтыг явуулчих л ёстой байхгүй юу. Тэгээд хэдэн багш орж ирсэн юм. Энэ тал дээр асуулга тавьчихсан байгаа учраас удахгүй Байнгын хороон дээр ярих болов уу гэж бодож байна.

Тэгээд багш, эмч нарын цалин хөлсийг улсын дундажид хүргэнэ гэдэг асуудал яригдсан юм. Би үүнийг бүүр тодруулаад хэлчихье. Жагсаад шууд гэнэт тавиулчихсан юм ерөөсөө биш шүү. Миний мэдэхийн 2021 онд бид нар асуудал тавиад, улсын дундажид багш, эмчээ хүргэе гэдэг дээр бид нар хэлэлцээр хийгээд ингээд явчихсан юм. Тэгэхгүй манай зарим гишүүд чинь бараг жагссанд нь өгөөд байгаа юм шиг бүүр хадуураад явчихлаа. Үгүй шүү, энэ суурь 2 салбар.

**П.Ганзориг:** Чинбүрэн гишүүн үг хэлье.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа дарга аа. Энэ удаагийн төсвийн тодотголтой холбоотой хэдэн зарчмын асуудал хэлнэ ээ. Нэгдүгээрт, төсөв амаргүй байгаа энэ үед ч эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг нэмэгдүүлэхээр бодлого төсөв тусгаж орж ирж байгаад дэмжиж байна аа. Эмч, сувилагч, эрүүл мэндийн

ажилтнуудын цалин зүгээр нэг зардлын асуудал биш шүү. Салбарын хүний нөөцийн тогтоон барих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг хамгаалах үндсэн нөхцөл. Би Эрдэнэбат гишүүнтэй санал нэг байна. Энэ зүгээр нэг жагсаал цуглаантай холбоотой ч асуудал биш шүү. Энэ үндэсний аюулгүй байдалтай ч холбоотой асуудал. Тийм учраас зүгээр нэг жагссан нь цалин нэмэгдүүлж байна гэж ярих нь өрөөсгөл байна шүү. Үүнтэй санал нэг байна. Эрүүл мэндийн сайдаар ажиллаж байхдаа энэ асуудлын тооцоо судалгаа нэлээн хийж, тооцоололтой энэ цалин хөлс нэмэх асуудлыг ярьсан. 2026 оны төсөвт 191 тэрбум төгрөгийн санхүүжилтийн зузаатгал хийсэн. Үүн дээр салбарын санхүүгийн сахилга батыг сайжруулах, үр ашиггүй зардлыг бууруулах, ЭМД-ын сангийн орлого төслийг сайжруулах замаар эх үүсвэр гаргана гэж тооцсон. Өнөөдөр ЭМД-ын сан дээр Эрүүл мэндийн сайдын мэдээлж байгаа 60 гаруй тэрбум төгрөгийн эерэг тэнцэл хэмнэлт бий болж, энэ тодотголоор дахин 91 тэрбум орчим төгрөг нэмж шийдвэрлэх боломж гарч байгаа нь тухайн үед хийсэн тооцоо үндэслэлгүй байгаагүйг харуулж байна. Үүнийг Эрдэнэбаяр дарга ярих хэрэгтэй шүү дээ.

Гэхдээ нэг зүйлийг онцгой анхааруулъя. Цалингийн бодлого хэрэгжихдээ аймгуудын төсвийн захирагчийн ангилалд байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг орхиж болохгүй ээ. Сая Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын хэлж байгаагаар ирэх оны 2 дугаар хагаст ТЭЗҮ ангиллын аймгийн эрүүл мэндийн ажилчдын цалинг нэмнэ гэж хэллээ шүү дээ. Тэгж болохгүй ээ. Энэ дээр Сангийн яам, Эрүүл мэндийн яам онцгой анхаарч, нэмэгдүүлэх арга чарга хай л даа. Энэ чинь тодотгол дээр та хэд 12 тэрбум төгрөг гүйцэтгэлээс бус санхүүжилт авдаг байгууллагуудад өгч болоод байгаа шүү дээ. Тэгээд үүнийгээ анхаар л даа. Энэ төсөвтөө, энэ тодотголтойгоо яагаад оруулж ирэхгүй байгаа юм.

Хоёрдугаарт, нэг эх үүсвэрээс эм худалдан авах асуудлыг маш зөв зохион байгуулах хэрэгтэй шүү. Энэ бол эмийн хүртээмж, үнэ, чанар, эерэг нөлөө үзүүлэх боломжтой механизм. Бид хуулийг 2024 оны 6 сард батлуулсан. Миний байр суурь маш тодорхой. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартайгаа хамтарч ямар эмийг нэг эх үүсвэрээс худалдан авах үндэслэл гаргаж өгөх ёстой. Та нар ингэж хийж байна уу. Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр аа. Эмийн зөвлөлөөрөө батлуулна, дараа нь бүүр 3 жил хүртэл гэрээ хийх эрхийг Эрүүл мэндийн сайдад өгсөн байгаа шүү дээ. Өмнөх процедурын алдааг давтав. Энэ дээр анхаараарай.

Мөн энэ нэг эх үүсвэрийн худалдан авалтын гол зорилго би түрүүн хэлсэн. Энэ олон тендер шалгаруулалтыг дамждаг, үнэ өсдөг тогтолцоог л бууруулах гэж байгаа юм. Гэхдээ хувийн хэвшлийнхэнтэй өрсөлдөөд хийж байгаа ажлын булаа гэсэн үг биш шүү дээ. Хуулийг өөрөө зарчмын зөрөөтэй санал оруулж, батлуулж байсан хүний хувьд үүнийг хатуу хэлчихье ээ.

Дээрээс нь мэдээллээ зөв хэлнэ шүү. Түрүүн юун 185 тэрбум төгрөг 2026 онд суулгасан гээд ярьчихав. Энэ протокол бичээстэй байгаа шүү дээ. Тийм учраас мэдээллүүдээ зөв өгнө шүү. Дээрээс нь цалинг нэг болсонтой холбоотойгоор сар бүрээр хэрхэн нэмэгдсэн талаар надад мэдээлэл бичгээр өгөөрэй. Хэрвээ бид үүнийгээ ингээд явсан, өнөөдөр бид 8,9,10 сар гээд явчих боломж харагдаж байна гэж би бодож байгаа.

Эцэст нь хэлэхэд цалин нэмэх бодлого зөв. Түүний эх үүсвэрийг сахилга бат, үр ашиг, зөв менежментээр бий болгох бодлого ч зөв. Бид одоо энэ ажлыг дутуу

орхилгүй, ялангуяа орон нутгийн эрүүл мэндийн ажилтнуудыг үлдээлгүй бүрэн хэрэгжүүлэх ёстой гэдгийг бүүр дахин, дахин энд энэ индэр дээр хэлье.

**П.Ганзориг:** Ганхүлэг гишүүн үг хэлье.

**М.Ганхүлэг:** Цалин хөлсний нэмэгдлийг үгүйсгээгүй ээ. Дал гэдэг тоо. 70 хувь нэмье гэдэг нь хаанаас гарч ирсэн юм. 50 хувь нэмэх нь ямар үндэслэл байгаа юм. Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаа хүмүүсийг “тэг” хувиар огт нэмэгдүүлэхгүй байна. Яг ямар үндэслэл байгаа юм бэ гэж би ухаж асууж байгаа юм аа. Тэгээд энэ дээрээ хэдүүлээ нэг жоохон ул суурьтай хандаж явахгүй бол яг салбар, салбараар нь авч явсаар байгаад нөгөө нэг цалин хөлсний нэгдсэн бодлогын асуудал маань ингээд орхигдох нь ээ. Энэ дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам манлайллаа үзүүлээч. Тодорхой шийдэл алдаа байгаа бол алдаагаа ингэж засах гэж байна гэдгээ тооцоотой судалгаатайгаар үүнийгээ хариулаад өгөөч л гэж байгаа юм. Тэрнээс Засгийн газраас цалин хөлс нэмэгдүүлье гэдэг саналыг ороод ирвэл Их Хурлын гишүүд бид нар дэмжээд л өгнө. Ингээд нэмэгдүүлээд тодорхой үр дүнгүүд гарахгүй байх эрсдэлүүд байна. Үүнийг сануулахгүй болохгүй байна. Сар болгон нэг хувиар инфляц өсөж байна. Энэ өсөлтийн хурдыг ингээд харах юм бол өнөөдөр 13.8 орчим хувьтай байгаа инфляц жилийн эцэс гэхэд 17, 18, 19 хувь руу орох нь ээ. Арай гэж 20 хувь нэмсэн цалингаа жилийн дотор буцаагаад дүндээ дүн болгоод алах гээд байна. Тийм учраас бид нар судалгаа, тооцооллоо зөв хийж байна уу, үгүй юу гэдэг энэ зүйл дээрээ мэргэжлийн яамдууд маань үнэхээр анхаарч чадаж байна уу. Хамаагүй ээ, бид нар цалин хөлс, тэтгэврийн асуудал дээр уян хатан хандаад, үүнийг нь дэмжээд ингээд явж болж байна. Тэгэхдээ үүнийгээ анхаараарай л гэж байгаа юм. Энэ дээр тодорхой зөв хариултуудыг өнөөдрийг хүртэл өгч чадахгүй, би хариултаа авч чадахгүй л сууж байна. Түүнээс биш багш нартаа, эмч нартаа хайргүйдээ, нэммээргүй байгаадаа энэ асуудлыг яриагүй шүү гэдгийг манайхан ойлгоно биз ээ. Бодлогогүй яваад байгаа нь энэ асуудлын горьг бид бүгдээрээ л хамтдаа амсана.

Засгийн газар тогтворгүй байгаагаас болоод улс төрийн өнцгөөс Засгийн газраа тогтвортойгоор авч үлдэхийн тулд шууд тооцоо үндэслэлгүйгээр би тэдэн хувь нэмнэ, ингэж өөрчилнө гэдэг ийм амлалтууд чинь өөрөө ийм байдалд хүргэхдээ байгаа гэдгийг үнэнээр нь хэлэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд үүнийгээ бид бүхэн яаж засах вэ гэдгээ тодорхой яриад явах ёстой. Ийм л үндсэндээ саналыг хэлээд байгаа юм.

Хоёр дахь үндсэн асуудал нь, төсвийн гүйцэтгэлийн асуудал дээр анхаарахгүй болохгүй байна. Бид бүхэнд өгсөн энэ материал дээрээс харахад 8 сарын 17-ны байдлаар төсвийн гүйцэтгэл 37 хувьтай байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 51 хувийн гүйцэтгэлтэй, Боловсролын яам 46, Соёлын яам 27, Эрүүл мэндийн яам 28 хувийн гүйцэтгэлтэй байна. Тэгэхээр энэ дээр тодорхой дүгнэлт хариултуудыг би бүрэн дүүрэн авч чадсангүй ээ. Дараа, дараагийн хэлэлцүүлгүүд дээр би тодруулна. Өнөөдөр хэмнэж байна, хасаж байна гээд ярьж орж ирж байна. Боловсролын зээлийн сангаас 13 тэрбум төгрөг хасагдсан дээр бид бүхэн анхаарч, харах ёстой байна. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас 5.5 тэрбум төгрөг хасагдсан байна. Боловсролын зээлийн санд хүсэлт өгөхгүй болчихсон юм уу, зээлээр сурах энэ оюутан залуучууд олдохоо болиод бид бүхэн хасаад байгаа юм уу гэдгийг асуугаад байгаа юм. ЖДҮ-лэл, бичил өрхийн энэ үйлдвэрлэлүүдийг хийх хүсэлт ирэхгүй болоод Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 5.5 тэрбум төгрөгөөр хасагдуулаад байгаа юм уу. Тэгээд энэ улсын төсвийн

гүйцэтгэл 8 сарын байдлаар 37 хувьтай байгаа энэ асуудал дээрээ анхаараач гэдэг ийм 2 үндсэн зарчмын саналыг энэ төсвийн хэлэлцүүлэг ярьж байгаатай холбогдолтой хэлээд байгаа юм.

Янз бүрийн процессууд өрнөж байж болно. Тэгэхдээ ажлаа хийх хэрэгтэй байна. Мэргэжлийн судалгаа тооцоололтой, үндэслэлтэйгээр асуудалдаа хандаад, хариуцлагатай ажиллах.

**П.Ганзориг:** Галбадрах гишүүн үг хэлье.

**Ж.Галбадрах:** Дахин өдрийн мэнд хүргэе. Миний хувьд тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэ дотор тэтгэвэр тэтгэмж нэмж байна. Бизнес эрхлэгчдийг дэмжих олон чухал заалтууд шийдэл шийдлүүд орсон байна. Гэхдээ боловсролын салбарт хийж байгаа энэ аливаа шинэчлэлийг нухацтай, судалгаа, тооцоотой, үндэслэлтэй, олон түмнээс асуусан судалгаан дээр үндэслэж хийх ёстой гэдгийг хэлээд байгаа юм. Тэгээд олон гишүүд маань энэ төсвийг их маш сайн анхааралтай тодотголыг уншсан байна. Тэгээд хүмүүс маань саналаа сэдэв сэдвээрээ ярьж байна. Тэгээд бидний хувьд энэ жилийг Боловсролыг дэмжих жил болгосны хүрээнд 28 гишүүн маань нийлээд Боловсролыг дэмжих лобби групп гэдгийг Их Хурал дээр байгуулсан, тэрийг нь би ахалж байгаа. Батсүмбэрэл гишүүн дэд дарга нь байгаа. Тэгээд 7 гишүүн нийлж байгаад нэг ийм асуулга өгсөн байж байгаа. Энх-Амгалан сайдад. Боловсролын шинэчлэлийн талаар гээд 7 багц асуултынхаа хариуг бид нар авсан. Тэгээд хариу нь хангалттай ирээгүй ээ. Бид нар зарим гишүүдээрээ тодруулж, дахин нарийн тоонуудыг авна. Ер нь нарийн тоотой, судалгаатай, тооцоололтой байж бид нар энэ шинэчлэлийг хийнэ. Ялангуяа энэ багш нарын асуудал дээр. Бид нар янз бүрийн тоо асуухад мэдэхгүй байна. Дөнгөж 9 сард эхэлсэн энэ хотхоны бага сургууль энэ тэр гээд асуудлууд зөндөө явж байна шүү дээ. Тэгээд бид нарын энэ багц асуудалд маань юу орсон юм бэ гэвэл, энд сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлаа нэгдүгээрт тавьсан.

Хоёрдугаарт, багшийн тоон болон чанарын хомсдолын асуудлыг тавьсан. Тэр төрөлжсөн ахлах сургууль гэдгийг тавьсан. Надад хэрвээ үг хэлэх цаг маань үлдвэл би тэр төрөлжсөн ахлах сургуулийн талаар хэдэн үг хэлэхийг хүсэж байна. Цахим шилжилт, хүүхдүүдэд өнөө нөтбүүк тараах, хүүхэд бүрийг цахим шилжилтэд оруулах, дэлхийн тренд хаашаа яваад байгаа билээ. Түүний судалгаа нь ямар байгаа юм гэдэг талаас нь асуусан. Аймаг, дүүрэг болгонд Кембрижийн хөтөлбөртэй сургууль байгуулна гэж байна. Мөн ЭЕШ-ын дүн мэдээ, өнөөдөр Монгол Улсын боловсролын чанар ямар байгаа талаар асуусан. Тэгээд бид бүгд үүнийг ингээд асуусны үр дүнд яах вэ гэвэл, үүнийгээ Байнгын хороон дарга байж байна. Байнгын хороон даргадаа энэ асуултаа бичгээр бэлдэж өгч байгаа. Байнгын хороон дээрээ энэ асуулгыг хэлэлцүүлж өгөөч гэдгийг хүсэж байгаа. Тэгээд түүнийг хэлэлцээд гарсны дараа бид нар нэгдсэн чуулганд энэ асуудлаа оруулна. Ингэж боловсролыг анхаарлын төвд авчирч, боловсролд ямар асуудал тулгараад байгаа юм, яг юуг нь эхэлж шийдэх ёстой юм гэдэг тэр эрэмбийг бид нар гаргаад яваад байгаа хэдэн гишүүн байгаа.

Тэгэхээр бид нар нийлээд үүнийгээ оруулаад ингээд явна. Жишээлбэл, би сая хэллээ. Төрөлжсөн ахлах сургуулийн талаар Ням-Очир дарга маань байж байна. Тэр төрөлжсөн ахлах сургууль гэдэг бид өнөөдөр Монгол Улсад юу хамгийн их тулгамдаад байна вэ гэвэл, 9 дүгээр анги суурь боловсролоо төгсөөд, ахлах ангид орохдоо угаасаа сурах чадвар султай, өөрөө сурах хүсэл эрмэлзэл багатай

хүүхдүүд ингээд орж ирээд байгаа. Урьд нь улаан шугам ч юм уу, ТМС ч гэдэг юм уу, ингээд явдаг байсан. Өнөөдөр бид нар тэнд байж байгаа хүүхдийг сурах сонирхолгүй цаашдаа яах вэ. Мал дээр гараад сайн малчин болчхож болно, худалдаанд гараад худалдагч хийж болох, манаач, слесарь хийгээд явчих ийм хүмүүсийг бэлддэг, зориулсан тийм гараад ахлах сургуулийнхаа 3 жилийг мэргэжлийн чиг баримжаатай сураад, хөдөлмөрийн дадал зуршил олж аваад явах чиглэл рүү гаргая гэдэг саналаар би өөрөө энэ төрөлжсөн мэргэжлийн ахлах сургуулийг оруулъя гэж байсан. Энэ концепц маань 180 градус эргэчихсэн явж байх жишээний. Толгой сайтай шилдэг сайн хүүхдүүд дээрээ гүнзгийрсэн анги дээр л ороод явсан байна. Энэ мэт зүйлүүдийгээ бид.

**П.Ганзориг:** Саранчулуун гишүүн үг хэлье.

**О.Саранчулуун:** Өнгөрсөн чуулган дууссаны дараахан би 3 яамны Төрийн нарийн бичгийн дарга нартай холбогдоод, 3 яамаараа нийлж уулзалт хийгээд, салбар дундын асуудал дээр юу юу шийдсэн бэ гэж асуусан. Тэгээд тэр үед эхний удаа асуудлыг сонсоод өнгөрлөө, уулзалт хийсэн гэсэн. Уг нь яамдууд болон холбогдох хүмүүс Төрийн нарийн бичгийн дарга, сайд нар уулзаж байгаа юм чинь тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хүүхдийн хөгжил, асаргаа, сургалт дэмжих асуудлуудаар нэг шийдвэр гаргачихвал болмоор л байсан юм. Тэгээд яах вэ. Ай си эф энэ тэр нь болохгүй нөгөө үнэлгээ нь болохгүй болохоор хойшлогдоод. Тэгээд сая бид нар 8 сард нөгөө ай си эфийнхээ чиглэлээр 3 яамны ийм уулзалт хийсэн. Яах ёстой вэ гэхлээр, 3 яам нийлээд 3 яамны хамтарсан ажлын хэсгээ яаралтай батлуулах хэрэгтэй гэсэн үг. Тэгээд нөгөө зардлаа зөв удирдахын тулд эхлээд зөв хэмжиж, тогтолцоо руугаа орох хэрэгтэй байгаа. Тэр 8 сарын 31-нд уулзсан гэдэг чинь 9 сар гарч байгаа болохоор яамдууд хариугаа өгөөгүй удаж байна. Тэгэхээр үүнийгээ үргэлжлүүлнэ.

Хоёрдугаарт нь, 3 яамаараа хамтраад заавал анхаарах ёстой нэг асуудал байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дээр жишээлбэл нэг ийм заалт байгаа юм. Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэн 5 жил тутамд үндсэн цалинтай тэнцэх 6 сарын тэтгэмж олгохоор заасан гэж байгаа юм. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүд орон нутагт 6 гээд байгаа. Тэнд ажиллаж байгаа эмч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч зэрэг мэргэжилтнүүдийн хувьд хийж байгаа ажил нь эрүүл мэндийн тусламж мөн үү, мөн, сэргээн засалтын чиг үүрэг мөн үү, мөн. Гэхдээ байгууллагын харьяалал нь эрүүл мэндийн салбар биш нийгмийн салбар болчхонгуутаа энэ тэтгэмжийн эрх үүсч, авах тийм боломжгүй болчхож байгаа юм.

Тэгэхээр дараагийн удаа 3 яамаараа дахиад уулзалт хийж, тэр санаачилгаа үргэлжлүүлэхдээ та бүхэн энэ салбар дундын асуудал болоод байгаа сэргээн засахын асуудал дээр хүний нөөцийн бодлого нь яах юм бэ, байгууллагын бүтэц нь яах юм бэ гэдгээ шийдэх хэрэгтэй байна. Тэгэх юм бол одоо энэ төсөв дээр орж ирж байгаа зардлуудыг хараад энэ дээр энэ ажлыг хийх гэж байгаа юм байна. Энэ нь ийм агуулгатай юм байна. Харахад ойлгомжтой болох гээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр та бүхэн зайлшгүй арга хэмжээ аваач ээ. Энэ дээр дараагийн уулзалтаа яаралтай товлох хэрэгтэй. Би нэг хэдэн хүний цалингийн асуудал ерөөсөө яриагүй, энэ тогтолцооны асуудал байгаа. Тэгэхээр намайг сонсож байгаа хүн болгон ойлгож байгаа байх, бид нарт нэг асуудал байгаа юм. Амьжиргааны баталгаажих түвшнээ хэзээ тогтоодог юм.

Халамжийн тухай хуулийг хүлээвэл нэлээн удахаар байна. Угаасаа 72 төрлийн үйлчилгээний чинь 40 хувь нь зөвхөн амь аргацаах төдий хэлбэртэй байгаа. Түүнийг бүгдээрээ мэдэж байгаа. 15-хан хувь нь нийгмийн оролцоог дэмжсэн байгаа. Тэгвэл миний хүлээж байгаагаар халамжийг дэмжсэн Халамжийн тухай хуулиар 15 хувийн нийгмийн оролцооны үйлчилгээ бараг 40 хувь болж өсөж орж ирвэл энэ чинь шинэчлэл байгаа байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү зүйлүүд дээрээ шинэчилнэ гэж үзээд, зарим сайн туршилтын ажлуудаа эхлүүлж баймаар байна. Тэгэхийн тулд 3 яам, энд сууж байгаа 2 Төрийн нарийн бичгийн дарга нар дараагийн уулзалт дээрээ, салбар дундын хүний нөөцийн асуудлыг заавал хэрэгжүүлж хийж уулзалтын сэдвээ болгооч ээ. Тэгэх юм бол бид нар төсвийн удирдлага маань ойлгомжтой болно, тэнд ажиллах хүмүүс нь тогтвортой болно. Тэгэхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн энэ агентлаг, байгууллагуудаар дандаа сонгуулиас сонгуулийн хооронд түр зуур томилогдоод жил болоод л явдаг хүмүүс байна. Тэгээд хүн тогтохгүй байгаад байна, ажиллах хүн олдохгүй байгаад байна. Тэгэхээр чинь энэ хүмүүсийн тэр үйлчилгээ яаж чанартай болох юм. Та нарын энэ зарцуулаад байгаа тэрбум, тэрбум төгрөг чинь үр дүнгүй болж үрэгдээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр яаралтай төсөв элдэв янзын асуудал ярилгүйгээр дахиад 3 яам дараагийн уулзалт товлоод надад хариу өгөөрэй.

Би та нараас мөнгө нэмэх тухай ерөөсөө ярихгүй. Дандаа мөнгөний зардлын зөв хуваарилалтын тухай ярьж байгаа шүү.

**П.Ганзориг:** Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн тодотголудын 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Ингээд төсвийн тодотголын 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг миний бие Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Энэ хуралдаанд оролцож гишүүдийн асуултад хариулж, мэдээлэл өгсөн нийт ажлын хэсгийн гишүүддээ талархал илэрхийлье. Баярлалаа.

16.30 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА